МАСКИРОВКА 1. баг өмсөх, зүсээ хувиргах, үнэн дүрээ нуух; 2. өнгөлөн далдлах арга.

МАСКИРОВОЧНЫЙ далдлах, өнгөлөн далдлах; 2. нуух, далдлах.

МАСЛЕНИЦА шар тосны баяр, (өвлийг үдэх баяр)

МАСЛЕНИЧНЫЙ шар тосны баярын.

МАСЛЕНКА тосны сав, тослуур.

МАСЛЕНОК шар сархиаг.

МАСЛЕННЫЙ тослогдсон.

МАСЛЕН||ЫЙ 1. тостой, тосдосон, тос түрхсэн, тосонд шарсан; ~ блин тосонд шарсан шүүрмэг бин; 2. нялуун, нялганасан нялга нялга гэсэн; ~ голос нялуун дуу; 3. тачаангуй, хуялтай; ~ые глаза тачаангуй харц, хуялтай нүд.

МАСЛ|ИНА 1. тослог мод; 2. тослог жимсгэнэ, чидун жимс.

МАСЛИТЬСЯ тосдох, тос болгох.

МАСЛИЧН||ЫЙ тост; ~ое дерево тослог мод; ~ая ягода тослог жимсгэнэ.

МАСЛ|О 1. тос; сливочное ~ цөцгийн тос; топленое ~ шар тос; сбивать ~ тос бүлэх; намазывать хлеб ~м талханд тос түрхэх; подсолнечное ~ наран цэцгийн тос; касторовое ~ тосон

туулга; ореховое ~ самрын тос; 2. тосон будаг; писать ~м тосон будгаар зурах; подлить ~а в огонь дайран дээр нь давс хийх, улам гааруулах; *идёт как по ~у сэтгэлчлэн бүтэж байна, саад тогтооргүй явж байна.

МАСЛОБОЙНЫЙ тосны, тос бүлдэг; ~ завод тосны завод.

МАСЛОДЕЛ тосны мэргэжилтэн, тосчин.

МАСЛОДЕЛИЕ тос үйлдвэрлэх.

МАСЛОЗАВОД тосны завод.

МАСЛОТОННЫЙ тос хайлуулдаг, тос хайлуулах, тос шахдаг.

МАСЛЯНИСТЫЙ тослог, тосовхи; ~ сыр тослог бяслаг.

МАСЛЯН|ЫЙ 1. тосон тосны, ~ое пятио тосон толбо;

2. тосон, тосон будгаар зурсан; ~ая краска тосон будаг; писать ~ыми красками тосон будгаар зурах.

МАСОН масон, (масонлигийг баримтлагч, масоны байгууллагын гишүүн)

МАСОНСК|ИЙ масоны; ~ая ложа масоны бүлгэм; ~ знак масоны тэмдэг.

МАСС|А I 1. масс, цул; единица ~ы массын нэгж; 2. лаагалдсан эд; фарфоровая ~ шаазангийн лаагалдсан эд; древесная ~ модны лаагалдсан эд (цаас хийдэг хагас бүтээгдэхүүн) 3. дүнгэр, лүглэгэр, сүидэр.

МАСС|А II 1. үй олон, учиргүй их, учиргүй олон; ~ пыли учиргүй их тоос; тратить ~у сил учиргүй их хүч гаргах; 2. олон түмэн, өргөн олон, өргөн түмэн; в ~е ихэнх нь, олонхидоо, ерөнхийдөө, бүхэлдээ.

МАССАЖ барихуй, илбэхүй; лечение ~ем илбэн эмчлэх.

МАССАЖИСТ бариац, илбэн эмчлэгч.

МАССАЖИСТКА бариац эмэгтэй, илбэн эмчлэгч эмэгтэй.

МАССИВ 1. хөвч, шил; горный ~ хөвч уулын шил; 2, хөвч хүлх; лесные ~ы ой хөвч, хүлх ой.

МАССИВНОСТЬ хүдэр том (байх), мантгар (байх), цул (байх), бараатай (байх)

МАССИВН|ЫЙ хүдэр том, мантгар, цул, бараатай; ~ая дверь хүдэр том хаалга; ~ая фигура хүдэр том бие.

МАССИРОВАНИЕ цуглуулах, хуримтлуулах, бөөгнөрүүлэх.

МАССИРОВАННЫЙ хуримталсан, бөөгнөрсөн.

МАССИРОВАТЬ I барих, илбэх, засах; ~ место ушиба няцарсан газрыг барих.

МАССИРОВАТЬ II цуглуулах, хуримтлуулах, бөөгнөрүүлэх.

МАССОВИК олон нийтийн зохион байгуулагч.

МАССОВКА 1. өчүүхэн цуглаан, 2. кинонд туслах тоглогчид.

МАССОВОСТЬ нийтийн чанар, өргөн олныг хамарсан (байх); ~ спорта өргөн олныг хамарсан спорт.

МАССОВ|ЫЙ 1. олон түмний, өргөн олны, өргөн түмний, олон нийтийн; в ~ом масштабе өргөн олноороо; 2. олон түмний, өргөн олны, нийтийн, өргөн олон; 3. олон түмний, олон түмний дунд явуулдаг, өргөн олны; 4. өргөн олон, нийт олон; ~ читатель өргөн олон уншигч.

МАССЫ олон түмэн, өргөн олон, өргөн түмэн, олон.

МАСТАК чадмаг хүн.

МАСТЕР 1. мастер чадварчин; сениный ~ ээлжийн мастер; 2. дархан, -чин; золотых дел ~ алт мөнгөний дархан; сапож-ный ~ гуталчин, часовой ~ цагчин; 3. мастер; ~ спорта спортын мастер; 4. уран мэргэн, чадамгай хүн; он ~ рассказывать ярих хөөрөхдөө чадамгай; * на все руки ~ гартаа дүйтэй хүн, арван хуруу тэгш.

МАСТЕРИТЬ урлах, дархлах.

МАСТЕРИЦА 1. оёдолчин (эмэгтэй); 2. уран эмэгтэй; она ~ вышивать хатгамаллахдаа уран эмэгтэй.

МАСТЕРОВОЙ үйлдвэрийн ажилчин.

МАСТЕРСКАЯ 1. дархны газар, засварын газар; столярная ~ мужааны газар, модны дарханы газар; часовая ~ цагчны

газар, цаг засварын газар; 2. тасаг; инструментальная ~ багаж зэвсгийн тасаг.

МАСТЕРСКИЙ уран чадамгай, чадварлаг; он ~ рисует тэр (хүн) уран зурна.

МАСТЕРСК|ИЙ уран чадамгай чадварлаг; ~ое исполнение симфонии симфони чадамгай хөгжимдөх.

МАСТЕРСТВО 1. дарх; 2. чадвар, уран чадвар; педагогическое ~ багшийн чадвар, сурган хүмүүжүүлэх чадвар.

МАСТИКА 1. давирхайлаг шаваас; 2. (шалны) лавтай тос; 3. гүгэл.

МАСТИТЫЙ алдар гавьяат, хүндэт гавьяат; ~ учёный хүндэт гавьяат эрдэмтэн.

МАСТ|Б 1. зүс, зүсэм; лошадь вороной ~и хар зүсмийн морь; 2. (хөзрийн) өнгө; бубновая ~ дөрвөлжний өнгө; ходить в ~ өнгө тааруулан гарах.

МАСТИТ хөхний үрэвсэл.

МАСШТАБ, 1. хураангуй хэмжээ, хураангуйлсан хэмжээ, масштаб; 2. далайц хэмжээ; в городском ~е хотын хэмжээн дээр; в маленьком ~е бага хэмжээгээр.

МАТ I мад; объявить ~ мад тавих, мадлах; сделать ~ в три хода гурав нүүгээд мадлах (шатарт).

МАТ II сүлжмэл; ~ соломенный сүлжмэл сүрэл.

МАТ III бүдэх, биржгэр.

МАТ IV кричать благим ~ом чадал мэдэн хашгирах.

МАТЕМАТИК 1. тооны ухааны эрдэмтэн, (мэргэжилтэн), математикч; 2. тооны ухааны багш, тооны багш.

МАТЕМАТИКА тооны ухаан, математик; высшая ~ дээд тооны ухаан.

МАТЕМАТИЧЕСК|ИЙ 1. тооны ухааны, математикийн; ~ая задача тооны ухааны бодлого; ~ анализ тооны ухааны задлаг; 2. нарийн нягт; определить что-либо с ~ой точностью юмыг нарийн нягт тодорхойлох.

МАТЕРИАЛ хэрэглэгдэхүүн, (түүхий эд), материал; строительные ~ы барилгын хэрэглэгдэхүүн; 2. хэрэглэгдэхүүн материал, мэдээ; 3. даавуу эд материал.

МАТЕРИАЛИЗМ материализм; исторический ~ түүхэн материализм.

МАТЕРИАЛИСТ I материалист.

МАТЕРИАЛИСТ II ашиг харагч, олз харагч.

МАТЕРИАЛИСТИЧЕСКИЙ материалист.

МАТЕРИАЛИСТИЧНЫЙ ашиг харсан, олз хардаг.

МАТЕРИАЛЬНО эд мөнгөний талаар, эд мөнгөөр; обеспечить ~ эд мөнгөний талаар хангах, эд мөнгөөр хангах.

МАТЕРИАЛН|ЫЙ 1. эд хэрэглэгдэхүүний, эд материалын; ~ые склады эд хэрэглэгдэхүүний агуулах; 2. эд хөрөнгийн, эд мөнгөний.

МАТЕРИК тив эх газар; Африканский ~ Африк тив, Үхэр эдлэгч тив.

МАТЕРИКОВ|ЫЙ тивийн эх газрын; ~ые острова эх газраас тасарсан арлууд; ~ое обледенение эх газрын мөстлөг.

МАТЕРИНСК|ИЙ эхийн; ~ая ласка эхийн энхрийлэл; ~ая любовь эхийн хайр.

МАТЕРИНСТВ|О 1. эх болох; охрана ~а и младенчества эх нялхсыг хамгаалах явдал; 2. эхийн сэтгэл; чувство ~а эхийн сэтгэл.

МАТЕРИ|Я I 1. матери, бод; 2. бодис, матери; строение ~и бодисын бүтэц.

МАТЕРИЯ II бөс даавуу, бөс бараа; шерстяная ~ иоосон даавуу.

МАТЕРЧАТЫЙ бөс, даавуун.

МАТЕРЬ|ЫЙ 1. азарган, мундаг, лут; ~ волк азарган чоно, хашир чоно; ~ дуб мундаг царс мод; 2. дүүрсэн, догбырсон, хашир; ~ бюрократ дүүрсэн хүнд сурталтан.

МАТИЦА дам нуруу.
МАТКА 1. умай сав, хэвтэш; 2. эм охин, эх мал, хээлтэгч мал; *пчелиная* ~ эм зөгий, хатан зөгий.
МАТОВЫЙ 1. бүдэх, бүдэг, цайвгар; *~ая кожа лица* цайвгар арьстай нүүр; 2. бүүдгэр бүдэх; *~ое стекло* бүдэх шил.
МАТОЧНИК 1. хатан зөгийн үүр, эх мал маллагч.
МАТОЧНЫЙ 1. умайн савны, хэвтшийн; 2. эм малын, эх малын, хээлтэгч малын; 3. эх; *~ куст* эх бут; *~ая порода* эх чулуулаг; *~ раствор* эх уусгамал.
МАТРАС дэвсгэр; *пружинный* ~ пүрштэй дэвсгэр.
МАТРАСНЫЙ дэвсгэрийн; *~ая ткань* дэвсгэрийн даавуу, дэвсгэр бүрэх даавуу.
МАТРИАРХАЛЬНЫЙ эхийн эрхт (ёсны); *~ые отношения* эхийн эрхт харьцаа.
МАТРИАРХАТ эхийн эрхт ёс.
МАТРИМОНИАЛЬНЫЙ гэрлэхийн, гэрлэх.
МАТРИЦА үсгийн хэв, матриц.
МАТРИЦИРОВАТЬ үсгийн хэв хийх, матриц хийх.
МАТРОС усан цэрэг.
МАТРОСКА усан цэрэг цамц.
МАТРОССКИЙ усан цэргийн; *~ танец* усан цэргийн бүжиг.
МАТУШКА 1. эх, ээж, 2. авгай, эмээ.
МАТЧ тэмцээн; *шахматный* ~ шахрын тэмцээн.
МАТЬ эх.
МАУЗЕР маузер буу, сэлээдий.
МАХ (дугуй, сонсний) иэг эргэлт, далайлт; * *дать ~у алдаа* хийх, гэнэдэх; *одним ~ом* иэг амьсгаагаар; *с ~у* гэнэт.
МАХАЛОВКА *разг.* зодоон, цохин.
МАХАТЬ 1. даллах, дэвэх, сэвэх, шарвалзуулах; *~ платком* алчуураар даллах; *~ крыльями* жигүүрээ дэвэх; 2. даллах, даллан дохио өгөх; *маши им рукой, чтобы шлн сюда* тэднийг наашаа ир гэж далал.
МАХИНА данхгар юм, лут юм, лужгар юм.
МАХИНАЦИЯ ов, заль мэх, бааш.
МАХНУТЬ 1. даллах, дэвэх; 2. даллан дохио өгөх; 3. харайн гарах, үсрэн гарах; *~ рукой на кого, что* зөнгөө мэдэг гээд орхих, зөнгөөрөө болог гээд орхих.
МАХОВИК эрчлүүр, ээрцэг дугуй.
МАХОВИОЙ *~ое колесо* эрчлүүр ээрцэг дугуй; *~ые перья* урт өд; *~ая сажня* алд.
МАХОМ тэр дорхоно, тэр даруй, агшин зуур.
МАХОРКА мохоор тамхи.
МАХОРОЧНЫЙ мохоорын.
МАХРОВАЯ 1. саглагар, хэлтсэрхэг; *~ая астра* саглагар гэсэр цэцэг; 2. хэтэрхий.
МАХРЫ сэмэрхий.
МАЧЕХА хойт эх.
МАЧТА (онгоцны) сураг, шураг.
МАЧТОВЫЙ сургийн, сураг хийх, *~ лес* сургийн мод.
МАШИНА 1. машин; *паровая* ~ уурын машин; *швейная* ~ оёдлын машин; *~ электронно-вычислительная* цахим тооцон бодох машин 2. машин; *личная* ~ хувийн машин; 3. байгуулалт, зохион байгуулалт.
МАШИНАЛЬНО санамсаргүй, өөрөө мэдэлгүй, аяндаа.
МАШИНАЛЬНЫЙ санамсаргүй (өгсөн), санаанд үгүй (хийсэн), өөрөө мэдэлгүй (хийсэн), аяндаа (болсон); *~ ответ* санамсаргүй өгсөн хариу.
МАШИНИСТ машинч.
МАШИНИСТКА бичээч эмэгтэй.
МАШИНК|А 1. машин; 2. (бичгийн) машин; *печатать на ~е* машинаар цохих.
МАШИННЫЙ машинын, машинаар; *~ое масло* машинын тос.

МАШИНОПИСНЫЙ машиндсан, цохисон, машиндах, машинаар цохих.
МАШИНОПИСЬ машиндах, машинаар цохих.
МАШИНОСТРОЕНИЕ машин бүтээх.
МАШИНОСТРОИТЕЛЬНЫЙ машин бүтээх.
МАЯК гэрэлт цамхаг.
МАЯТНИК дүүжмэг; *часовой* ~ цагийн дүүжмэг.
МАЯТЬСЯ зовох, энэлэх.
МАЯЧИТЬ бөртөлзөх, бөргийх, сүүдийх, сүүдэлзэх.
МГЛА 1. униар, будан, 2. бүрэнхий харанхуй.
МГЛИСТЫЙ униартай, будантай, униар татсан, будан татсан.
МГНОВЕНИЕ агшин зуур; *в одно* ~ агшин зуур; *в ~ ока* нүд ирмэх зуур, нүд цавчих зуур.
МГНОВЕННО агшин зуур, дорхноо, төдхөн гэнэт.
МГНОВЕННЫЙ агшин зуурын, гэнтийн, дорхноо (хийсэн); *~ое состояние* агшин зуур ноцох, дорхноо асах.
МЕБЕЛЬ (гэрийн) тавил, гэрийн хэрэгсэл; *мягкая* ~ (гэрийн) зөөлөн тавил.
МЕБЕЛЬНЫЙ (гэрийн) тавилын, гэрийн хэрэгслийн; *~ магазин* (гэрийн) тавилгын дэлгүүр.
МЕБЕЛЬЩИК (гэрийн) тавилын дархан, (гэрийн) тавилч.
МЕБЛИРОВАННЫЙ (гэрийн) тавилтай, (гэрийн) тавил тавьсан; *~ая квартира* (гэрийн) тавилтай байр.
МЕБЛИРОВАТЬ (гэрийн) тавил тавих.
МЕБЛИРОВКА 1. (гэрийн) тавил тавих; 2. гэрийн тавил.
МЕД 1. бал; *пчелиный* ~ зөгийн бал; *липовый* ~ далдуу модны бал; 2. балын архи; * *твоими бы устами да ~ пить* хэлсэн чинь ерөөл болтугай.
МЕДАЛИСТ медальтан, (дунд сургууль онцсайн төгсөж медаль авсан хүн).
МЕДАЛЬ медаль; * *оборотная сторона* ~и юмны буруу тал, юмны нөгөө тал.
МЕДАЛЬОН хүзүүний гуу.
МЕДВЕДИЦА эм баавгай, охин баавгай, эм хар гөрөөс; *Большая* ~ Долоон өвгөн, Долоон бурхан; *Малая* ~ Алтан мөнгөн шаргууд.
МЕДВЕДЬ 1. баавгай, хар гөрөөс; *бурый* ~ хүрэн баавгай, *белый* ~ цагаан баавгай; 2. баавгай шиг болхи хүн.
МЕДВЕЖАТИНА баавгайн мах.
МЕДВЕЖАТНИК *разг.* сейф ухдаг хулгайч.
МЕДВЕЖИЙ баавгайн, баавгайн арьсан; *~ья лапа* баавгайн савар; *~и берлога* баавгайн ичээ; *~ья шапка* баавгайн арьсан малгай; * *оказать ~ью услугу* тус болох гээд тушаа болох.
МЕДВЕЖОНОК бамбарууш.
МЕДВЯНЫЙ балын үнэртэй, сайхан үнэртэй.
МЕДЕПЛАВИЛЬНЫЙ зэс хайлуулах; *~ая печь* зэс хайлуулах зуух.
МЕДЖИЛИС межлис (Турк, Ираны их хурал).
МЕДИАНА дундаж шугам, медиан.
МЕДИК 1. эмч, 2. эмнэлгийн оюутан.
МЕДИКО-ХИРУРГИЧЕСКИЙ эмнэлэг, мэс заслын.
МЕДИЦИНА анагаах ухаан, (хүн) эмнэлэг; *судебная* ~ шүүхийн эмнэлэг, *экспериментальная* ~ туршлагын эмнэлэг.
МЕДИЦИНСКИЙ анагаах ухааны, эмнэлгийн; *~ факультет* анагаах ухааны факультет; *~ая помощь* эмнэлгийн тусламж; *~ая сестра* эмнэлгийн сувиллагч.
МЕДЛЕННО удаан, алгуур, аажим, аяар, ааль; *писать* ~ удаан бичих; *идти* ~ аяар явах.
МЕДЛЕННОСТЬ удаан (байх), алгуур (байх), аажим (байх).
МЕДЛЕННЫЙ удаан, алгуур, аажим, аяар; *идти ~ым шагом* удаан алхах.

МЕДЛИТЕЛЬНО удаан аажуу, яаралгүй; он ~ **соображает** тэр (хүн) удаан ухаарна.

МЕДЛИТЕЛЬНОСТЬ удаан (хөдлөц), аажуу (явдал), яаралгүй (зан).

МЕДЛИТЕЛЬНЫЙ удаан, аажуу, яаралгүй, хашин хойрго; он **очень** ~ человек тэр их удаан хүн.

МЕДЛИ|ТЬ удах, удаах, удаашрах, удаашруулах, алгуурлах; он ~ л с **ответом** тэр (хүн) хариу өгөлгүй удаав.

МЕДН|ЙЙ зэсийн; ~ая руда зэсийн хүдэр; ~ые деньги зэс мөнгө; зэс зоос; ~ лоб тэиэг толгой (хүн); ~ **век** зэс зэвсгийн үе; ~ **купорос** зэсийн байван.

МЕДОВЫЙ 1. бал, балын, 2. балтай; ~ **прияик** балтай боов; ~ **месяц** бурман сар (гэрлэсэн сар).

МЕДОНОСН|ЙЙ балтай; ~ые **цветы** балтай цэцэг.

МЕДОСМОТР эмчийн үзлэг.

МЕДПОМОЩЬ эмнэлгийн тусламж.

МЕДПУНКТ эмнэлгийн тасаг.

МЕДСЕСТРА эмнэлгийн сувилагч.

МЕДУЗА далайн мөгөөрс, далайн залхаг.

МЕДЬ 1. зэс; **красная** ~ зэс; **жёлтая** ~ гууль; 2. зэс мөнгө, зэс зоос, улаан мөнгө.

МЕДЯК *разг.* зэс мөнгө, зэс зоос, улаан мөнгө.

МЕДЯНИЦА могой гүрвэл.

МЕЖ 1. дундуур, хоорондуур; 2. дунд хооронд; ~ **нами** **возник спор** бидний дунд маргаан гарав; ~ **тем как** тэгэх завсар, тэгэх зуур, тэр хооронд.

МЕЖ|А зааг, хил; **пройти по** ~е заагаар явах; **уничтожить** ~и заагийг устгах.

МЕЖВИДОВ|ОЙ зүйл хоорондын; ~ое **скрещивание** зүйл хоорондоо эвцэлцэх.

МЕЖДОМЕТИЕ аялга үг.

МЕЖДОУСОБИЦА хямралдаан, дотоодын тэмцэл, хоорондын эвдрэл, хямралдах, дотооддоо тэмцэлдэх, хоорондоо эвдрэх.

МЕЖДОУСОБН|ЙЙ хоорондын тэмцлийн; ~ые **войны** хоорондын тэмцэлээс гарсан дайн.

МЕЖДУ 1. дунд, хооронд, завсар; ~ **небом и землей** тэнгэр газрын хооронд; 2. хооронд, завсар хоорондох үе, завсрын үе; 3. хоорондоо; **договориться** ~ **собой** өвөр хоорондоо хэлэлцэн тохиролцох; ~ **нами** **говоря** эиүүхэйдээ хэлэхэд, эндээ гэж хэлэхэд; ~ **прочим а)** юмны далимд, юмны далимаар; б) дашрамд хэлэхэд, далимд хэлэхэд; ~ **тем** тэгэх завсар, тэгэх зуур, тэр үед, гэтэл, тэгж байхад нь; ~ **делом** ажлын завсар; **читать** ~ **строку** бичгийн далд утгыг тааж мэдэх.

МЕЖДУГОРОДНЫЙ хот хоорондын, олон хот хоорондын; ~ **телефон** хот хоорондын телефон утас.

МЕЖДУНАРОДНЫЙ олон улсын (хоорондын), улс түмний; ~ **женский день** олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдөр.

МЕЖДУРЕЧЬЕ хоёр мөрний хоорондох газар.

МЕЖДУРЯДЬЕ далангийн хоорондох зай.

МЕЖДУЦАРСТВИЕ хоёр хааны хоорондох.

МЕЖЕВАНИЕ зааг тавих, зааглах.

МЕЖЕВАТЬ зааг тавих, зааглах; ~ **поля** тариалангийн талбай зааглах.

МЕЖЕВ|ОЙ заагийн; ~ые **столбы** заагийн овоо, шон.

МЕЖЗУБНЫЙ дээд доод шүдний хоорондох авна.

МЕЖНАЦИОНАЛЬНЫЙ олон үндэстний (хоорондын); үндэстэн хоорондын.

МЕЖПЛАНЕТН|ЙЙ олон ертөнцийн хоорондын, ертөнц хоорондох; ~ое **пространство** олон ертөнцийн хоорондох зай, огторгуйн уудам.

МЕЖРЁБЕРНЫЙ хавирган завсрын.

МЕЗДРА 1. шар хальс; 2. арьсын хөрс.

МЕЗОЗОЙСК|ЙЙ мезозойн; ~ая **эра** мезозойн эрин.

МЕКСИКАНЕЦ мексик хүн.

МЕКСИКАНКА мексик эмэгтэй.

МЕКСИКАНСКИЙ мексик, мексикийн.

МЕЛАНХОЛИК 1. гуниг аашт; 2. ноомой хүн.

МЕЛАНХОЛИЧЕСКИЙ уйтгарт (ай), гунигт (ай), бухимдалт (ай).

МЕЛАНХОЛИЯ 1. гуниг ааш; 2. дүнсгэр ааш, гуниг, уйтгар, бухимдал.

МЕЛЁ|ТЬ гүехэн болох, татрах; **во время жары реки** ~ют халуунд гол гүехэн болно.

МЕЛИОРАТИВН|ЙЙ хөрс сайжруулах; ~ые **работы** хөрс сайжруулах ажил.

МЕЛИОРАТОР хөрс сайжруулагч.

МЕЛИОРАЦИОННЫЙ хөрс сайжруулахын.

МЕЛИОРАЦИЯ хөрс сайжруулах, хөрс сайжруулалт.

МЕЛИТЬ цэрдэх, шохойдох.

МЕЛК|ЙЙ 1. жижиг, жижигхэн; ~ие **деньги** жижиг мөнгө, задгай мөнгө; ~ **скот** жижиг мал, бог мал; ~ **песок** нарийн элс; 2. гүехэн; ~ан **река** гүехэн гол; 3. гүехэн, өнгөцхөн; ~ая **пахота** гүехэн хагалах; 4. жижиг; ~ **собственник** жижиг өмчтөн; 5. жижиг сажиг, аар саар; ~ие **интересы** өчүүхэн ашиг сонирхол.

МЕЛКО жижиг; ~ **колоть сахар** ёотон жижиг хагалах; 2. гүе байх, гүехэн байх; **в этом месте реки очень** ~ голын энүүгээр нь их гүехэн; 3. гоён, гүехэн байх.

МЕЛКОБУРЖУАЗНЫЙ жижиг хөрөнгөтний.

МЕЛКОВОДН|ЙЙ гүехэн устай, ус багатай; ~ая **река** гүехэн гол.

МЕЛКОВОДЬЕ ус татрах.

МЕЛКОКАЛИБРЕННЫЙ бага амтай, бага калибертай.

МЕЛКОКРЕСТЬЯНСКИЙ жижиг тариачны.

МЕЛКОЛЕСЬЕ явган ой, тачир ой.

МЕЛКОПОМЕСТН|ЙЙ газар багатай; ~ое **дворянство** газар багатай тайж нар.

МЕЛКОСОБСТВЕННИЧЕСКИЙ жижиг өмчтөний.

МЕЛКОСОПОЧНИК толгод газар.

МЕЛКОТА багачуул, жижиг сажиг юм.

МЕЛКОТОВАРНЫЙ жижиг таваарын.

МЕЛКОШЕРСТНЫЙ ахар үстэй, ноос багатай.

МЕЛОВОЙ цэрд, цэрдийн, цэрдэдсэн, цэрдтэй; ~ **период** цэрдийн галав.

МЕЛОДИКА 1. ая судлал; 2. ая, ая найруулга, яруу ая; ~ **стиха** шүлгийн ая найруулга.

МЕЛОДИЧЕСКИЙ яруу аятай, уянгатай, эгшигтэй.

МЕЛОДИЧНОСТЬ яруу аятай (байх), уянга; ~ **песни** дууны уянга.

МЕЛОДИЧНЫЙ аятай, уянгатай, эгшигт; ~ **голос** яруу хоолой.

МЕЛОДИЯ ая.

МЕЛОДРАМА дуутай жүжиг, эмгэнэл уянгатай жүжиг.

МЕЛОДРАМАТИЧЕСКИЙ дуутай жүжгийн.

МЕЛОДРАМАТИЧНЫЙ дуутай жүжиг шиг, шийний баатар шиг.

МЕЛОМАНИЯ хөгжим шохоорхох, хөгжмийн ин.

МЕЛОЧН|ОЙ I жижиг сажиг юмны, аар саар юмны; ~ая **торговля** жижиг сажиг юмны худалдаа.

МЕЛОЧНОЙ II 1. шалигүй зантай, олхиогүй зантай; 2. шалигүй, ялигүй, өөдгүй.

МЕЛОЧНОСТЬ шалигүй зан, олхиогүй зан, өөдгүй зан.

МЕЛОЧН|ЫЙ 1. шалигүй зантай, базаахгүй зантай, олхиогүй зантай; 2. шалигүй, ялигүй, өөдгүй; ~ые интересы ялигүй эрмэлзэл.

МЕЛОЧ|Ь 1. жижиг сажиг юм, аар саар юм; 2. задгай мөнгө, бутархай мөнгө, жижиг мөнгө; 3. ялимгүй зүйл, ялихгүй юм; не следует размениваться на ~и ялихгүй юмаар хөөцөлдөх хэрэггүй.

МЕЛ|Ь харгиа, хайр, усны гөөхөн.

МЕЛЬКАНИЕ жирс жирс хийх, бүргэлзэх, сүүтэгнэх, гялс гялс хийх.

МЕЛЬКАТЬ 1. жирэв жирэв хийх, жирэгнэх, жирэлзэх, бүргэлзэх, сүүтэгнэх, гялалзах; 2. бүүр түүр санагдах, санаанд орон гарах, бүүр түүр тааварлах.

МЕЛЬКНУ|ТЬ 1. бүүр түүр санагдаад авах, санаанд ороод гарах; эта мысль ~ла у меня в голове энэ бодол миний санаад бүүр түүр ороод гарав.

МЕЛЬКОМ 1. агшин зуур, түр зуур; 2. халти, халти мөлт; взглянуть ~ халти хараад авах; я об этом слышал только ~ би үүний тухай зөвхөн хальт мөлт сонссон.

МЕЛЬНИК тээрэмчин.

МЕЛЬНИЦА тээрэм; водяная ~ усан тээрэм; ветряная ~ салхин тээрэм.

МЕЛЬНИЧНИЙ тээрмийн; ~ жёрнов тээрмийн чулуу.

МЕЛЬХИО|Р пойлоос.

МЕЛЬХИО|РОВЫЙ пойлоосон; ~ нож пойлоосон хутга.

МЕЛЬЧАЙШ|ИЙ хамгийн жижиг, маш жижиг, тун жижиг, маш нарийн; до ~их подробностей маш нарийн юм хүртэл, маш нарийн дэлгэрэнгүй.

МЕЛЬЧАТЬ 1. жижигрэх, жижиг болох; 2. чанараа алдах, яс муудах.

МЕЛЬЧЕ 1. бүр жижиг, бүр нарийн, бүр гөөхөн; 2. бүр геен, гөөхөн.

МЕЛЬЧИТЬ жижиглэх, жижиг болгох, бутлах, бутаргах, үйрүүлэх.

МЕЛЮЗ|Г|А зааз амьтан, гоожуур.

МЕМБРАНА мембран; покровная ~ бүрхүүл мембрана.

МЕМОРАНДУМ меморандум, санамж бичиг.

МЕМОРИАЛ|Н|ЫЙ дурсгалын; ~ая доска дурсгалын самбар.

МЕМУА|Р|Н|ЫЙ дурсгал бичгийн.

МЕМУА|РЫ дурсгал бичиг.

МЕН|А арилжаа, андалдаа, солио; произвести ~у арилжаа хийх, арилжих.

МЕНЕЕ -аас(-ээс, -оос, -өөс) бага, доош, илүүгүй, хүрэхгүй; ие ~ важно бага бус чухал; тем не ~ тэгэвч, юу ч гэсэн; более или ~ их бага аль нэг хэмжээгээр, нх ч бага ч не более, не ~ как их ч бус, бага ч бус яг л.

МЕНЕДЖЕР менежер, захирагч, эрхлэгч, удирдагч.

МЕНЗУ|РКА хэмжүүрт домбо.

МЕНИНГ|ИТ мэнэн өвчин, мэнэнтэх, менингит.

МЕНОВ|Ю|Й арилжааны, андалдааны; ~ая стоимость арилжааны өртөг; ~ая торговля арилжаа, наймаа.

МЕНСТРУАЛ|Н|ЫЙ сарын юмны, биеийн юмны, сарын тэмдгийн; ~ период биеийн юмны үе.

МЕНСТРУАЦИЯ биеийн юм, сарын юм, сарын тэмдэг.

МЕНСТРУИ|РОВАТЬ биеийн юм ирэх, сарын юм үзэгдэх, сарын тэмдэг мэдэгдэх.

МЕНТОВКА разг цагдаагийн машин.

МЕНТОЛ батрашийн тос.

МЕНТОЛОВ|ЫЙ батрашийн тостой; ~ая мазь батрашийн тостой түрхэц.

МЕНЬШЕ 1. -аас(-ээс, -оос, -өөс) бага, 2. бага; в два раза ~ хоёр дахин бага.

МЕНЬШЕВИЗМ меньшевизм,

МЕНЬШЕВИК меньшевик, меньшевизмийг баримтлагч.

МЕНЬШ|ИЙ 1. бага; ~ая часть бага хэсэг нь; 2. бага, отгон; ~ сын отгон хүү.

МЕНЬШ|И|Н|СТВ|О цөөнх; ~ голосов цөөнхийн санал; национальные ~а цөөнх үндэстэн.

МЕНЮ хоолны нэрс, хоолын цэс.

МЕНЯ 1. мний, би, над; ~ не было дома би гэртээ байхгүй байв. 2. намайг; ~ никто не спрашивал? намайг хэн ч асуугаагүй юу?

МЕНЯ|Л|А мөнгө задлагч, мөнгө солигч, ченж.

МЕНЯТЬ 1. арилжих, андалах, солих; ~ книги в библиотеке номын санд ном солих; 2. сэлэх, солих, халах сэлгэх; ~ квартиру байр солих; 3. өөрчлөх, хувилгах, хувьсгах, хувиргах; ~ убеждения үзлээ өөрчлөх, 4. задлах, бутлах, жижиглэх; ~ деньги мөнгө задлах; * ~ кукушку на ястреба морь унаж явснаа илжиг унах, хуцаа ухнаар арилжих.

МЕНЯТЬСЯ 1. арилжих, андалдах, солих; ~ квартирами с кем-либо хүнтэй орон байраа солих; 2. өөрчлөгдөх, хувилах хувьсах, хувирах; погода меняется цаг агаар хувирч байна; ~ в лице царай нь хувьсах; 3. арилжигдах, солигдох, сэлгэгдэх; 4. задлагдах, бутлагдах, жижиглэгдэх.

МЕР|А 1. хэмжүүр; ~ длины уртын хэмжүүр; 2. хэмжээ, хим, хир; чувство ~ы хэмжээ мэдэх; знать ~у хирээ мэдэх; 3. арга хэмжээ, арга явуулага, арга; сверх ~ы, через ~у, ие в ~у хир хэмжээнээс илүү, хирээс хэт, хэтэрхий, дэндүү.

МЕРГЕЛЬ сэвх чулуу, шохойнор, барилт.

МЕРЕЖКА сэмлэн оёх, арьсны ар хээ.

МЕРЕТЬ 1. хиартал үхэх; мрут как мухи батгана шиг хиартал үхнэ; 2. дотор пал хийх; сердце мрет дотор пал пал хийнэ.

МЕРЕЩИТЬСЯ нүдэнд үзэгдэх, харагдах шиг болох.

МЕРЗАВЕЦ шинжгүй хүн, өөдгүй амьтан.

МЕРЗКИЙ бузар булай, бузар муухай, жигшүүртэй, өөдгүй, олиггүй; ~ поступок бузар явдал.

МЕРЗЛОТА цэвдэг; вечная ~ мөнх цэвдэг.

МЕРЗЛ|ЫЙ 1. хөлдүү цэвдэг; ~ая земля хөлдүү газар; 2. хөлдсөн.

МЕРЗНУТЬ 1. даарах, бээрэх, осгох; 2. хөлдөх; вода мерзнет ус хөлдөнө.

МЕРЗОСТ|Ь 1. бузар булай, жигшүүр, шнвшиг; 2. бузар юм, булай юм жигшүүртэй хэрэг; говорить ~н бузар булай юм ярих.

МЕРИДИА|Н уртраг.

МЕРИЛО хэмжүүр.

МЕРИН морь, агт; ~ врёт как сивый ~ хэнэггүй худал хэлэх.

МЕРИНГ|Я бог ойн цагдаа.

МЕРИНОС мирноос хонь.

МЕРИНОСОВ|ЫЙ мирноос, мирноосын; ~ая шерсть мирноосын ноос.

МЕРИТЬ 1. хэмжих, хэмжээ авах; 2. хэмжиж үзэх, тааруулж үзэх, өмсөж үзэх; ~ костюм костюм тааруулж үзэх.

МЕРИТЬСЯ 1. (чадлаа) үзэлцэх; ~ силами с кем-либо хүнтэй хүчээ үзэлцэх; 2. хэмжигдэх.

МЕРК|А 1. хэмжих, хэмжилт; 2. хэмжээ; снить по ~е хэмжээгээр нь оёх; снять ~у хэмжээ авах.

МЕРКАНТИЛ|ИЗМ 1. меркантилизм; 2. хонжоо харах, олзонд шунах.

МЕРКАНТИЛ|Н|ЫЙ 1. меркантилист; 2. хэрэг чавдаг.

МЕРКНУТЬ бүдгэрэх, бүрийх, звёзды меркнул и гаснут од мичид сийрэн сөнөнө.

МЕРКУРИЙ Лхагва, Буд.

МЕРЛУШКА хурганы арьс.

МЕРЛУШКОВ|ЫЙ хурганы арьсан; ~ая шапка хурганы арьсан малгай.

МЕРН|ЫЙ жигд, нэг янзын хэмнэлтэй; идти ~ым шагом жигд алхаагаар алхах; ~ бой часов цагний жнгд цохилт; ~ая речь алгуур яриа.

МЕРОПРИЯТИЕ арга хэмжээ.

МЕРТВЕНН|ЫЙ үхэнгэ, амигүй, зэвхий, үнсэн хөх; ~ая бледность зэвхий цагаан царайтай.

МЕРТВЕ|ГТЬ 1. мэдээгүй болох, бадайрах, хөших; руки ~ют от холода хүйтэнд гар бээрч мэдээгүй болно; 2. бэгтрэх, зөвхйрэх; ~ от страха айж бэгтрэх.

МЕРТВЕЦ үхсэн хүн, үхдэл, хүүр.

МЕРТВЕЦКИ ~ пьян ухаан алдтал согтсон, шал согтуу, тас компанийн захирал.

МЕРТВЕЧИНА 1. зовлого, үхдэл, үхсэн малын мах; 2. үхээнц юм.

МЕРТВО амигүй, элэн хулин.

МЕРТВОРОЖДЕННЫЙ амьгүй төрсөн.

МЕРТВ|ЫЙ 1. үхсэн, нас нөгчсөн; 2. анир чимээгүй, элин хулин, хөл татарсан, хөл үймээнгүй; ~ые уллицы города эль хуль гудамж; ~ сезон хөл татарсан үе, хөл үймээнгүй үе; 3. бүтэхгүй, биелэгдэхгүй; ~ое дело бүтэхгүй хэрэг; ~ая тишина чив чимээгүй; ~ая природа амьгүй байгаль; ~ час амралтын цаг; ~ инвентарь үл хөдлөх эд хогшил; ~ капитал үхмэл хөрөнгө; ~ язык мөхсөн хэл; ~ая точка а) сөнөмөл цэг; (механизмын бүх хэсгүүдийн агшин зуур тэнцүүртэй болох үе); б) хөдөлгөөнгүй байдал; ~ая петля годройтох; ~ая зыбь дөлгөөн долгио; спать ~ым сном үхсэн мэт унтах; ~ волос ямаан үс.

МЕРЦАНИЕ сүүмэлзэх, гялбалзах.

МЕРЦА|ГТЬ сүүмэлзэх, мяралзах, гялбалзах гялан гялан гэх; **вдали** ~л огонёк алсад гал гялан гялан гэв; **звёзды м**~ют од мяралзана.

МЕСИВО 1. зуурмаг; 2. холио бантан.

МЕСЯЛКА холиур, зууруул.

МЕСЯЛЬНЫЙ зуурах, зуурдаг, хутгах, хутгадаг, холих, хольдог; ~ чан зуурах ган.

МЕСИТЬ зуурах, хутгах, холих; ~ тесто гурил зуурах; ~ грязь шавар дундуур туучих.

МЕСТАМИ зарим газар, энд тэнд, ов тов, заримдаа, хаяа.

МЕСТЕЧКО I байр суурь, газар; **тёплое** ~ аятайхан ажил.

МЕСТЕЧКО II орон газар, суурин (газар)

МЕСТЯ 1. шүүрдэх, туужуудах, хамах; 2. хийсгэх, бужигнуулах, бургиулах, дэгдээх; **ветер метёт пыль** салхи тоос бужигнуулна; 3. шуурах, шуургалах.

МЕСТКОМ (*местный комитет профсоюзной организаций*) албан байгууллагын үйлдвэрчний хороо.

МЕСТНИЧЕСТВО 1. зэрэг хэргэмийг харгалзан алба хаах; 2. явцуу нутгийнхаа ашгийг хамгаалах.

МЕСТНОСТЬ 1. газар орон; **пересечённая** ~ бартаатай газар; 2. нутаг, газар; **дачная** ~ зуслангийн газар.

МЕСТН|ЫЙ 1. нутгийн, орон нутгийн; ~ **уроженец** нутгийн хүн; ~ая порода скота нутгийн үүлдрийн мал; 2. нэг газрын, хэсэгхэн газрын, нэг газар гарсан, хэсэгхэн газар хийсэн; ~ **наркоз** хэсэг газрыг мэдээ алдуулах; ~ое **воспаление** нэг газрын үрэвсэл.

МЕСТ|Ю 1. газар байр, суурь, суудал; **занять своё** ~ байраа эзлэх; **рабочее** ~ ажлын газар; **положить на** ~ байранд нь тавих; **но** ~ам байр байрандаа; 2. газар нутаг; ~ **рождения** төрсөн газар, төрсөн нутаг; **глухое** ~ бөглүү газар; 3. зай завсар, чөлөө газар; **здесь много** ~а энд зай их байна; **нет** ~а зайгүй байна; 4. хөдөө, хөдөө нутаг, орон нутаг, нутаг;

власть на ~ах (орон) нутгийн захиргаа; 5. газар, хэсэг; **это самое сильное** ~ **в пьесе** энэ бол уул жүжгийн хамгийн сайн газар нь юм; 6. хэсэг юм, ширхэг юм; **в багаже два** ~а хоёр хэсэг тээш; 7. алба, албан тушаал, орон тоо; **доходное** ~ ашигтай алба, олзтой албан тушаал; **больвое** ~ эмзэг тал, эмзэг асуудал; **иметь** ~ болох, гарах, тохиолдох; * **общее** ~ улиг болсон зүйл; ~ **заключеннв** хорих газар, шорон; ~а **не находить себе орох** газраа олж ядах; **на** ~е **преступления** (поймать, заставить) халуун мөр дээр нь барих; **ни с** ~а! та бүү хөдөл!; **поставить на** ~ хирий нь мэдүүлэх, тамиры нь таниулах, хнрээ мэд гэх; **знать своё** ~ хнр хэмжээгээ мэдэх; **до** ~а хүрэх газар хүртэл, очих газар хүртэл; **к** ~у зол болж, завшаан болж, таарч, зохиж; **на** ~е **кого-либо** хүний оронд; **не должно быть** ~а зохихгүй, таарахгүй; **узкое** ~, **слабое** ~ сул тал.

МЕСТОЖИТЕЛЬСТВО оршин суух газар, суудаг газар, суурин нутаг.

МЕСТОИМЕНИЕ төлөөний үг; **личное** ~ биеийн төлөөний үг; **указательное** ~ заах төлөөний үг; **вопросительное** ~ асуух төлөөний үг; **относительное** ~ харьцангуй төлөөний үг.

МЕСТОИМЕННЫЙ төлөөний үгийн, төлөөний үгийн шинжит, ~ **афикс** төлөөний үгийн шинжит залгавар.

МЕСТОНАХОЖДЕНИЕ орших газар, байрласан газар, байр.

МЕСТОПОЛОЖЕНИЕ байгаа газар.

МЕСТОПРЕБЫВАНИЕ орших газар, суудаг газар, байран нутаг.

МЕСТОРОЖДЕНИЕ 1. төрсөн газар; 2. орд; ~ **нефти** нефтийн орд.

МЕСТЬ өшөө хонзон.

МЕСЯЦ 1. сар; ~ **тому назад** нэг сарын өмнө; 2. сар; **молодой** ~ шинэ сар, шинийн сар, сарын шинэ.

МЕСЯЧНИК сар.

МЕСЯЧНЫЙ 1. сарын, нэг сарын, сартай, нэг сартай; ~ **отпуск** нэг сарын амралт; 2. сарын юм, сарын тэмдэг.

МЕТАБОЛИЗМ бодисын солилцоо.

МЕТАЛЛ төмөрлөг; **чёрные** ~ы хар төмөрлөг; **цветные** ~ы өнгөт төмөрлөг; **благородные** (драгоценные) ~ы эрдэнийн (үнэт) төмөрлөг; **лёгкие** ~ы хөнгөн төмөрлөг; **тяжёлые** ~ы хүнд төмөрлөг.

МЕТАЛЛИСТ 1. төмөрлөгч; 2. металл рок шүтэн бишрэгч.

МЕТАЛЛИЧЕСКИЙ 1. төмөрлөг, төмөрлөгөөр хийсэн; 2. төмөрлөгийн ~ **звон** төмөрлөгийн дуу; 3. хахир; ~ **голос** хахир хоолой.

МЕТАЛЛОВИДНЫЙ төмөрлөг шиг, төмөрлөгөрхүү, төмөрлөгөрхөг.

МЕТАЛЛОГРАФИЯ төмөрлөгийн зүй, төмөрлөгийн судлал.

МЕТАЛЛОИД төмөрлөг бус.

МЕТАЛЛОНОСНЫЙ төмөрлөгтэй; ~ **пласт** төмөрлөгтэй давхрага.

МЕТАЛЛООБРАБАТЫВАЮЩИЙ төмөрлөг боловсруулах, төмөрлөг боловсруулдаг, ~ая **промышленность** төмөрлөг боловсруулах үйлдвэр.

МЕТАЛЛОЦАВильный төмөрлөг хайлуулах, төмөрлөг хайлуулдаг; ~ **завод** төмөрлөг хайлуулах завод.

МЕТАЛЛОПРОКАТНЫЙ төмөрлөг цувих, цувимал төмөрлөгийн; ~ **завод** төмөрлөг цувих завод.

МЕТАЛЛОПРОМЫШЛЕННОСТЬ төмөрлөгийн үйлдвэр.

МЕТАЛЛОПРОМЫШЛЕННЫЙ төмөрлөгийн үйлдвэрийн, төмөрлөгийн үйлдвэртэй, ~ **район** төмөрлөгийн үйлдвэртэй газар.

МЕТАЛЛОРЕЖУЩИЙ төмөрлөг зүсдэг, төмөрлөг огтолдог.

МЕТАЛЛОХИМИЯ төмөрлөгийн хими.

МЕТАЛЛУРГ төмөрлөгийн мэргэжилтэн, металлургич.

МЕТАЛЛУРГИЧЕСКИЙ төмөрлөг боловсруулах, төмөрлөг боловсруулдаг, металлургийн; ~ **заяод** төмөрлөг боловсруулах үйлдвэр.

МЕТАЛЛУРГИЯ төмөрлөг боловсруулах үйлдвэр, металлурги; **чёрная** ~ хар төмөрлөг боловсруулах үйлдвэр.

МЕТАМОРФОЗА метаморфоз, хувирлах.

МЕТАН намгийн хий.

МЕТАНИЕ 1. шидэх, чулууудах, харвах, хаях, орхих; ~ **копья** жад шидэх; 2. хаях орхих; ~ **икры рыба**н загас түрс орхих.

МЕТАПЛАЗИЯ хувирал.

МЕТАСТАЯ үсэрхийлэх

МЕТАТЕЛЬ шидэгч, харвагч.

МЕТАТЕЛЬНЫЙ шидэх, чулууудах, харвах; ~**ое** **оружие** харвадаг зэвсэг, шидэх зэвсэг.

МЕТАТЬ I 1. шидэх, чулууудах, харвах, хаях, орхих; ~ **копья** жад шидэх; ~ **жребий** шавга орхих; 2. хуваах; ~ **сено** өвс хураах, цомоглох.

МЕТАТЬ II хаях, орхих; **рыба мечет** **икру** загас түрс хаях байна.

МЕТАТЬ III шидэх, ~ **петли** а) товчны нүх хэрэх; б) булгах.

МЕТАТЬСЯ 1. хөрвөх, эргэж хөрвөх; **всю ночь** **больной** **метался** в бреду өвчтөн шөнө гуж дэмийрэн эргэж хөрвөх; 2. ийш тийш гүйх; 3. самгардах, бачимдах, ~ **как угорелый** ухаан алдан самгардах.

МЕТАФИЗИК метафизикч.

МЕТАФИЗИКА метафизик.

МЕТАФИЗИЧЕСКИЙ метафизик, метафизикийн.

МЕТАФОРА зүйрлэл.

МЕТАФОРЫЧЕСКИЙ 1. зүйрлэсэн, зүйрлэн хэлсэн, зүйрлэлийн; 2. зүйрлэл ихтэй.

МЕТАФОРЫЧНЫЙ зүйрлэл ихтэй, зүйрлэл олонтой; ~ **стиль** зүйрлэл ихтэй, найруулга.

МЕТЕЛИЦА шуурга, цасан шуурга.

МЕТЕЛКА 1. шүүр, туужуу, хамуур, гүвүүр, (цэцгийн) шүхэр.

МЕТЕЛЬ цасан шуурга.

МЕТЕОР 1. солир, од харвах; 2. хоромхон зуурын юм, гялс гээд өнгөрөх юм, солир мэт өнгөрөх юм.

МЕТЕОРИТ солир.

МЕТЕОРИТНЫЙ солирын.

МЕТЕОРОЛОГ цаг уур судлагч, цаг уурын мэргэжилтэн.

МЕТЕОРОЛОГИЧЕСКИЙ цаг уурын; ~ **прибор** цаг уурын багаж.

МЕТЕОРОЛОГИЯ цаг уурын судлал.

МЕТЕОРИЗМ хий дүүрэх, унгах өвчин.

МЕТИС эрлийз, балдир.

МЕТИТЬ I тэмдэглэх, тэмдэг тавих.

МЕТИТЬ II 1. шагаах; 2. санаа тавих, санаархах, эрмэлзэх.

МЕТИТЬСЯ шагаах.

МЕТКА тэмдэг, тамга.

МЕТК[И]Й 1. мэргэн; ~ **стрелок** мэргэн бууч; 2. мэргэн, оновчтой, хурц ~**ое** **название** оновчтой нэр.

МЕТКОСТЬ 1. мэргэн (тусай); ~ **выстрела** мэргэн буудах; 2. мэргэн (үг), оновчтой (хэллэг), хурц (үг); ~ **сравнения** мэргэн харшуулах, оновчтой зүйрлэх.

МЕТЛА шүүр, туужуу, хамуур.

МЕТНУТЬ шидээд авах, чулууудаж орхих, харавчихах.

МЕТОД арга, арга барил; **передовой** ~ тэргүүний арга; ~ **антисептический** үржил эсэргүүцэх арга; ~ **диагностическая** оношлох арга.

МЕТОДИКА арга зүй, сургах арга, заах арга, бнелүүлэх арга; ~ **исследования** шинжлэлийн арга зүй.

МЕТОДИСТ заах аргын мэргэжилтэн, заах арга зүйч.

МЕТОДИЧЕСКИЙ 1. арга зүйн; ~ **приём** арга барил; 2. хатуу эрэмбэтэй; ~**ое** **исследование** **явления** олон үзэгдлийг хатуу эрэмбэтэй судлах.

МЕТОДИЧНОСТЬ хатуу эрэмбэтэй (хийх); ~ **работы** хатуу эрэмбэтэй ажиллах.

МЕТОДИЧНЫЙ хатуу эрэмбэтэй.

МЕТОДОЛОГ арга судлалч.

МЕТОДОЛОГИЧЕСКИЙ арга судлалын.

МЕТОДОЛОГИЯ арга судлал.

МЕТОНИМИЯ төлөөлөл.

МЕТР I метр.

МЕТР II метр хэмжээ; ~ **стиха** шүлгийн метр хэмжээ.

МЕТРАЖ хэмжээ; ~ **комнаты** тасалгааны хэмжээ.

МЕТРИКА I метр хэмнэл, метрик.

МЕТРИКА II төрсний гэрчилгээ.

МЕТРИЧЕСКИЙ I метр хэмнэл, метрик; ~**ая** **система** метрийн тогтолцоо.

МЕТРИЧЕСКИЙ II метр хэмнэлийн, метрик, метр хэмнэлтэй.

МЕТРИЧЕСКИЙ III төрөгсдийн; ~**ое** **свидетельство** төрөгсдийн гэрчилгээ; ~**ая** **княга** төрөгсдийн бүртгэл.

МЕТРО метро.

МЕТРОЛОГ (жин) хэмжүүрийн мэргэжилтэн.

МЕТРОЛОГИЯ (жин) хэмжүүрийн ухаан, (жин) хэмжүүрийн судлал.

МЕТРОНОМ хурд хэмжүүр.

МЕТРОПОЛИТЕН метрополитен.

МЕТРОПОЛИЯ эзэн улс, колоннт улс, метрополн.

МЕТРОСКОПИЯ сав дурандах.

МЕХ I 1. арьс, ангийн арьс, ангийн үс, нэхий; **лясий** ~ үнэгний арьс; **на** ~у үстэй, арьсан дотортой; 2. ангийн арьсан хувцас, ангийн үсээр хийсэн хувцас; **в дорогах** ~**ах** үнэтэй ангийн үсээр хийсэн хувцастай; **на рыбьем** ~у дулаан барихгүй.

МЕХ II хөөрөг; **кузнечный** ~ төмөрчний хөөрөг; 2. тулам; ~ **для вина** дарсны тулам.

МЕХАНИЗАТОР механикжуулагч, оньсжуулагч.

МЕХАНИЗАТОРСКИЙ механикжуулагчийн, оньсжуулагчийн.

МЕХАНИЗАЦИЯ механикжуулах, механикжуулалт; ~ **сельского хозяйства** хөдөө аж ахуйг механикжуулах.

МЕХАНИЗИРОВАННЫЙ механикжсан, механикжуулагдсан.

МЕХАНИЗИРОВАТЬ механикжуулах, оньсжуулах.

МЕХАНИЗМ 1. механизм, оньс; ~ **часов** цагийн оньс; ~ **высшей нервной деятельности** мэдрэлийн дээд үйлийн механизм; ~ **защитный** хамгаалах механизм; **подъемный** ~ өргөх механизм; 2. тогтолцоо, байгууламж; **государственный** ~ төрийн тогтолцоо.

МЕХАНИК механикч.

МЕХАНИКА 1. механик; **теоретическая** ~ онолын механик; 2. оньс; **хитрая** ~ ухаан гаргаж хийсэн оньс.

МЕХАНИСТИЧЕСКИЙ механик суртлын, механик үзэлт.

МЕХАНИЧЕСКИ утгы нь ойлголгүй, аяндаа, зөндөө; ~ **запомнить что-либо** юмыг утгы нь ойлголгүй тогтоох.

МЕХАНИЧЕСКИЙ 1. механизмын, оньсны, механизмтай, оньстой; 2. механик, механикийн; ~**не** **законы** механикийн хууль; 3. аяндаа (болдог), зөндөө (болдог), утгыг нь ойлголгүй; ~**ое** **движение** механик хөдөлгөөн.

МЕХАНИЧНЫЙ аяндаа (болдог), утгыг ойлголгүй.

МЕХАНОРЕЦЕПТНОЕ механик авуур.

МЕХОВОЙ 1. арьсан, ангийн үсээр хийсэн, үстэй нэхий, хөдсөн; ~ **воротник** үстэй зах; 2. ангийн үсний, арьс үсний; ~ **магазин** ангийн үсний дэлгүүр.

МЕХОВЩИК 1. арьс үсний мэргэжилтэн; 2. арьс үсний худалдаачин, ангийн үсний наймаачин.

МЕЦЕНАТ шинжлэх ухаан урлагийн ивээгч, меценат.
МЕЦЕНАТСТВО шинжлэх ухаан урлагийг ивээх, меценатчилах.
МЕЦЦО-СОПРАНО цөлдөн хоолой.
МЕЧ илд, сэлэм; **обнажить** ~ илдээ сугалах; **предать огню** н ~ у гал мэсний аюул учруулах; **поднять** ~ дайн зарлах.
МЕЧЕНОСЕЦ 1. илдэт цэрэг; 2. илдтэн.
МЕЧЕНЫЙ тэмдэгтэй, тамгатай.
МЕЧЕТЬ лалын сүм, масчид.
МЕЧТА санал хүсэл, санаа мөрөөдөл, хүслэн; **сокровенная** ~ дотроо хадгалж явсан хүсэл; **осуществлённая** ~ биелсэн хүсэл; **стать голубой мечтой** арилсан хорвоо болох.
МЕЧТАНИЕ 1. бодол болох, санаа болох, хүслэн болох; 2. хүслэн **предаваться** ~ м хүслэн болох.
МЕЧТАТЕЛЬ бодол бологч, бодолхийлэгч.
МЕЧТАТЕЛЬНОСТЬ бодол болох явдал, хүслэн болох явдал.
МЕЧТАТЕЛЬНЫЙ бодол болсон, хүслэн болсон, хүслэн бологч; ~ **взгляд** бодол болсон харц.
МЕЧТАТЬ хүслэн болох, бодол болох.
МЕШАЛКА хутгуур, бүлүүр.
МЕШАНИКА холион бантан.
МЕША|ТЬ I саад болох, үймүүлэх, тойв болох; **не ~йте мне, работайте!** ажилд минь бүү саад хий!; **не ~ет, не ~ло** бы зүгээрсэн, гэмгүйсэн.
МЕШАТЬ II 1. хутгах; ~ **чай ложечкой** цай халбагаар хутгах; 2. хольж хутгах, холих, хийж зуурах; ~ **глину с песком** шаварт элс хийж зуурах; 3. ялгахгүй хутгах, андуурах.
МЕША|ТЬСЯ I саад болох, бөртөгнөх; **не ~йся под** ногам хөл доогуур битгий бөртөгнөөд бай; 2. оролцох, хутгалдах; **в~ в чужие дела** хүний (бусдын) хэрэгт оролцох.
МЕШКА|ТЬ новшрох, мунгинах, удаацрах; **он ~л с отъездом** явах гээд мунгинаж байв.
МЕШКОВАТЫЙ хэлхгэр, халхгар, хүлхгэр; ~ **костюм** хэлхгэр хувцас.
МЕШКОВИНА шуудайн эд.
МЕШКОТНЫЙ новшруу, мунгинуу, удаан.
МЕШОК шуудай, хүүдий гаар, уут; ~ **мукн** шуудай гурил; ~ **грыневой** ивэрхийний уут; **костюм сидит на нём** мешком костюм нь халхгар байна.
МЕШОЧЕК бяцхан хүүдий, бяцхан уут.
МЕЩАНИН бэртэгчин.
МЕЩАНКА бэртэгчин эмэгтэй.
МЕЩАНСКИЙ бэртэгчин, бэртэгчний.
МЕЩАНСТВО бэртэгчин үзэл, явцуу үзэл.
МЗДА 1. төлөөс, шан; 2. хээл хахууль.
МИАЗМЫ бугшсан үнэр, хортой уур.
МИАЛЬГИЯ булчин өвдөх.
МИГ в один ~, на один ~ агшин зуур.
МИГАНЕ 1. цавчих, ирмэх, анивалзах, цавчганах; ~ **глаз** нүд цавчих; 2. гялав, гялав хийх, гялбалзах, сүүмэлзэх; ~ **звёзд** од гялбалзах.
МИГ|ТЬ 1. цавчлах, цавчрах, ирмэх, цавчганах, анивалзах; 2. ирмэх; 3. гялав гялав гэх, гялбалзах, сүүмэлзэх; **свеча ~ет** лаа сүүмэлзэнэ.
МИГНУ|ТЬ 1. ирмэх, нүд цавчих, анив гэх; ~ **глазом** нүд анив гэх; 2. ирмэх; 3. гялав хийх, гялс хийх, анивс гэх, сүүмс гэх; **свеча ~ла и погасла** лаа анивс гээд унтарчихав.
МИГОМ агшин зуур, хоромхон зуур, агшнаа, агшинд; ~ **вернись** агшин зуур эргэж ирнэ.
МИГРАЦИОНН|ЙЙ нүүдлийн нүүх; ~**ое движение** нүүх хөдөлгөөн.

МИГРАЦИЯ 1. нүүдэл, нүүх; **внутренняя** ~ улс дотроо нүүх; ~ **птиц** шувууны нүүдэл; 2. шилжил, шилжих; ~ **капитала** хөрөнгийн шилжил, хөдөлгөөн.
МИГРЕНЬ тал толгой өвдөх, толгой таллан өвдөх.
МИГРИРОВАТЬ нүүх шилжих.
МИЕЛОМ чөмөгний бундуу, чөмөгчөр.
МИЗАНТРОП хүнийг үзэн ядагч, зожиг хүн.
МИЗАНТРОПИЧЕСКИЙ хүнийг үзэн ядах, зожиг хүн.
МИЗАНТРОПИЯ хүнийг үзэн ядах, зожиг явдал.
МИЗГИРЬ тэмээн аалз.
МИЗЕРНО шалиггүй, ялиггүй, маш өчүүхэн, тон жаахан.
МИЗЕРНОСТЬ шалиггүй (байх), ялиггүй (байх), маш жаахан (байх).
МИЗЕРНЫЙ шалиггүй, ялиггүй, маш өчүүхэн, тон жаахан.
МИЗИНЕЦ чигчий (хуруу).
МИКАДО японий хуандий, микадо.
МИКОЛОГИЯ мөөг судлал, мөөгний зүй.
МИКРОБ нян, бичил биетэн, микроб, ~ **аэробный** агаартан нян.
МИКРОБИОЛОГ бичил амь судлалч, микробиологи.
МИКРОКОСМ хумхи ертөнц, бичил ертөнц.
МИКРОМЕТР микрометр, бичил хэмжүүр.
МИКРОН микрометр, (метрийг сая хуваасны нэг).
МИКРООРГАНИЗМ бичил биетэн, микроорганизм.
МИКРОСКОП микроскоп, бичил дуранбай.
МИКРОСКОПИЧЕСК|ЙЙ 1. микроскопоор хийх, микроскопын, бичил дуранбайгаар хийх, бичил, дуранбайн; ~**ое исследование** микроскопоор хийсэн шинжилгээ; 2. гагцхүү, микроскопт үзэгдэх, гагцхүү бичил дуранбайгаар харах; 3. бичил, хумхийн тоос шиг өчүүхэн, галт шилээр хармаар жаахан ~ **рост** галт шилээр хармаар жаахан өсөлт.
МИКРОСКОПИЧНЫЙ 1. гагцхүү микроскопт үзэгдэх, гагцхүү бичил дуранбайгаар харах; 2. бичил, хумхийн тоос шиг өчүүхэн, галт шилээр хармаар жаахан.
МИКРОСКОПН|ЙЙ микроскопын; ~**ое стекло** микроскопын шил.
МИКРОФИБР|ЛТЫ бичил ширхэгэнцэр.
МИКРОФОН микрофон.
МИКСТУРА шингэн эм, усан эм.
МИЛИТАРИЗАЦИЯ 1. милитарист бодлого явуулах, цэрэгжүүлэх, 2. цэрэгжүүлэл, цэрэгжүүлэх.
МИЛИТАРИЗМ милитаризм.
МИЛИТАРИЗОВАТЬ цэрэгжүүлэх.
МИЛИТАРИСТ милитарист, цэрэгжүүлэх үзэлтэн.
МИЛИТАРИСТИЧЕСКИЙ милитарист.
МИЛИЦЕЙСКИЙ цагдан сэргийлэхийн, цагдаагийн.
МИЛИЦИОНЕР цагдаа, сэргийлэгч.
МИЛИЦИЯ цагдан сэргийлэх (газар), цагдаагийн газар.
МИЛЛИАРД тэрбум, миллиард, арван дүнгүүр.
МИЛЛИАРДЕР тэрбумтан.
МИЛЛИГРАММ миллиграмм.
МИЛЛИМЕТР миллиметр.
МИЛЛИМЕТРОВКА миллиметрийн шугамтай цаас.
МИЛЛИОН 1. сая 2. үй түм, тоо томшгүй.
МИЛЛИОНЕР саятан.
МИЛЛИОННЫЙ олон сая, сая сая, сая төгрөгний; ~ **оборот** сая төгрөгийн гүйлгээ.
МИЛО ялдамхан, аятайхан, хөөрхөн; ~ **улыбнуться** ялдамхан инээмсэглэх.
МИЛОВАТЬ өршөөх, өршөөл үзүүлэх, хайрлах, хайр хүртээх.
МИЛОВАТЬ энхрийлэх, таалах.
МИЛОВАТЬСЯ энхрийлэлдэх, энхрийлэлцэх, таалалдах, таалалцах.

МИЛОВИДНОСТЬ хөөрхөн (байх), аятайхан царай.

МИЛОВИДН||ЫЙ хөөрхөн, аятайхан; ~**ое** личико хөөрхөн царай.

МИЛОСЕРДИЕ нигүүлсэл, энэрэл, нигүүлсэх энэрэх.

МИЛОСЕРДНЫЙ нигүүлсэнгүй энэрэнгүй; ~ поступок нигүүлсэнгүй явдал.

МИЛОСТИВО өршөөнгүй, энэрэнгүй.

МИЛОСТИВ||ЫЙ өршөөлт, энэрэлт, өршөөлтэй, энэрэлтэй, өршөөнгүй, энэрэнгүй; ~ **государь** өршөөлт ноён; ~**ая** государыня энэрэлт хатан.

МИЛОСТЫНЯ өглөг, просить милостыню юм гуйх, гуйланчлах.

МИЛОСТ||Ь 1. өршөөл, энэрэл, хайр; сдаться на ~ победителя ялагчийн өршөөлд шүтэж бууж өгөх; из ~и өршөөн, энэрэл үзүүлэн, 2. хишиг, хайр; 3. хайр, энэрэл; **быть в ~и у кого-либо** хүнд хайрлагдан байх, хүний ивээлд байх; **милости просим** морилон орно уу, орж хайрлагтун; **скажите на ~ хэлж** хайрламуу, тийм үү? тийм гэж үү?

МИЛ||ЫЙ 1. ялдамхан, аятайхан, хөөрхөн; ~ человек ялдамхан хүн; 2. амраг, янаг, хайрт хонгор; **мой ~ друг** амраг нөхөр минь, хайрт найз минь; ~**ые бранятся** — только тешатся ам дордойвч, элэг дордойлгүй.

МИЛЯ бээр; морская ~ далайн миль (1852 метр); географическая ~ газрын миль (7420 метр).

МИМИЧЕСКИЙ нүүрийн хөдөлгөөний, мимикийн.

МИМО 1. дэргэдүүр хажуугаар; поезд проехал мимо станции галт тэрэг өртөөний хажуугаар өнгөрөв. 2. хажуугаар гадуур; **лечь ~ ведра** хувингийн гадуур хийх.

МИМОЗА сийрсэн мод, гамба цэцэг.

МИМОЛЁТН||ЫЙ 1. хурдан түргэн, хальт; ~ взгляд хальт харах; 2. түргэн зуурын, зуурдын батгүй, найдваргүй; ~**ая** радость түргэн зуурын баяр.

МИМОХОДОМ явуут, зууртаа, далимд, ялдамд ялдар; ~ упомянуть далимд дурдах.

МИН||А I 1. мина; подводная ~ усан дорх мина; 2. харвадаг мина; 3. шунгадаг мина; **подвести ~у, подложить ~у** далдуур хорлох.

МИН||А II царай; **сделать кислою ~у** яравгар царай гаргах, ярвайх.

МИНАРЕТ минарет, лалын сүмийн цамхаг.

МИНДАЛЕВИДН||ЫЙ бүйлс хэлбэртэй, бүйлсэн; ~**ые** глаза бүйлс хэлбэртэй нүд.

МИНДАЛЕВЫЙ бүйлсний.

МИНДАЛИНА 1. бүйлсний цөм, 2. бүйлсэн; ~ **гортанная** төвөнхийн бүйлс.

МИНДАЛЬ 1. бүйлс(мод); ~ **цветёт ранней весной** бүйлс хавар эрт цэцэглэнэ. 2. бүйлс, бүйлсний жимс.

МИНДАЛЬНИЧАТЬ 1. нялганах, нялуун загнах, 2. нялганах, эвлэрэх, толгой илэх.

МИНДАЛЬН||ЫЙ бүйлсэн, бүйлсний, бүйлстэй; ~**ое** масло бүйлсний тос.

МИНЁР минач, мина тавигч.

МИНЕРАЛ эрдэс.

МИНЕРАЛОГ эрдэс судлагч, эрдсийн зүйч.

МИНЕРАЛОГИЧЕСК||ИЙ эрдсийн зүйн, эрдэс судлалын, ~ кабинет эрдсийн зүйн кабинет; ~**ая** корреляция эрдсийн харьцуулга.

МИНЕРАЛОГИЯ эрдсийн зүй, эрдэс судлал, минералог.

МИНЕРАЛЬН||ЫЙ эрдэс, эрдсийн, эрдэстэй; ~**ые** удобрения эрдэс бордоо.

МИНИАТЮР||А 1. миниатюр; 2. бяцхан өгүүллэг, бяцхан найруулга, бяхан жүжиг; ~ **в ~е** бяцхан хэмжээний.

МИНИАТЮРН||ЫЙ 1. миниатюр, миниатюрын; ~**ая** живопись миниатюр зураг; 2. маш бяцхан; ~ **столик** маш бяцхан ширээ.

МИНИМАЛЬНО хамгийн бага, хамгийн богино, хамгийн багадаа, доод зах нь, үгүй дээ;

МИНИМАЛЬН||ЫЙ хамгийн бага, хамгийн богино хугацаа; ~**ое** количество хамгийн бага тоо.

МИНИМУМ 1. туйлын бага (хэмжээ), хамгийн бага (тоо), нэн бага; ~ **атмосферного давления** агаарын даралтын хамгийн бага хэмжээ; 2. хамгийн багадаа, доод зах нь, багадаа л; **эта работа требует ~ два дня** энэ ажилд багадаа л хоёр өдөр хэрэгтэй; 3. туйлын (бага) хамгийн бага, нэн бага, минимум; **программа ~ минимум программ**; **прожиточный ~ амьжиргааны доод түвшин**; **технический ~ техникийн минимум, техникийн хамгийн чухал мэдлэг.**

МИНИРОВАНИЕ мина тавих, миналах.

МИНИРОВАТЬ мина тавих, миналах.

МИНИСТЕРСКИЙ 1. сайдын; ~ **пост** сайдын тушаал; 2. засгийн газрын.

МИНИСТЕРСТВО яам; ~ **иностранных дел** Гадаад явдлын яам.

МИНИСТР сайд; ~ **иностранных дел** Гадаад явдлын Яамны сайд; **заместитель ~а** орлогч сайд; **премьер ~** ерөнхий сайд; ~ **без портфеля** яамгүй сайд; **товарищ ~а** шадар сайд.

МИНН||ЫЙ мнын, минатай, мина тавьсан; ~**ое** поле мнын талбай, мина тавьсан газар.

МИНОВА||ТЬ 1. (дэргэдүүр) өнгөрөх, хажуугаар гарах; 2. зайлах, ангижрах, хагацах; ~ **смертя** үхлээс ангижрах; 3. өнгөрөх; **опасность ~ла** аюул өнгөрөв; **минуя подробности** нарийны нь дурдалгүй.

МИНОГА нүд загас.

МИНОИСКАТЕЛЬ 1. мина олуур; 2. мина ологч.

МИНОМЁТ мина харвуул.

МИНОМЁТНЫЙ мина харвуулын.

МИНОМЁТЧИК мина харвуулч.

МИНОНОСЕЦ минат онгоц.

МИНОР 1. билиг эгшиг; 2. уйтгар гуниг.

МИНОРН||ЫЙ 1. билиг эгшгийн; ~**ая** гамма билиг эгшгийн зохиол эрэмбэ; 2. уйтгартай, гунигтай.

МИНУВШЕЕ өнгөрсөн цаг, нөгчисөн үе, улирсан юм.

МИНУВШИЙ өнгөрсөн, нөгчсөн, улирсан, өнгөрөгч; ~ **год** өнгөрсөн жил.

МИНУС 1. хасах тэмдэг; 2. хасахад, хасвал, хасах нь; **семь ~ два** — **пять** долоогоос хоёрыг хасахад тав үлдэнэ; 3. дутагдал; **в этом проекте были ~ы** энэ төсөлд дутагдал байсан.

МИНУТ||А 1. минут; **десять минут** первого арван хоёр цаг арван минут; 2. түр зуур; **зайти куда-либо** иа ~у нэг газар түр зуур ороод гарах; **сно ~у** мөдхөн; **в свободную ~у** чөлөөтэй цагтаа; **одну ~у, одна ~!** жаахан хүлээнэ үү! ~у **внимаяна!** түр анхаарна уу!

МИНУТН||ЫЙ 1. минутын; ~**ая** стрелка часов минутын зүү; 2. нэг минутын; ~ **перерыв** нэг минутын завсарлага; 3. түр зуурын; ~**ая** радость түр зуурын баяр.

МИНУ||ТЬ 1. өнгөрөх; ~**ло** ещё два дня бас хоёр өдөр өнгөрлөө; 2. хүрэх, гарах; **ему ~ло** десять лет тэр арван нас хүрсэн.

МИОЛОГИЧЕСК||ИЙ булчин судлалын, булчин зүйн; ~**ое** исследование булчин зүйн шинжилгээ.

МИОЛОГИЯ булчин судлал, булчин зүй.

МИОМА булчин хавдах.

МИР I 1. ертөнц, орчлон, хорвоо, замбуулин, замба тив; **происхождение ~а** ертөнцийн үүсэл, 2. дэлхий, дэлхийн

бөмбөрцөг; известие облетело весь ~ энэ мэдээ бүхий дэлхийд тарав; 3. ертөнц дахин, дэлхий дахин; 4. ертөнц; 5. хүмүүс; научный ~ шинжлэх ухааны хүмүүс; в литературе -е бичгийн хүмүүсийн дотор; 6. аймаг, ертөнц; ~ животных амьтны аймаг; ~ растений ургамлын аймаг; звёздный ~ одны аймаг; органический ~ шим ертөнц.

МИР II 1. эв эе найрамдал; жить в -е эвтэй амьдрах, найрамдалтай суух; 2. энх тайван; Всемирный совет -а Бүх дэлхийн энх тайвны зөвлөл; 3. найрамдал, найрамдлын гэрээ заключить ~ найрамдал байгуулах.

МИР III хүй нэгдэл; всем ~ом бүгдээрээ нэгдэн.

МИРАЖ 1. зэргэлгээ; ~ в пустыне цөл говийн зэргэлгээ; 2. хуурмаг үзэгдэл, зүүд зэргэлгээ шиг үзэгдэл.

МИРИАДЫ түмэн, үй түмэн, тоймгүй олон, хэмжээлшгүй олон; ~ звёзд үй түмэн од мичид.

МИРИТЬ эвлэрүүлэх, найрамдуулах, хүлцүүлэх.

МИРИТЬСЯ 1. эвлэх, эвлэрэх, найрамдах; они ~лись тэд найрамдав. 2. хүлцэх, эвлэрэх.

МИРНО 1. эвтэй, эетэй найрамдалтай; ~ беседовать эвтэй ярилцах 2. амар амгалан, тайван энх; ~ спать амгалан унтах.

МИРН|ЫЙ 1. энх тайвны, энх тайвныг сахигч, энх тайванч; ~ая политика энх тайвны бодлого; 2. энх амгалан, энх тайван, энх амгалан, тайван; ~ое время тайван цаг; 3. найрамдлын гэрээ; 4. амгалан, номхон, түвшин; ~ характер номхон зан.

МИРОВ|АЯ сайн дураараа эвлэх, эвлэрэх; пойтн на ~ую сайн дураараа эвлэх, эвлэрэх.

МИРОВОЗРЕНИЕ ертөнцийг үзэх үзэл, үзэл.

МИРОВ|ОЙ I 1. ертөнцийн, орчлонгийн; 2. дэлхийн, дэлхий дахины, дэлхийд түгээмэл; ~ая война дэлхийн дайн.

МИРОВ|ОЙ II эвлэсэн, эвлэрсэн, эвлэх, эвлэрэх, найрамдах, эвлэрүүлэх, найрамдуулах; ~ая сделка эвлэрэх хэлэлцээ; ~ судья найрамдуулах шүүгч (Хаант Оросын жижиг хэрэг шүүх шүүгч).

МИРОЕД нударган баян.

МИРОЗДАНИЕ ертөнц, орчлон.

МИРОЛЮБИВО эвтэй эетэй, эв эетэй.

МИРОЛЮБИВОСТЬ энх тайвныг эрхэмлэх явдал, эв зөийг хичээх явдал, амгалан тайван зан.

МИРОЛЮБИВ|ЫЙ энх тайвныг эрхэмлэгч, энх тайвныг эрхэмлэх, эв зөийг хичээгч, найрамдлыг эрхэмлэгч; ~ая политика энх тайвныг эрхэмлэх бодлого.

МИРОЛЮБИЕ энх тайвныг эрхэмлэх, эв зөийг хичээх.

МИРООЩУЩЕНИЕ орчин тойронд хандах хандлага.

МИРОПОНИМАНИЕ ертөнцийн ойлголт, бодит байдлын ойлголт.

МИРОСОЗЕРЦАНИЕ ертөнцийг үзэх үзэл, үзэл.

МИРОСОЗЕРЦАТЕЛЬНЫЙ ертөнцийг үзэх үзлийн, үзлийн.

МИРОТВОРЧЕСК|ИЙ энхийг сахиулах; ~ие силы энхийг сахиулах хүчин.

МИРСКОЙ I хар төрийн.

МИРСКОЙ II хүй нэгдлийн.

МИРЯНИН төрийн хар хүн, харц.

МИСКА жижиг төмпөн, пял; деревянная ~ модон пял.

МИССИОНЕР шажин номлогч.

МИССИЯ 1. даалгавар; 2. үүрэг, тавилан; ~ поэта шүлэгчийн үүрэг; 3. элчний газар; 4. төлөөлөгчид; военная ~ цэргийн төлөөлөгчид; 5. шажин номлох газар.

МИСТЕРИЯ шажны сүжиг, цам.

МИСТИК агний ёсыг баримтлагч, сангасваа.

МИСТИКА 1. агний ёс; 2. шид, тарни.

МИСТИФИКАТОР мэхлэн төөрүүлэгч.

МИСТИФИКАЦИЯ мэхлэн төөрүүлэх.

МИСТИФИЦИРОВАТЬ мэхлэн төөрүүлэх.

МИСТИЦИЗМ агний ёс.

МИСТИЧЕСКИЙ 1. агний ёсны; 2. мэхлэн төөрүүлэх, нууц далд; тарни шиг.

МИТИНГ цуглаан.

МИТИНГОВАТЬ цуглаан хийх.

МИТИНГОВЫЙ цуглаанын.

МИТКАЛЬ гөлөнгөр, шанхай даавуу.

МИТРА митр (үнэн алдартны шажны шнрээт ламы малгай.)

МИТРОПОЛИТ хамба, митрополит, (үнэн алдартны шажны шнрээт ламын их цол)

МИФ 1. домог; 2. далан худал.

МИФИЧЕСК|ИЙ 1. домгийн; ~ сюжет домгийн өгүүлэгдэхүүн; 2. үлгэр домгийн, үлгэр домогт орсон; ~ая личность үлгэр домгийн хүн, үлгэр домогт орсон хүн; 3. далан худал.

МИФОЛОГ домог судлаач, домгийн зүйч.

МИФОЛОГИЧЕСК|ИЙ үлгэр домгийн, домгийн зүйн, домог судлалын ~ое сказание домог үлгэр.

МИФОЛОГИЯ домог үлгэр, домгийн зүйн, домог судлал.

МИЧМАН 1. мичман (Оросын Армийн улирсан усан цэргийн ахлагчийн цол).

МИЧМАНСКИЙ мичманын.

МИЧУРИНЕЦ мичуринч.

МИШЕН|Ь бай; стрельба по ~ям бай буудах; 2. бай хүн; служить ~ью для насмешек инээдэм наадмын хүн болох, тоглоом шоглоомын бай болгох.

МИШУРА 1. алтан мөнгөн утас; 2. гяланцаг, гялгар цалгар юм, бахар.

МИШУРН|ЫЙ 1. утасны, хоргойн, алтан мөнгөн утасны; 2. ~ое золото хоргойн алт; 3. гяланцаг болсон, гялгар, цалгар болсон.

МИЕЛИТ нугас үрэвсэх.

МЛАДЕНЕЦ цах, цахаа, балчир хүүхэд; грудной ~ хөхүүл цах.

МЛАДЕНЧЕСКИЙ нялх балчир, цах ахуй; ~ возраст балчир нас.

МЛАДЕНЧЕСТВ|О нялх үе, балчир нас, цах ахуй, нялхас; охрана материнства и ~а эх нялхсыг хамгаалах.

МЛАДОЙ идэр залуу, и стар и млад хөгшин залуугүй.

МЛАДОСТЬ идэр залуу нас.

МЛАДШ|ИЙ 1. дүү, отгон, залуу хойт; мой ~ брат миний дүү; ~е поколение залуу үе, хойт үе; 2. бага, дэд, дорд, доод; ~ научный сотрудник эрдэм шинжилгээний дэд ажилтан; ~ лейтенант бага дэслэгч.

МЛЕКОПИТАЮЩЕЕ хөхтөн; хищные ~ махчин хөхтөн.

МЛЕТЬ 1. бээрэх, даарч мэдээ алдах; 2. гөлрөх, бахардах.

МЛЁЧНЫЙ сүүн, сүү шиг; ~ сок сүү шиг шүүс; ~ путь тэнгэрийн оёдол, тэнгэрийн заадас.

МНЕ 1. над; 2. миний, над; обо ~ миний тухай.

МНЕМНИКА цээжлэх арга дөр, цээжлүүлэх арга дөр.

МНЕМНИЧЕСК|ИЙ цээжлэх, цээжлүүлэх; ~ие приёмы цээжлүүлэх арга дөр.

МНЕНИ|Е санал бодол; общественное ~ олон нийтийн санал; обменяться ~ями саналаа солилдох.

МНИМОСТЬ хуурмаг (байх), худал (байх), ~ болезни худал өвчин.

МНИМ|ЫЙ 1. сэтгэлдээ бодсон, санаа дагасан; 2. хуурмаг худал; ~ больной хуурмаг өвчтөн; 3. хуурмаг; ~ые числа хуурмаг тоо.

МНИТЕЛЬНОСТЬ сэжиг, биеэ чагнах; страдать ~ю сэжиглэн зовох.

МНИТЕЛЬНЫЙ сэжигч биеэ чагнагч; ~ больной биеэ чагнагч өвчтөн.

МНИТЬ тооцох, өргөмжлөх; ~ себя учёным биеэ эрдэмтэн гэж өргөмжлөх.

МНИТЬСЯ санагдах, бодогдох, үзэгдэх.

МНОГ|ИЕ 1. олон; во ~их отношених олон талаар; 2. олон хүн; ~ так думают олон хүн ингэж боддог.

МНОГО 1. их, их юм; он ~ знает тэр (хүн) их юм мэднэ; 2. олон, их; ~ лет прошло олон жил өнгөрлөө; ~ шума нэ нинчего шалигүй юмнаас их шуугиан гарна; 3. олон байх, их байх; как ~ ясан олон юм; 4. их, хавигүй, нилээд; ~ лучше их дээр; ~ меньше хавигүй бага; ~ выше их өндөр; ~ ~ ихдээ л, олондоо л; ни ~ ни мало их ч үгүй бага ч үгүй, илүү ч үгүй, дутуу ч үгүй.

МНОГОБРАЧИЕ олон эхнэртэй (буюу олон нөхөртэй) байх ёс.

МНОГОВАТО оловтор, олхон, иххэн, ихэвтэр.

МНОГОВЕКОВ|ОЙ олон зуун жилийн, олон үеийн; ~ая история человечества хүн төрөлхтөний олон зуун жилийн түүх.

МНОГОВАСТНИЕ олон засаг.

МНОГОВОДН|ЫЙ ус ихтэй; ~ая река ус ихтэй гол.

МНОГОГОВАРЯЩИЙ их юм ухааруулах, чухал мэдээ бүхий, гүн утгатай.

МНОГОГОЛОВЫЙ олон толгойтой.

МНОГОГРАННИК олон цамцаалт, олон талт.

МНОГОГРАННЫЙ 1. олон цамцаалттай, олон талтай; ~ камень олон талтай чулуу; 2. олон цамцаалт, олон талт; ~ угол олон талт өнцөг; 3. юм юмны, төрөл бүрийн; ~ талант юм юмны авъяас.

МНОГОДЕТН|ЫЙ олон хүүхэдтэй, өнөр; ~ая семья өнөр гэр бүл; ~ая мать олон хүүхэдтэй эх.

МНОГОЕ олон юм, олон зүйл.

МНОГОЖЕНЕЦ олон эхнэртэй хүн.

МНОГОЖЕНСТВО олон эхнэртэй (байх).

МНОГОЗЕМЕЛЬНЫЙ газар ихтэй.

МНОГОЗНАЧИТЕЛЬНО учиртай, учир утгатай; ~ взглянуть учиртай харах.

МНОГОЗНАЧИТЕЛЬН|ЫЙ 1. учиртай, учир утгатай; ~ взгляд учиртай харц; 2. утга төгөлдөр, ач холбогдол ихтэй; ~ая встреча ач холбогдол ихтэй уулзалт.

МНОГОЗНАЧНОСТЬ 1. олон оронтой (байх), 2. олон утгатай (байх); ~ слова үг олон утгатай байх.

ГОЗГОНОХ неуклюже двигаться, часто шевелиться (о тонких, длинных, торчащих предметах)
ГОЗГОНУУЛАХ *побуд. от* **гозгонох**, часто двигать, шевелить, производить движение (о торчащих, тонких предметах), **гар хөлөө** ~ болтать руками и ногами, **хуруугаа** ~ двигать пальцами
ГОЗГОР 1) вертикальный, торчащий, поднимающийся вверх, 2) высокий, тонкий, худощавый
ГОЗОЙЛГОХ *побуд. от* **гозойх**, поднимать, ставить торчком
ГОЗОЙХ подниматься, выпрямляться, вытягиваться, торчать, стоять торчком, **зурам нүхнийхээ аман дээр** ~ж байна суслик стоит у своей ямы торчком
ГОЗОЛЗОХ мерно двигаться, высовываться (о чём-либо тонком, поднимающемся вверх)
ГОЗОН 1. торчащий, вертикальный
ГОЗОН 2.: ~ **толгой** одноклнй, **бобыль**
ГОЙД весьма, чрезвычайно, очень, немного, ~ **сайхан** очень красивый
ГОЙМОН вермишель, **хөндий** ~ макароны, **нарийн** ~ вермишель, ~той шөл суп с вермишелью, ~ **баятар** прозвище Сухэ-Батора
ГОЛ 1. река, ~ын эх/адаг верховье/устье реки, ~ын гүүр мост через реку, ~ын могоолзой речной угорь, ~ усаар яриа беспочвенный разговор, толочь воду в ступе
ГОЛ 2. середина, центр, стержень, **хотын яг** ~ дунд нь в самом центре города, **лааны** ~л фитиль свечи, ~ мах филе, **шинжилгээний** ~ нь стержень исследования
ГОЛ 3. основной, центральный, главный, ~ **гудамж** главная улица, ~ хот главный город, ~ хүч главные силы, ~ **цохилт** главный удар, ~ **гэрч** основной свидетель, ~ **үүрэг хүлээгч** основной должник, тот, на ком лежит основная ответственность, **хамгийн** ~ нь самое главное, ~ **шалтгаан** основная причина, ~ **ач холбогдол** главное значение, ~ **утга/санаа** главная мысль, ~ **зорилго** главная цель, ~ **газар** центральное место, ~ **орох** утолить голод, ~ **зогоох** сводить концы с концами, ~д **орох** выручать, спасать
ГОЛГҮЙ 1) бессовестный, падкий до чего-либо, 2) без стыда, нахально, совсем, ~ худал хэлэх бесстыдно солгать, ~ хөлдөх окончательно замерзать, совсем превратиться в лёд
ГОЛДОЧ меридиан
ГОЛДУУ главным образом, в основном, в большинстве, чаще
ГОЛИГОР толстый, тучный, жирный, полный, ~ **тарган гахай** толстая, жирная свинья

ГОЛИЙХ быть толстым, оказываться тучным, становиться полным/жирным, ~тол **таргалах** сильно жиреть, лосниться от жира/тучности, ~тлоо **ндэх** наедаться досыта
ГОЛИЛЗОХ двигаться, шевелиться (о полных, тучных и толстых)
ГОЛИО *зоол.* кобылка, ~ **азаа** үзэх попытать счастье на авось, ~ **чихэрразг.** карамель, конфета, *разг.* вертолёт
ГОЛЛОХ 1) занимать центральное место, быть в центре чего-либо, 2) быть главным, оказываться центральным, главенствовать, 3) играть в чём-нибудь главную роль, фокусироваться, ~н суух сидеть в самом центре, ~ **тоглох** исполнять главную роль, ~ **ажил** главная работа, **энэ хэрэгт тэр** ~но в этом деле он играет главную роль, ~ж **хуваах** разделить пополам
ГОЛЛУУЛАХ *побуд. от* **голлох**, разместить по одну линию/в одной точке, делать главным/центральным, собирать фокус, центровать, центрировать *тех.*
ГОЛОГДОЛ брак, дефект, ~ **бүтээгдэхүүн** бракованное изделие, бракованная продукция, ~ **гаргах** делать брак, выпускать брак
ГОЛОГДОХ быть бракованным, быть отвергаемым, быть пренебрегаемым, ~сон хүүхэн отвергнутая девушка
ГОЛОМТ очаг, эпицентр, **гал** ~ домашний очаг, очаг предков, **газар хөдлөлтийн** ~ очаг землетрясения, **дайны** ~ очаг войны, ~ **сахих** продолжать род, ~ нь **тасрах** выродиться, перестать существовать (о роде), ~ **залгамжлагч** наследник, **халдварий** ~ очаг инфекции
ГОЛОХ 1) считать недостойным/плохим, быть недовольным, браковать, отвергать, пренебрегать, 2) не принимать детского (о матках животных), **эхнэрээ** ~ пренебрегать женой, **эр нөхрөө** ~ относиться к мужу без почтения, **хургаа** ~ не принимать ягнёнка (об овцах), ~сон **янзтай/байдалтай** с пренебрежительным/недовольным видом
ГОЛТ: ~ бор сирень
ГОЛЦУУ в основном, в большинстве
ГОЛЧ 1. честный, правдивый, справедливый, прямой, ~ хүн правдивый/прямой человек, ~ зан честный/прямой характер, ~ мэргэн үг правдивые и мудрые слова
ГОЛЧ 2. диаметр, поперечник круга
ГОМДОЛ жалоба, апелляция, претензия, обман, **санал** ~ *парн.* жалобы, **шүүхийн шийдвэрт** ~ мэдүүлэх подавать апелляцию на решение суда, ~ыг хэрэгсэхгүй болгох отклонить апелляцию, ~эрэх жаловаться, заявлять претензию, **санал** ~ын дэвтэр книга жалоб, жалобная книга, ~ын товчоо бюро жалоб, ~ын шаардлага **гаргах** заявлять претензию, ~ыг хангах (**барагдуулах**) удовлетворять жалобу, ~ **гаргагч** жалобщик, подающий жалобу, ~ **үндэслэлгүй гаргах** заявлять необоснованную претензию, ~ **хянан шийдвэрлэх журам** порядок рассмотрения жалоб
ГОМДОЛТОЙ обидный, жалобный, досадный, обидно, жалобно, досадно, **би** ~ байна у меня есть жалоба (претензия)
ГОМДОНГУЙ 1) жалобный, скорбный, с обидой, 2) жалобно, обидливо, ~ **харах** смотреть с обидой
ГОМДООХ обижать, хүүхдийг биттгий гомдоо! не обижайте ребёнка!
ГОМДОХ обижаться, жаловаться, **биттгий** ~оорой! не обижайтесь!
би чамд ~гүй я не обижаюсь на тебя, **өөртөө** ~ пеняй на себя
ГОМОРХОЛ сетование, жалоба, неудовольствие, недовольство, роптание, претензия
ГОМОРХОХ сетовать, жаловаться, выражать недовольство, быть недовольным, предъявлять претензии
ГОН 1.: ~ **бие** бобыль, ~ **бие** **гозон толгой** один, как перст
ГОН 2.: ~ ~ **хийх/гэх** ныть, хныкать, докучать жалобами, плакаться, **чи юу гэж** ~ ~ гээд **байгаа юм бэ?** чего ты ноешь?

ГОНГИНОО(и) звукн жалобной речи, звукн плача, хныканье, нгытё, залхуутай ~и надоедливое нгытё, хныкающие звуки, ~ дуутай неприятный/~соны хэрэггүй и не надейся, что сможешь её окружить! горьд! ага, держи карман шире!

ГОНГИНОХ 1) гнусавить, 2) ныть, хныкать, пищать, плакаться, плаксиво жаловаться

ГОНЖ зря, попусту, безрезультатно, бесполезно, тэр чамд туслана гэдэг ~ он тебе не поможет, бесполезно ждать от него помощи, ёстой ~ на-ка выкуси!

ГОНЖГОНОХ двигаться, шевелиться (о продолговатом, вытянутом предмете)

ГОНЖГОР 1) продолговатый, вытянутый удлиненный, овальный, 2) перен. неуклюжий

ГОНЖИЙХ 1) делаться продолговатым, стать вытянутым, быть овальным/удлиненным, 2) перен. быть неуклюжим

ГОНЗГОЙ продолговатый, овальный, удлиненный, ~ царай продолговатое лицо, ~ талх батон

ГОНЗГОЙВТОР слегка продолговатый

ГОНЗГОР удлиненный, продолговатый, вытянутый, ~ хад продолговатая скала, ~ хэлбэртэй сав посуда, имеющая удлиненную форму, продолговатая посуда

ГОНЗОЙЛГОХ побуд. от гонзойх, делать продолговатым/удлиненным, вытягивать в длину

ГОНЗОЙХ становиться продолговатым, стать удлиненным, быть вытянутым, делаться овальным

ГОНСГОР мрачный, грустный, унылый, угрюмый, мрачно, грустно, уныло, угрюмо, сурово, сэтгэл изг л ~ байна на душе/сердце что-то грустно

ГОНСОЙЛГОХ побуд. от гонсойх, огорчать, расстраивать, привести к грустному состоянию, энэ мэдээ сэтгэлийг минь ~в эта весть огорчила меня

ГОНСОЙХ огорчаться, расстраиваться, делаться угрюмым, становиться грустным, быть мрачным, унывать

ГОНСРОХ унывать, печалиться, огорчаться

ГОНШГОНОХ 1) ныть, хныкать, прося что-либо (о детях), докучать/наедать просьбамн, 2) пищать

ГОНШИХ гнусавить, говорить гнусаво, говорить в нос

ГОНЬД тмин, ногоон ~д укроп

ГОО красивый, ~ сайхан а) красивый, прекрасный, б) красота, в) косметика, ~ сайхны заслын газар косметический кабинет, ~ заслын дэлгүүр косметический магазин, эмчилгээний ~ засал лечебная косметика, ~ зүй эстетика, эстетический, ~ зүйн онол эстетическая теория

ГООЖИХ 1) течь, литься, вытекать (о жидкости), 2) сыпаться, хөлс ~ обливаться потом, цус ~ истекать кровью, кровотоичить, ~ж гарах вытекать, выливаться, ~ж орох втекать, вливаться, ~дусаал ~ж байна капает

ГООЖУУЛАХ побуд. от гоожих, 1) лить, проливать, 2) сыпать, просыпать, 3) перен. проявлять алчность, жадничать, нулимс ~ проливать слёзы, цусаа ~ проливать кровь, шүлээ ~ а) распускать слёзы, пускать слюну, б) проявлять чувство алчности, нусаа ~ а) распус-тичь сопли, б) простудиться, хөлсөө ~ а) обливаться потом, б) работать в поте лица, работать до пота

ГООЖУУР 1. 1) сток, водосточный желоб, 2) кран (водопроводный), 3) трубочка (по которой сыплется или льётся что-либо)

ГООЖУУР 2. разг. салага, новобранец

ГООМОЙ необдуманный, опрометчивый, неосновательный, несерьёзный, легкомысленный, необдуманно, опрометчиво, неосновательно, несерьёзно, легкомысленно, ~ дүгнэлт неосновательный вывод, необдуманное заключение, ~ шийдвэр необдуманное решение, ~ явдал опрометчивый, неосмотрительный

поступок, ~ хүн легкомысленный/ несерьёзный человек, ~ хнийж болохгүй нельзя поступать опрометчиво/необдуманно

ГООМОЙТОХ проявлять неосмотрительность/легкомыслен, вести себя необдуманно/опрометчиво, ~ж болохгүй нельзя проявлять необдуманность, нельзя вести себя опрометчиво

ГООНЬ холостой, одинокий

ГООЧЛОХ 1) обижать, дразнить, задевать, трогать, 2) пробовать, пытаться съесть что-либо, та намайг ~ хэрэггүй вы меня не дразните/не задевайте, хурга нинг өвс ~ж байна ягната и козлята привыкают есть траву

ГООЧЛУУЛАХ побуд. от гоочлох, быть задетым, дразниться, быть причиной раздражения

ГОРДГОР 1) жёсткий, твёрдый, затвердевший, 2) высохший

ГОРДОЙЛГОХ побуд. от гордойх, делать затверде-лым/высохшим, давать делаться жёстким/твёрдым

ГОРДОЙХ делаться жёстким, становиться высохшим, быть твёрдым

ГОРЗГОР 1) длинный; худошавый, сухошавый, 2) огрубевший, отвердевший, высохший, ~ туранхай хүн тоненький, худошавый человек, ~ арьс невыделенная и высохшая кожа, жёсткая шкура

ГОРЗОЙЛГОХ побуд. от горзойх, давать огрубевать, делать отвердевшим, давать высохнуть

ГОРЗОЙХ 1)засыхать в сыром виде, огрубевать, отвердевать (напр. о коже), 2) быть сухошавым, делаться худошавым

ГОРИГҮЙ 1) нет надежды, ненадёжный, безнадёжный, 2) негодный, трудный, 3) не получится, нельзя, олдох ~ байна нет надежды найти, нет надежды на то, что найдётся, ~ хүүхэд трудный ребенок, ~ хүн негодный/ненадёжный человек

ГОРИЛОГЧ сонскатель, докторын зэрэг ~ сонскатель докторской степени

ГОРИЛОХ 1) надеяться, ожидать, предполагать что-либо, 2) представлять на соискание, дэд эрдэмтний зэрэг ~сон зохиол диссертация на соискание учёной степени кандидата наук

ГОРИМ режим, порядок, норма, правило, ~ журам, ~ дэглэм парн. режим, положение, устав, ёс ~ обычай, нарийн ~ сахих/баримтлах соблюдать строгий режим, зохих ~ журмаар нь хийх/ажиллах выполнять/работать по соответствующему правилу

ГОРИМ 1) высыхать, пересыхать в горле, застревать (о сухой пище), 2) чувствовать душевную тяжесть, быть в гнетущем настроении, дотор ~ чувствовать тяжесть под ложечкой, быть в тягостном состоянии

ГОРТИГ 1. циркуль, готовальня, ~ийн хөл циркульная ножка

ГОРТИГ 2. 1) круг, черта, 2) предел, граница, черта, ~ татах провести черту, ~ дотор в черте чего-либо, в пределах чего-либо, ~оос гарах зайти за предел, сургуулийн ~оос гадна за чертой школы

ГОРХИ 1. пряжка, застёжка, приспособление для застёжки, бүсний ~ пряжка для поясного ремня, поясные застёжки, зэс ~ медная пряжка

ГОРХИ 2. ручья, ручей, речка, поток, гол ~ речки, уулын ~ ручей

ГОРХИЛОХ застёгивать, закреплять пряжкой

ГОРЬДЛОГО надежда, ожидание, желание, чаяние

ГОРЬДЛОГОГҮЙ безнадёжный, ненадёжный, бесполезный, негодный

ГОРЬДЛОГОТОЙ внушающий надежду, обнадеживающий, вызывающий надежду

ГОРЬДООХ побуд. от горьдох, вызывать надежду, обнадежи-вать, давать надеяться на что-нибудь, заставляя ожидать

ГОРЬДОХ надеяться, полагаться, ожидать, желать

ГОРЬДУУЛАХ обнадеживать, заставляя ожидать

ГОСПИТАЛЬ госпиталь, госпитальный, ~д эмчлүүлэх лечиться в госпитале, **цэргийн хээрийн** ~ полевой госпиталь

ГОХ крюк, крючок, багор, **бууны** ~ **дарах** нажать на курок, спустить курок, ~ дэгээ - а) крюк, б) крючковторство, ~ дэгээ **тавих** заниматься крючком/апортом

ГОХДОХ поддевать крючком, зацеплять/захватывать багром/крюком

ГОХТОЙ 1) с крюком, 2) *перен.* хитрый, крючковторный

ГОЦ 1) отличный, особый, особенный, 2) особо, особенно, ~ **сайн** превосходный, отличный, ~ **гойд юмгүй** ничего особенного, ~ **аихаарах** уделять особое внимание, ~ **сонирхох** проявлять особый интерес к чему-либо, ~ **мөргөх** получить добавочное очко, набрать очко без борьбы (о борцах)

ГОЦДОХ слишком выделяться, особо отличиться, выйти в ведущий тур без борьбы

ГОЦЛОЛ соло, **дуурийн театрын** ~ **дуучин** солист оперного театра, ~ **бүжиг бүжиглэх** танцевать соло

ГОЦЛОХ 1) выделяться, отличаться, 2) получать добавочное очко без борьбы, ~ **и дуулах** петь соло

ГОЮУ пластырь, хөхөх ~ вытяжной пластырь, **шарханд** ~ **наах** заклеивать пластырем рану, ~ **гаар хөхүүлэх** наложить пластырь

ГӨВДӨХ бить, колотить, избивать, выбивать, наносить побои

ГӨВДРҮҮ 1) прыщ, бугорок, 2) красная полоса от удара чем-нибудь (напр. палочкой)

ГӨВДРҮҮГЭХ 1) покрываться прыщиками/бугорками, появляться (о прыщах, бугорках), 2) покрываться красными полосами от удара

ГӨВӨХ встряхнуть

ГӨВШИХ бить, колотить

ГӨЕН мелкий, неглубокий, ~ **нуур** мелкое озеро

ГӨЕХӨН мелковатый, неглубокий, мелковато, неглубоко, поверхностно, ~ **гол** неглубокая река, ~ **мэдэх** знать поверхностно

ГӨЖҮҮН упрямый (о лошади)

ГӨЛБӨЛЗӨХ чувствовать себя виноватым, сознавать свою вину, ~ **сөн харц** виноватый взгляд

ГӨЛГӨНӨХ 1) лосниться, блестеть, отсвечивать, 2) *перен.* попадать в тулик, попадать в иловкое положение по своей вине, признавать себя виноватым, **хэлэх үггүй** ~ не находить слов, созная свою вину

ГӨЛГӨР гладкий, ровный, скользкий, ~ **гадаргуу** ровная поверхность, гладкая поверхность, ~ **тэгшхөн зам** ровная дорога

ГӨЛИЙЛГӨХ *побуд.* от **гөлийх**, делать гладким/ровным, делать блестящим

ГӨЛИЙХ 1) становится гладким, делается блестящим, становится скользким, 2) *перен.* быть неподвижным, стать пассивным, оцепенеть, впадать в апатию

ГӨЛӨГ 1. щенок, **нохойн** ~ детёныш собаки, щенок, **чонын** ~ волчонок

ГӨЛӨГЛӨХ 1. щениться, рожать щенят, принести щенят

ГӨЛӨГЛӨХ 2. распускаться, давать/пускать ростки, **модод хараахан** ~ **өөгүй байна** ещё не распустились почки/не появились побеги на деревьях

ГӨЛӨЛЗӨХ 1) блестеть, отсвечивать, лосниться, 2) чувствовать себя виновным, оказываться в неловком положении по своей вине, **бусдын нүүр харж чадахгүй** ~ стыдиться/бояться смотреть в лицо другим

ГӨЛӨМ 1) чепрак, 2) лист, **ширэн** ~ кожаный чепрак, **хивсэн** ~ коворый чепрак, ~ **и н төмөр** лист железа, металлический лист, ~ **и шил** лист стекла

ГӨЛРӨХ обомлеть, уставиться глазами, **айснаас** ~ обомлеть от ужаса

ГӨЛТГӨНӨ гипс, **талстат** ~ гипс кристаллический

ГӨЛЧГӨР что-либо гладкое/скользкое, что-либо блестящее

ГӨЛЧИЙЛГӨХ *побуд.* от **гөлчнийх**, делать гладким/скользким/блестящим

ГӨЛЧИЙХ становиться гладким, стать ровным, делаться блестящим, быть скользким

ГӨӨГӨӨ дядя (обращение к кнтайцу)

ГӨРДӨГДӨХ *страд.* от **гөрдөх**, быть оклеветанным, **хулгайд** ~ быть несправедливо обвиненным в краже

ГӨРДӨГЧ клеветник, **хорон санаат** ~ злостный клеветник

ГӨРДӨХ 1) клеветать, распространять о ком-либо клевету, 2) ложно подозревать

ГӨРӨӨ 1) охота, 2) дичь, дикие звери, **ан** ~ дикие звери, дикие животные, **ан** ~ **хийх** заниматься охотой

ГӨРӨӨЛӨГЧ: сэм ~ браконьёр

ГӨРӨӨЛӨХ охотиться, добывать диких зверей

ГӨРӨӨС травоядное дикое животное, **зээр** ~ антилопа, **бор** ~ косуль, **бөхөн** ~ сайгак, **ямаан** ~ горный козёл, **бух** ~ тур, дикий як, **хүн** ~ снежный человек

ГӨРӨӨЧИН охотник, зверебой

ГӨРӨӨЧЛӨХ охотиться, **ууланд** ~ охотиться в горах

ГӨРҮҮЛЭХ *побуд.* от **гөрөх**, давать плести, заставляя заплетать

ГРАДУС градус, **гудамжны жавар тас** **няс явагийн халуун 40** ~ (Д.Нацагдорж) на улице стужа - стужей, а милая горяча как 40 градусов

ГРАММ грамм

ГРАНАТ граната, ~ **шидэх** бросать гранату, ~ **тэсрэх** взрыв гранаты, ~ **ын хэлтэрхий** гранатные осколки

ГРАФИК график, **галт тэрэгний** ~ график движения поездов, **жижүүрийн** ~ график дежурства

ГРИПП грипп, гриппозный

ГУА 1. красивый, прекрасный, ~ **сайхан хүн** красавец

ГУА 2. бахчевые культуры, **амгат** ~ дыня, **ший** ~ арбуз

ГУАГЛАХ 1) каркать (о вороне), 2) квакать (о лягушке)

ГУАЙ вежливое обращение к старшим, *может передаваться словами:* дядя, тётя, товарищ, уважаемый, почтенный и др. **Содном** ~! дядя Содном! уважаемый Содном, **Оюун** ~! тётя Оюун!

ГУАЙЛАХ обращаться вежливо со словом **гуай**, уважать

ГУАЛИГ красивый, стройный, ~ **нуруутай хүн** стройный красивый человек, ~ **гачуур** мод стройная сль

ГУАЛИН бревно, балка, бревенчатый, балочный, ~ **гүүр** бревенчатый мост, балочный мост

ГУАНЗ столовая, кафе, «столовка», **оюутны** ~ студенческая столовая, **сувиллын/цагаан хоолны** ~ диетическая столовая

ГУАНЗДАХ питаться в столовой/кафе, есть в ресторане

ГУВШАА привыкший сосать чужую матку (напр. ягнёнок)

ГУВШИХ сосать чужую матку (о ягнёнке, козлёнке, телёнке), **гуйж** ~ настоятельно просить, умолять, надоедать просьбами

ГУДАЙЛГАХ *побуд.* от **гудайх**, склонять голову, опускать/наклонять голову, **накрених**, **толгойгоо альгүй** ~ слегка /чуть опустить голову

ГУДАЙХ склоняться, наклоняться, **накрених**, **цэжээ альгүй урагш** ~ слегка наклониться вперёд, **толгой** ~ наклонить голову, **нар** ~ в солнце закатилось

ГУДАМ корндор, проход

ГУДАМЖ 1. улица, проспект, 2) **гол/төв** ~ главная/центральная улица, **эргийн** ~ набережная, **гадаа** ~нд на улице, ~ **ны хөдөлгөөн** уличное движение, ~ **ны гэрэл** дожно светофор

ГУДАРГАН наклонный, с наклоном, ~ **ор** кровать с наклоном в головной части

ГУДАС 1. вдоль, на протяжении, **зам** ~ по дороге

ГУДАС 2. крытый материей войлочный матрас, орны ~ матрац для кровати
ГУДГАР сгорбленный, сутулый, наклонный, ~ цээжтэй морь лошадь с приподнятым крупом
ГУДИГ 1) печаль, огорчение, 2) внимание, забота
ГУДИГГҮЙ беспечный, беззаботный, невнимательный, хэтэрхий ~ хүн чересчур беззаботный человек
ГУДИГГҮЙДЭХ быть слишком беспечным/беззаботным
ГУДИГГҮЙТЭХ вести себя слишком беспечным, становиться очень беззаботным
ГУДРАХ 1) запикивать, засовывать, 2) всовывать, впикивать, *перен.* жрать, жадно есть, хар ус ~ напиться до чёртиков
ГУДЧИХ сопеть, посапывать
ГУЙВАЛЗАХ покачиваться, шататься, колебаться
ГУЙВАЛТ покачивание, шатание, колебание, ~ дайвалтгүй не колеблясь, ~н дундаа при покачивании, при шатании
ГУЙВАХ 1. переводить (деньги)
ГУЙВАХ 2. колебаться, качаться, шататься, быть непоследовательным
ГУЙВАГНАХ то и дело шататься/качаться, часто колебаться
ГУЙВУУЛАХ 1) качать, шатать, колебать, 2) переводить (деньги), 3) искажать, извращать, үнэнийг ~ извращать/искажать истину, баримтыг ~ искажать факты, үг ~ извращать чьи-либо слова, банкаар мөнгө ~ переводить деньги через банк, цахилгаан холбоогоор дамжуулан мөнгө ~ телеграфный перевод денежных средств
ГУЙВУУЛГА перевод, мөнгөний ~ денежный перевод, перевод денег, ~ын баримт квитанция перевода денег
ГУЙЛГА 1) просьба, прошение, 2) попрошайничество, ~ гуйх просить милостыню, попрошайничать
ГУЙЛТ просьба, ~ыг биелүүлэх удовлетворить чью-либо просьбу, бусдын ~аар по чьей-либо просьбе
ГУЙМТГАЙ часто просящий, привыкший просить
ГУЙМХАЙ канючащий
ГУЙРАНЧИН нищий, попрошайка
ГУЙРАНЧЛАЛ нищета, попрошайничество
ГУЙРАНЧЛАХ нищенствовать, попрошайничать, жить в нищете, кланчить
ГУЙХ просить, выпрашивать, умолять, упрашивать, тусламж ~ просить помощи/помочь, зөвшөөрөл ~ просить разрешения, чөлөө ~ просить освобождения, просить освободить, би чамайг ~гүй я не буду упрашивать тебя, нөгөө Цэцгээ эрэгтэйчүүдийг ~д улам үнээд ордог если парни просят (упрашивают) ту Цэцгээ, она ещё больше набивает себе цену
ГУЛБИГАНАХ 1) изгибаться из стороны в сторону, извиваться всем телом, быть упругим, 2) быть хилым /тонким
ГУЛБИГАР 1) тонокий, хилый, слабый, вялый, 2) упругий, эластичный, гибкий, ~ дорой мал тощий слабый скот, ~ булчин слабые мышцы
ГУЛБИЙХ становиться хилым, делаться вялым, быть тонким и слабым
ГУЛБИЛЗАХ делаться упругим, стать эластичным, извиваться
ГУЛГАХ кататься, скользить, тэшүүрээр ~ кататься на коньках, цанаар ~ ходить на лыжах, чаргаар ~ кататься на санках
ГУЛГАЛТ катание, скольжение, ураг ~ фигурное катание, хос ~ парное катание, ганцаарчилсан ~ одиночное катание
ГУЛГИХ срыгивать, отрыгивать (о ребёнке), нярай хүүхэд сүүгээр ~я младенец срыгнул молоком
ГУЛГУУЛАХ побуд. от гулгах, катать, давать/разрешать кататься
ГУЛГУУР каток, мөсөн ~ каток
ГУЛД: хөндлөн ~ вдоль и поперёк

ГУЛДАЙХ 1) валяться, лежать (о длинных предметах), лежать пластом, 2) быть неподвижным, оказываться вялым, стать слабым, зам дээр гуалин ~ж хэвтэнэ на дороге лежит/валяется бревно
ГУЛДГАР длинноватый, продолговатый, тонкий
ГУЛДМАЙ 1) длинный, длинноватый, 2) туша
ГУЛДРАХ таскать, ташить, волочить, чирч ~ двигать волоком, ташить, татаж ~х дэргать, тащить
ГУЛДРИЛ русло, ширгэсэн горхины ~ русло высохшей речки
ГУЛЖГАЙ тонкий и гибкий, качающийся
ГУЛЖГАНАХ 1) гнуться, пригибаться, становиться изогнутым, 2) быть вялым, оказываться слабым
ГУЛЖГАР 1) тонкий и гибкий, не прямой, гнушной, качающийся, 2) малый
ГУЛЖИЛЗАХ часто сгибаться, то и дело наклоняться, извиваться, качаться, шататься
ГУЛЗАЙЛГАХ побуд. от гулзайх, делать кривым, кривить, делать непрямым, гнуть, төмөр утас ~ гнуть металлическую проволоку
ГУЛЗАЛЗАХ сгибаться, кривиться, гнуться, извиваться, салхинд мод ~на деревья гнутся от ветра
ГУЛЗГАЙ кривой, косой, гнутый, непрямолинейный
ГУЛЗГАНАХ кривиться, гнуться, качаться, шататься, гнуться
ГУЛЗГАР кривой, гнутый
ГУЛИР мука, мутное
ГУЛРАХ ошибаться, совершать проступок, делать ошибку, заблуждаться
ГУЛСАЛТ 1) скольжение, 2) оползень
ГУЛСАХ 1. 1) скользить, катиться, 2) оползти, мөсөн дээр ~ кататься на льду
ГУЛСАХ 2. переходить, передаваться от одного к другому
ГУЛУУЗ 1. скалка для раскатывания теста
ГУЛУУЗ 2. туша, хонины ~ баранья туша
ГУЛУУЗ 3. слиток, ~э алт слиток золота
ГУНА (н) трёхлетний, трёхгодовалый (о самцах крупных домашних животных, а также крупных зверей), ~н бух трёхлетний бычок/бык-производитель, ~н барс трёхгодовалый тигр
ГУНГАНАХ 1) гнусавить, издавать гнусавый звук, 2) издавать нечленораздельные носовые звуки, мычать, 3) *перен.* докучать, надоедать
ГУНДААХ побуд. от гундах, истощать, изнулять, привести к истощению, делать физически слабым/усталым
ГУНДАХ 1) истощаться, изнуляться, сильно уставать, выглядеть усталым, становиться слабым, 2) разоряться, иищать, гутаж ~ огорчаться, печалиться, падать духом
ГУНДМАЛ 1) истощённый, исхудалый, ослабевший, 2) печальный, понурый
ГУНЖ (ин) трёхгодовалая, трёхлетняя (о самках крупных домашних животных), ~н үнээ корова трёх лет, трёхлетняя телка
ГУНЖГАР тонкий и продолговатый
ГУНЖИЙХ 1) делаться тонким и продолговатым, становиться продолговатым, 2) кривиться, гнуться
ГУНИГ печаль, грусть, тоска, уйтгар ~ парн. печаль, уныние
ГУНИГГҮЙ 1) без печали, без грусти, 2) *перен.* довольно, опасно, ~ хурдан морь довольно быстрый конь, ~ цэвэрхэн/сайхан довольно чистый/красивый
ГУНИГЛАЛ грусть, печаль, тоска, уныние
ГУНИГЛАХ грустить, печалиться, тосковать, ~н суух грустно сидеть, печалиться
ГУНИГТ печальный, грустный, унылый, ~ амьдрал печальная жизнь, ~ дуу грустная песня

ГУНИГТАЙ печальный, грустный, унылый, ~ түүх грустная история, **Бужин** их ~ **харагдаж байна** Бужин выглядит печальной

ГУНИХ печалиться, испытывать печаль от чего-нибудь, грустить о чём-нибудь, тосковать, печалиться, ~ж **гутрахын хэрэггүй** не надо печалиться, не стоит грустить, не огорчайся

ГУНИХРАХ печалиться, грустить

ГУНИХРУУЛАХ *побуд.* от **гунихрах**, печалиться, наводить грусть/тоску

ГУНСРАХ 1) огорчаться, горевать, унывать, 2) ослабевать, становиться хилым, расстраиваться

ГУНХАЛЗАХ отличаться стройностью, держаться грациозно, двигаться пластично, быть стройным и грациозным

ГУНХАГНАХ быть грандиозным (-ой), стройным (-ой)

ГУНХГАР стройный, красивый, пропорционально красиво сложенный, гармоничный, грациозный, ~ **сайхан биетэй эр** мужчина со стройной фигурой, грациозный мужчина

ГУНШАА гнусавый, гнусливый, гнусавость, ~ **дуун гнусавый** голос, ~ **хүн гнусавый** человек

ГУНШГАНАХ 1) гнусавить, гнусить, 2) *перен.* хныкать, ныть, плакаться

ГУНШИН 1) титул, звание, 2) прозвище, кличка *простореч.*

ГУНШИХ говорить в нос, гнусавить, **хамраараа** ~ж дуулах петь в нос

ГУРАВ/ГУРВАН три, ~ **дахин**, ~н удаа три раза, **өнөөдөр** ~ дахь өдөр сегодня среда, ~ **хоноод ир** приходи через три дня, ~н **даахар байшин** трёхэтажный дом, ~н **талын** трёхсторонний, ~н **сар а)** три месяца, **б)** март, ~н зуу трина, ~н хувь три процента, ~ны хоёр две трети, ~ны нэг одна третья, ~н талаас бүрэлдсэн состоящий из трёх частей, ~н ~ын ес трижды тридевять, ~н залууртан трёххвостка рыба, ~н **Маралын орд** со звездие Орнон

ГУРАВДАГЧ третий, ~ **этгээд** третье лицо

ГУРАВДАХ третий, третий по счёту, третий раз

ГУРАВДУГААР третий, ~ **хуудас** третья страница, ~ **зэрэг** третий сорт/разряд

ГУРАВЛАХ делить на три части, объединяться втроём, сложиться на покупку чего-нибудь втроём

ГУРАВТ 1. тройка, ~ын **төгрөг/дэвсгэрт** купюра в три тугрика, трёшка

ГУРАВТ 2. 1) в третьих, 2) в три часа

ГУРАВХАН только три, всего три

ГУРВАЛ трио, терцет, ~ **хөгжимчин** трио музыкантов

ГУРВАЛЖИН треугольник, треугольный, **тэгш өнцөгт** ~ прямоугольный треугольник, **адил талт** ~ равносторонний треугольник, **чацуу хажуут** ~ равнобедренный треугольник, ~ **хайрцаг** треугольная коробка, ~ **талбай/талбар** треугольная площадь, площадь в форме треугольника, ~ **хэрүүл** перекрёстный спор, **Бермудын** ~ Бермудский треугольник

ГУРВАЛЖЛАХ придавать треугольную форму чему-нибудь, делить треугольным

ГУРВАНГАА трижды, три раза, ~ **унших** читать три раза

ГУРВУУЛ втроём, троё, все три, ~ **иржээ** пришли втроём

ГУРГАЛДАЙ 1. прямая кишка

ГУРГАЛДАЙ 2. **алтан** ~ соловей, **алтан** ~н дуу пение соловья, **алтан** ~н **жиргээн/жиргэх** соловьиные трели

ГУРГУУЛ фазан, ~ын өд фазань перья *побуд.* от **гурзайх**, **нестош**ать, **лиш**ать сил, **дел**ать худым/тошным

ГУРЗАЙХ худеть, исхудать, истощаться, изнуряться, становиться тошным/худым, делаться тонким/слабым

ГУРЗАЛЗАХ измождённо шевелиться, истощённо двигаться (о ком-, чём-либо тонком, худом)

ГУРЗГАР худой, тощий, тонкий, исхудалый, истощённый, ~ **туранхай хүн** тонкий худой человек, истощённый человек

ГУРИА 1. голодный, обессиленный, измождённый, тощий, (слабый) (о собаке)

ГУРИА 2. скряга, скупой человек

ГУРИАТАХ сильно голодать, страдать от голода (о собаке, волке)

ГУРИЛ мука, мучной, **нарйин** ~ мука высшего сорта, ~ **зуурах** месить тесто, ~ **элдэх** раскатывать тесто, ~ын **үйлдвэр** мучомольный комбинат, ~ын **шуудай** мешок для муки, ~ан **бүтээгдэхүүн** мучные изделия, **улаан буудайн** ~ пшеничная мука, **хөх тарианы** ~ ржаная мука

ГУРИЛДАХ 1) смазывать мукой, 2) заправлять мукой, **цай** ~ заправлять чай мукой и маслом

ГУТААГЧ компрометирующий, дискредитирующий, **нэр** ~ тот, кто компрометирует, тот, кто портит чью-либо репутацию

ГУТААХ портить, позорить, порочить, срамить, очернять, **нэр** ~ а) порочить чье-либо имя, компрометировать, дискредитировать, б) дискредитация, компрометация

ГУТАЛ обувь, сапоги, обувной, **шаахай** ~ ботинки, **эсгий** ~ валенки, **савжин** ~ сапоги, **ажлын** ~ спецобувь, **гэрийн** ~ домашние тапочки, ~ **өмсөх** обуваться, ~ **өмсгөх** обувать кого-либо, **бнейин тамирын** ~ спортивные тапочки, ~ын **дэлгүүр** обувной магазин, ~ын **үйлдвэр** обувная промышленность, ~ын **тос**, **сойз** крем и щётка для обуви, ~ **засаар** ремонт обуви

ГУТАЛТ обутий, в сапогах, ~ **муурын үлгэр** сказка про kota в сапогах

ГУТАЛЧИН сапожник, обувщик

ГУТАМШИГ позор, стыд, срам, пошлость, бесчестье, **юутай/ямар** ~ что за позор!

ГУТАМШИГТ позорный, стыдный, пошлый, бесчестный, ~ **явдал/хэрэг** позорный поступок, ~ **амьдрал** позорная жизнь

ГУТАМШИГТАЙ позорный, стыдный

ГУТАХ огорчаться, омрачаться, **сэтгэл** ~ быть удручённым, **дур** ~ терять интерес, **тер**ять охоту к чему-либо, **ой** ~ брезговать, **чув**ствовать отвращение

ГУТРАЛ огорчение, депрессия, горе, неприятность, **сэтгэлийн** ~ душевная боль

ГУТРАХ падать духом, тосковать, огорчаться, омрачаться, **сэтгэл санаагаар** ~ быть в огорчении, **битгий гутар!** не огорчайтеся!

ГУТГААР третий, ~ **богь** третий том

ГУУ 1. овраг, ложбина, балка, ров, ~ **жалга парн**. овраг, яр, обрыв

ГУУ 2. 1) рама, рамка, 2) медальон, ладанка, *уст. религ.* **зургийн шармал/алгадмал** ~ позолоченная рама для картины, **гэрэл зураг** ~нд **хийх** вставить фотографическую карточку в рамку, **шилтэй** ~нд **байгаа хөрөг** портрет в рамке под стеклом

ГУУЖИЛТ линия, линияне, **хаврын** ~ весенняя линия

ГУУЖИХ линять, сбрасывать наружный покров/шерсть, перья, кожу и т.п. передавать электрический ток, **ном бие биедээ** ~ передавать кингу друг другу, **нүд/харц** ~ осматривать, перевести взгляд **бүжэ** бегать глазами, **хазаар** ~ красть, воровать (о разных животных и птицах)

ГУУЛИН сделанный из латуни, латунный, ~ **шанага** латунный ковш-черпак, ~ **хөгжим** духовой оркестр/инструмент

ГУУЛЬ латунь, жёлтая медь, ~ **зэс нь цухуйх** проявлять нехорошие черты, обнаружить своё утро

ГУУР 1) свинц, изъян в чём-нибудь в виде дыры, 2) личинка овода на спине крупного рогатого скота и лошади

ГУУРС 1. перо (птичье), ствол птичьего пера, **тарнаны** ~ солома

ГУУРС 2. соломинка (для питья)

ГУУРС 3. трубка, канал, катетер

ГУЧЛУЧИН тридцать, **би** ~н настай мне тридцать лет, ~н **жилийн ой** тридцатилетие, тридцатилетний юбилей, ~н

жилийн өмнө тридцать лет тому назад, тэр ~ хүрч байна ему под тридцать, Сарантуяа ~ гарсан ч их л залуу харагдана хотя Сарантуяе исполнилось 30 лет, она выглядит очень молодой

ГҮЧ праправнук

ГҮЧААД около тридцати, по тридцать, хотоос ~ километр в тридцати километрах от города, ~ оны эхээр/эцсээр в начале/в конце тридцатых годов

ГҮЧДАХЬ тридцатый по счёту

ГҮЧДУГААР тридцатый, номын ~ талд үз! смотри на тридцатой странице книги!

ГҮЧИНТАА тридцать раз

ГҮЧУУЛ всего тридцать, все тридцать, бид ангидаа ~ нас в классе всего тридцать

ГҮЯ 1) ляжка, бедро, 2) задняя конечность при разделке туши, ~а ганзгалж ирэх приехать с пустыми руками, гуя баз свояки, хаалганы ~ брус/косяк дверной рамы, «юун үхрийн ~?» намёк на кого-либо проговорившегося

ГҮЯДАХ 1) бить, хлестать, стегать, 2) бросать с размаху (при борьбе), морийг ташуураар ~ стегать коня кнутом, нуруун дундуур нь сураар ~ хлестать по спине ремнём

ГҮВГЭНЭХ передвигаться медленно, ползть по поверхности

ГҮВГЭР выпуклый, небольшой выступ, слегка возвышенная местность, энэ жижиг ~ийн цаана нуур бий за этим невысоким выступом находится озеро

ГҮВДРҮҮ прыщ, бугорок

ГҮВДРҮҮТЭХ 1) покрываться прыщиками/бугорками, появляться (о прыщах, бугорках), 2) покрываться красными полосами от удара

ГҮВДЭХ бить, колотить, избивать, выбивать, наносить побои

ГҮВНЭХ идти медленно, передвигаться с трудом, еле двигаться

ГҮВҮҮЛЭХ побуд. от гүвэх, быть выколоченным, быть побитым, выколачиваться, отряхиваться (от пыли, снега и т.п.)

ГҮВҮҮР то, чем выбивают/выколачивают, выбивалка

ГҮВҮҮРДЭХ выбивать пыль

ГҮВЭХ 1) удая, очищать от пыли, трясти, колотя, выбивать из чего-нибудь что-нибудь, выколачивать, выбивать, 2) отцветать, опадать, осыпаться после цветения, ~ж арилгаж/цэвэрлэх выколачивала пыль из одежды, намаар болж модод навчаа ~в наступила осень и листья с деревьев опали

ГҮВЭХ 2) разорять, истрчивать, промотать, байдаг хөрөнгө мөнгөө ~н өөдгүй амьтан тип, промотавший всё свое богатство

ГҮВЭЭ 1. бугор, холм, возвышенность

ГҮВЭЭ 2. дамба, плотина

ГҮВЭЭРХҮҮ бугристый, холмистый, ~ газар холмистая местность

ГҮДГЭР выпуклый

ГҮДИЙХ становиться возвышенным, делаться выпуклым

ГҮДЭС прямой, чистосердечный, откровенный, правдивый, ~ зан прямой /решительный характер, ~ эр прямодушный мужчина

ГҮДЭСДЭХ быть слишком прямым, прямодушный

ГҮДЭСХЭН довольно прямой/прямодушный, несколько откровенный, довольно правдивый, ~ сэтгэл прямота души

ГҮЖИР 1. ложь, неправда, клевета, клеветнический, ложный, ~ гүтгэлэг парн. клевета, ложное обвинение, ~ цуурхал клеветнические слухи, гүн усанд олом үгүй, ~ үгэнд үгэн үгүй погов. в глубокой воде нет брода, а в клевете нет правды

ГҮЖИР 2. стойкий, решительный, упорный, смелый, сильный, ~ эр решительный, сильный мужчина

ГҮЖИРДЛЭГ клевета, хула, сплетня

ГҮЖИРДЭГДЭХ страд. от гүжирдэх, ложно обвиняться, быть оклеветанным

ГҮЖИРДЭХ клеветать, порочить, оговаривать, хулить, сплетничать, улаан цайн ~ явно (нагло) клеветать, бусдыг ~ж болохгүй нельзя оклеветать на других людей

ГҮЖИРЛЭХ 1. клеветать, порочить

ГҮЖИРЛЭХ 2. быть сильным/крепким, оказываться решительным/смелым

ГҮЖИРМЭГ 1) сильный, крепкий, выносливый, здоровый, 2) решительно, смело, ажидд их ~ хүн очень работоспособный человек, очень усердный в работе человек, ~ биегэй физически крепкий

ГҮЖИРМЭГИЙЛЭХ поступать смело, действовать решительно, действоавать физической силой

ГҮЖИРМЭГЛЭХ действовать решительно

ГҮЗЭЭ 1) рубец, брюшина, 2) перен. живот, брюхо, пузо, ~ нхтэй хүн пузатый человек, человек с большим животом, ~ суух становиться пузатым, ~нд наалдсан дэлүү шиг дагах следовать как тень, ~ шороодох отдать концы, «дать дуба», ~ мэдэн идэх есть чересчур много

ГҮЗЭЭЛЭГЭНЭ земляника, земляничный, ~ний бут земляничные кустники, ~ний чанамал земляничное варенье, варенье из земляник

ГҮЗЭЭЛЭХ 1) делаться пузатым, иметь большой живот, 2) класть что-либо в рубец, 3) перен. много есть, много пить

ГҮЗЭЭРХҮҮ/ГҮЗЭЭРХЭГ пузатый

ГҮЙДЭЛ 1) течение, циркуляция, 2) ток, цусны ~ циркуляция крови, цахилгаан ~ электрический ток, моринны ~ дунд на бегу лошади

ГҮЙ постпозитивная частица отрицания не, нет, без, ажил~ нет работы, безработный, без работы, би явах~ я не пойду

ГҮЙГДЭХ страд. от гүйх, переноситься, переводиться, передаваться

ГҮЙГЧ бегун, бегающий, ойрын зайн ~ спринтер, бегун на короткую дистанцию

ГҮЙДЭЛ циркуляция, ~ үүсгэгч генератор, ~ хэмжигч амметр (амперметр)

ГҮЙЛГЭНЭХ слегка покрываться жидкостью, нулимс ~ слезиться, иаполняться слезами

ГҮЙЛГЭХ 1. побуд. от гүйх, 1) заставлять бежать, 2) отправлять, дэлгүүр рүү хүүхэд ~ отправить ребенка в магазин, сонин ~н унших просматривать газету, ~н бичих бегло писать, ухаан ~думать, обдумывать, мыслить, шевелить мозгами

ГҮЙЛГЭХ 2. продавать, торговать, бараа ~ продавать товары, наймаа ~ торговать чем-нибудь, успешно распродавать, делать торговый оборот

ГҮЙЛГЭХ 3. страдать поносом, гэдэс ~ болеть поносом, цусаар ~ кровавый понос

ГҮЙЛГЭХ 4. 1) передавать, отдавать кому-нибудь, переводить что-либо, 2) жарг. красть, воровать

ГҮЙЛГЭХ 5. покрывать чем-либо, будаг ~ окрашивать, красить во что-либо, тугалга ~ покрывать полудой, лудить, цайр ~ покрывать цинком, цинковать

ГҮЙЛГЭЭ обращение оборот, бараа ~ товарооборот, мөнгөний ~ денежный оборот, ~ харц беглый взгляд, ~нд оруулах/гаргах пускать в оборот, ~ хийх производить операцию (денежную), делать расчёт, ~ сайтай /нхтэй байх пользоваться большим спросом, ~нээс гаргах изымать из обращения

ГҮЙЛГЭЭГҮЙ не пользующийся спросом, ненужный/негодный для продажи, ~ бараа неходовые товары

ГҮЙЛГЭЭТЭЙ ходкий, пользующийся спросом, ~ ном хорошо расходящаяся книга

ГҮЙЛДЭХ бежать, бегать (о мюгих), гадаа хүүхдүүд ~нэ дети бегают на улице

ГҮЙЛС абрикос, абрикосовый, абрикосный, ~ний мод абрикосовое дерево, ~ний яс абрикосная косточка

ГҮЙЛТ бег, пробег, мянган метрийн ~ бег на тысячу метров, саадтай ~ бег с барьерами, ~ний аварга чемпионо бега, автомашины ~ийн дундаж хэмжээ средняя норма пробега автомобиля

ГҮЙМТГИЙ любящий бегать

ГҮЙМХИЙ 1) любящий бегать, привыкший бегать, 2) домашнее животное по неволе оказавшееся на чужом для него пастбище среди незнакомого стада и стремящееся вернуться к своим

ГҮЙМХИЙ 2) 1) самец, часто бегающий за самкой в период течки, 2) перен. ловелас, донжуан

ГҮЙХ 1) бежать, бегать, 2) течь, ~ж гарах выбежать, ~ж ирэх прибежать, би тэр Цолмонгийн араас ~гүй шүү я за этой Цолмон бегать не буду, ~ нохойд ~гүй нохой саад болох левная собака помага для бегущей собаки

ГҮЙХ 2. распродаваться, реализоваться, идти (о торговле), үнэтэй бараа ~гүй байна дорогие товары плохо реализуются, ховор бараа зах дээр сайн ~дэг дефицитные товары быстро реализуются/продаются на рынке

ГҮЙХ 3. бегать в период течки

ГҮЙХЭН 1) мелкий, неглубокий, 2) перен. поверхностный, несерьезный, узкий, бедный, ~ ус мелководье, ~ мэдлэг узкий кругозор, поверхностные знания, ~ бодол поверхностные размышления

ГҮЙЦЭГДЭХ страд. от гүйцэх, быть настигнутым, настигаться, ~гүй байх быть неуловным

ГҮЙЦЭГДЭШГҮЙ очень быстрый, неуловный

ГҮЙЦЭД полностью, без остатка, ~ мэдэх полностью знать, ажлыг ~ хийх закончить работу полностью

ГҮЙЦЭЛДЭХ 1) исполняться, стать реальностью, осуществляться, 2) собираться в полном составе, укомплектовываться, үл ~ үзэл утопия

ГҮЙЦЭТГҮҮЛЭХ побуд. от гүйцэтгэх, заставлять выполнять, приказывать исполнять

ГҮЙЦЭТГЭГДЭХ страд. от гүйцэтгэх, быть выполненным, быть осуществленным, осуществляться, выполняться, исполняться

ГҮЙЦЭТГЭГЧ 1) исполнитель, 2) исполняющий, 3) подрядчик, шүүхийн шийдвэр ~ судебный исполнитель, гэрээт ажлыг ~ подрядчик договорных работ, ~ байгууллага подрядная организация, үүрэг ~ исполняющий обязанности (и.о.), ерөнхий ~ генеральный подрядчик

ГҮЙЦЭТЭЛ выполнение, исполнение, осуществление, завершение, ~ийн хяналт шалгалт контроль за исполнением чего-либо, ~ийн хугацаа срок исполнения, ~ийн чанар качество исполнения/выполнения, төсвийн ~ исполнение бюджета

ГҮЙЦЭТГЭХ выполнять, исполнять, төлөвлөгөө ~ выполнять план, тушаал ~ исполнять приказ, үүрэг ~ а) играть роль, б) исполнять обязанности, ~ хуудас исполнительный лист, ~ийг хойшлуулсан шүүхийн шийдвэр решение суда об отложении исполнения, амлалтаа/үүргээ ~ исполнять обещание/свой долг, ~ байгууллага/хороо исполнительный орган/комитет, ~ боломжгүй болох (фактическая) невозможность исполнения

ГҮЙЦЭТГЭШГҮЙ неосуществимый, невыполнимый

ГҮЙЦЭХ 1) догонять, нагонять, 2) завершаться, оканчиваться, 3) истекать, кончатся, ~ж түрүүлэх догнать и перегнать, нас ~ стать взрослым, би чамайг ~нэ я догонию тебя, хугацаа ~жээ срок истек, хоногийн тоо ~ пробить (о смертном часе)

ГҮЙЦЭЭГҮЙ незаконченный, неоконченный, арай бичиж ~ еще не дописано, хийж ~ ажил незаконченная работа

ГҮМ: нам ~ тишина, затишье, эргэн тойрон нам ~ вокруг стоит мертвая тишина, шөнийн нам ~ ночная тишина

ГҮН глубина, глубокий, ~ мэдлэг глубокое знание, ~ ноёр глубокий сон, ~ уйтгар глубокая печаль, ~ хэвлэл глубокая печать, далайн ~ морская глубь, морские глубины, ~ далайн геол. батил, арваад метрийн ~д на глубине десяти метров, ~ талархал илэрхийлэх выразить глубокоу благодарность

ГҮНГЭНЭХ бормотать, говорить про себя, говорить негромко и неясно, аман дотроо ~ бормотать себе под нос

ГҮНГЭР: ~ гангар (звукоподражание бормотанию, говору), ~ гангар хийх негромко разговаривать, беседовать между собой

ГҮНДҮҮГҮЙ справедливый, честный, правдивый, прямой, ~ хүн честный человек

ГҮНЖ принцесса, ~тэй суух жениться на принцессе

ГҮНЗГИЙ глубокий, глубокомысленный, ~ худаг глубокий колодец, ~ утгатай үгс глубокомысленные слова

ГҮНЗГИЙВТЭР глубоковатый, глубоковато

ГҮНЗГИЙВТЭРДҮҮ довольно глубокий

ГҮНЗГИЙДЭХ быть глубоким, оказываться более глубоким

ГҮНЗГИЙЛҮҮЛЭХ побуд. от гүнзгийлэх, заставлять углублять

ГҮНЗГИЙЛЭХ углублять, делаться более глубоким, худаг ~ углубить колодец

ГҮНЗГИЙРҮҮЛЭХ побуд. от гүнзгийрэх, 1) углублять, 2) усугублять, мэдлэгээ ~ углублять знания, ~сэн сургалт расширенное обучение

ГҮНЗГИЙРЭХ 1) углубляться, делаться более глубоким, 2) усугубляться

ГҮНЭЭ сильно, очень, ~ хүндэтгэх/итгэх очень уважать/надеяться, ~ хүндэтгэсэн с глубоким уважением, ~ харамсах сильно сожалеть

ГҮРВЭЛ ящерица, үлэг ~ динозавр, ~ аарцагтай ящеротазовые, ~ загас настоящая рыба-ящерица

ГҮРВЭЛЗЭХ 1) пресмыкаться, передвигаться плавно ползком, 2) мед. перистальтика, гэдэсний ~ хөдөлгөөн перистальтика кишок, перистальтические движения/сокращения желудка

ГҮРЖ Грузия, грузины, ~ гургуул фазан обыкновенный

ГҮРИЙХ 1) вздуваться, набухать, распухать, увеличиваться в объеме, 2) разг. заупрямиться, настаивать на своём

ГҮРЭН держава, государство, их ~ великие державы

ГҮРЭЭ переднебокая часть шеи, ~ний судас сонная артерия

ГҮТГҮҮЛЭХ побуд. от гүтгэх, 1) быть оклеветанным, 2) преувеличивать, нарочно/умышленно прибавлять

ГҮТГЭГДЭХ страд. от гүтгэх, быть оклеветанным, хулгайд ~ быть оклеветанным в краже

ГҮТГЭГЧ клеветник, ~ нарыг шийтгэх хэрэгтэй надо наказывать клеветников

ГҮТГЭЛЭГ заведомо ложный слух, клевета, хула, ложь, шар хэвлэлийн ~ клевета желтой прессы, ~ хийх/явуулах возводить клевету, распространять клевету, ~ийн кампани клеветническая кампания

ГҮТГЭХ 1) клеветать, оклеветать, опорочить кого-либо клеветой, 2) клеветнический, ~сэн тул харнуцлагад татах привлечь к ответственности за клевету, ~ арга клеветнические приёмы

ГҮҮ кобыла, кобылица, ~ний сүү кобылье молоко, ~ний айраг кумыс, ~ саах доить кобылиц, олон азрагатай байсан ~ сувайрдаг кобыла, у которой много жеребцов, яловеег

ГҮҮР мост, төмөр замын ~ железнодорожный мост, салдаг/хөвдөг ~ разводной/плавающий мост, ~ээр гарах переходить через мост, ~ийн тулгуур бык, опора моста

ГҮЦ чайник, шаазан ~ фарфоровый чайник, цайны хандны ~ чайник для заварки чая

ГЭВ частица усиления к словам с наальным гэ, ~ гэиэг совсем внезапно, совершенно неожиданно, как снег на голову, ~ гэгээн очень светло

ГЭВЧ хотя, несмотря на то, что, но, однако, **Багабандийг урьсан**, ~ **тэр ирсэнгүй** мы пригласили Багабанди, однако он не пришёл
ГЭВЭЛ 1) если, 2) если спросишь ... то ... в этом значении — обычно перед прямой речью, цитатой или перед перечислением иногда соответствует двоеточию: **тэр хийе** ~ чадна если он захочет, то сможет, **тэр ангид юу юу байна вэ** ~ бува. если спросишь, что есть/имеется в классе, то ...

ГЭГДЭХ *страд.* от гэх, называться, именоваться, считаться, признавать, **сайн оюутан** ~ считаться хорошим студентом

ГЭГЧ 1) некий, некто, какой-то, 2) именуемый, так называемый, 3) довольно, весьма, очень, **Оюуигэрэл ~ хүн яриа хийв** некто Оюунгэрэл провела беседу, **хүн ~ амьтан бол** ... существо, называемое человеком ..., **том ~ харах** смотреть довольно удивленно, смотреть довольно большими глазами, **тарган ~ийн хүн** весьма толстый человек

ГЭГЭЭ свет, заря, **үдшийн/үүрийн** ~ вечерняя/утренняя заря, ~ **орох** рассветать, ~ **тасрах** темнеть, вечереть, ~ **гарах** излучать свет

ГЭГЭЭВТЭР светловатый, светловато

ГЭГЭЭВЧ окно

ГЭГЭЭН светлый, ясный, ~ **нараа** ясное солнце, ~ **ухаан** ясный ум, ~ **цагаан өдрөөр** среди бела дня, **Өндөр Гэгээн** — титул монгольского правителя Занабазара

ГЭГЭЭРҮҮЛЭГЧ просветитель, **ард түмнийг соён** ~ просветитель народа

ГЭГЭЭРҮҮЛЭГ просвещение, просветительстао

ГЭГЭЭРҮҮЛЭХ *побуд.* от гэгээрэх, 1) просвещать, 2) просветительный, просветительский, **ард олныг** ~ просвещать народные массы, ~ **ажил** просветительная работа

ГЭГЭЭРЭЛ просвещение, образование, **ардын** ~ народное просвещение, **Ардын** ~ийн тэргүүний ажилтгай отличник народно-го образования

ГЭГЭЭРЭХ 1) рассветать, 2) становиться светлым/ясным, 3) просвещаться, **үүр** ~ **байна** рассветает, утренняя заря зарезжилась

ГЭГЭЭТЭЙ светлый, светло, ~ **газар** светлое место, ~ **байхад**, ~д пока светло, засветло

ГЭДГЭР 1) с закинутой головой, 2) неохотно, упрямый, ~ **толгой** закинутая назад голова, **тэр их** ~ **хүн юмаа** он, оказывается, очень важная персона, **ажилд ~ хүн** неохотно работающий человек, человек, работающий с ленивой

ГЭДИЙЛГЭХ *побуд.* от гэдийх, 1) выгибать спину, 2) запрокидывать, **толгойгоо** ~ запрокинуть голову

ГЭДИЙХ 1) выпячивать грудь, откидывать назад корпус, выгибаться назад, 2) упрямиться, нарочно/упрямо не соглашаться, ~ **ж явах** идти, выгнув спину назад, **түүнээс гуйсаи чийх харин ч** ~ чихлээ его попросили, но он упрямится/артачится

ГЭДРЭГ обратно, назад, вепять, ~ **буцах** идти обратно, вернуться, ~ **харах** оглядываться, смотреть назад, ~ **харалгүй гүйх** бежать без оглядки, ~э **харж унах** падать на спину, ~ **нь татах** а) тянуть назад, оттягивать, б) затягивать, тормозить, препятствовать, ~ **болох** подаваться назад, отступать, пятиться, ~ **дуудах** отзываться

ГЭДРЭГДЭХ слишком выгибаться назад, чересчур откидываться
ГЭДРЭГЛЭХ уклоняться от работы, отказываться делать что-либо

ГЭДЭГ 1. называется, обычно называют, носит название, **таны нэрийг хэн** ~ **вэ?** как вас зовут? **намайг Сайхнаа** ~ меня зовут Сайхнаа, **монголоор юу** ~ **юм бэ?** как это называется по-монгольски?

ГЭДЭГ 2.: ~ **хнийх/гэх** часто выгибаться назад, то и дело запрокидываться

ГЭДЭГНЭХ 1) часто выгибать спину, часто выпячивать грудь, то и дело откидывать голову назад, 2) нетерпеливо ёрзать, держать себя беспокойно, быть подвижным, ломаться, кривляться, **битгий** ~э **бай!** не ломайся! ~ **ж явах** идти часто изгибаясь

ГЭДЭЛЗЭХ 1) часто изгибаться, 2) ходить, двигаться с важным видом

ГЭДЭН 1. упрямый, неуступчивый, непослушный

ГЭДЭН 2.: ~ **годон** непостоянный, жеманный, легкомысленный, ~ **годон хнийх** кривляться, ломаться, жеманничать

ГЭДЭС живот, брюхо, кишка, **нарийн /бүдүүн** ~ тонкие/толстые кишки, **шулуун** ~ прямая кишка, ~ **ний өвчин** кишечные заболевания, **миний** ~ **өлсөж байна** я проголодался, я голоден, ~ **өвдөж байна** болит живот, ~ **ндээ хөлөө хийлцэх** перегрызть друг друга, мешать друг другу, ~ **гаргах** заколоть скотину, ~ **ний нь хормойлуулах** пустить кишки кому-либо

ГЭДЭСЛЭХ 1) становиться пузатым, избивать живот,

2) беременеть, быть в положении, стать беременной

ГЭДЭСТЭЙ 1) имеющий живот, с брюшком, пузатый, 2) беременная, брюхатая, **том** ~ **эр** пузатый мужчина

ГЭЖ союз что, чтобы, **би мэдэхгүй** ~ **хариулав** я ответил, что не знаю

ГЭЗЭГ коса, **нарийхан** ~ тонкая косичка, **бүдүүн** ~ толстая коса, ~ **тавих** отпустить косу, ~ **сүлжих** заплетать косу, ~ **дарж гарах** рождаться один за другим (о детях)

ГЭЗЭГДЭХ хватать за косу, тянуть за косу

ГЭЛБЭЛЗЭХ разоблачение тайны, **гэмт хүн** ~ **нэ**, **дайрт морь шарвалзана** всё тайное становится явным

ГЭЛДРЭХ шагать спокойно, брести, идти тихо/медленно

ГЭЛЦЭХ *соам.* от гэх, говорить, рассказывать, разговаривать (о многих),

ГЭЛТГҮЙ *разг.* нечего говорить, незачем говорить, не к чему говорить так, **одоо чн тийшээ явна** ~ нечего говорить, что тебе хочется съездить туда

ГЭЛТЭЙ *разг.* можно сказать, энэ бол Аюурын ирсний ач ~ можно сказать, что это благодаря приезду Аюура

ГЭМ 1) порок, недостаток, повреждение, 2) вина, виновность, проступок, ~ **буруу** вина, **зүрхний** ~ порок сердца, ~ **хор** вред, ~ **хор арилгах баталгаа** гарантия возмещения ущерба, ~ **хор арилгуулах тухай нэхэмжлэл** иск о возмещении ущерба, ~ **хнийх /гаргах** наносить вред, совершать преступление, ~э **хүлээх** признавать свою вину, ~ **бурууг хөнгөрүүлэх** смягчать вину, ~ **бурууг хөнгөрүүлэх нөхцөл байдалтайгаар** хүн алах убийство со смягчающими вину обстоятельствами, ~э **намагчлах** каяться, ~ **буруугаа үгүйсгэх** отрицать свою вину, ~ **хор учруулагч** причинитель вреда

ГЭМГҮЙ 1) невинный, безвредный, 2) ничего, пусть, **ямар ч** ~ совершенно невинный

ГЭМТ виновный, преступный, опасный, вредный, ~ **хэрэг** преступление, ~ **явдал** преступность, **эрүүгийн** ~ **хэрэг** уголовное преступление, **эрүүгийн** ~ **хэрэгтэн** уголовный преступник, ~ **хэрэг үйлдэх** совершать преступление, ~ **хэргийн бүрэлдэхүүн** состав преступления, ~ **бүлэглэл** преступная группировка, ~ **довтолгоо** преступное нападение, ~ **санаа** преступное намерение, ~ **зорилго** преступная цель, ~ **үйлдэл** преступное деяние, ~ **хамсал (жэгдэл)** преступное сообщество, ~ **хэргийн гүйцэтгэгч** исполнитель преступления, ~ **хэргийн сэдэлт** мотив преступления, ~ **хэрэг үйлдсэн нөхцөл байдал** обстоятельства совершения преступления, ~ **хэрэг үйлдэхэд оролцогчид** участники совершения преступления, ~ **хэрэгтнийг шилжүүлэх тухай хэлэлцээр** соглашение о выдаче преступников, ~ **эс үйлдэл** преступное бездействие

ГЭМТЭЙ 1) виновный, преступный, *эиэ бол их* ~ хэрэг это очень опасный поступок, **болохгүй**, ~! нельзя, опасно

ГЭМТЭЛ повреждение, дефект, травма, **хөнгөн** ~ лёгкое повреждение, **хүнд**, **ноцтой** ~ серьёзное повреждение, ~ийн эмнэлэг травматологическая больница

ГЭМТЭН преступник, **гол** ~ главный преступник

ГЭМТЭХ получать повреждение, травмироваться, **яс** ~ получить повреждение кости, **хөл нь** ~ жээ у него нога повреждена

ГЭМТЭЭХ *побуд. от гэмтэх*, повредить, травмировать, нанести травму/повреждение, **унаж хөлөө** ~ повредить ногу при падении

ГЭМШИГЧ кающийся, тот, кто раскаивается

ГЭМШИЛ раскаивание, сознание своей вины, исповедь, покаяние, сожаление о чём-либо, **гэм нь урдаа**, ~ **нь хойноо** *бужв.* сначала совершает проступок, а потом раскаивается

ГЭМШИХ каяться, раскаиваться, признавать виновность, исповедать, **гэмт хэрэг хийсэндээ** ~ раскаяться в преступлении, **болсон явдалд харамсам** ~ сожалеть о совершившемся, **буруугаа** ~ сознавать/признавать вину, **нүгэлээ наманчлан** ~ исповедаться, каяться

ГЭМШҮҮЛЭХ *побуд. от гэмших*, заставлять раскаиваться

ГЭНГЭНЭХ 1) взвизгивать, визжать, скуливать, 2) издавать однообразные жалобные звуки, пичать, надоедать, докучать

ГЭНДҮҮЛЭХ *побуд. от гэндэх*, заставить враспloch, нагрязнить неожиданно, захватывать враспloch, ~н асуух враспloch спросить, неожиданно задать вопрос

ГЭНДЭХ 1) вести себя наивно, попасть впросак (по неопытности, по доверчивости), 2) оплошать, совершать оплошность, 3) поддаваться на уловку, **санамсаргүйгээс** ~ оплошать из-за неожиданности

ГЭНТ 1) вдруг, неожиданно, враспloch, внезапно, 2) скоропостижно, 3) случайно, между прочим, **гэв** ~ совсем неожиданно, **тэр** ~ ороод ирэн он вдруг вошёл, **бид гадаа** ~ тааралдлаа мы случайно встретились на улице

ГЭНТИЙН неожиданный, внезапный, скоропостижный, ~ аюул неожиданная опасность, стихийное бедствие, ~ үхэл скоропостижная смерть, ~ учрал случайная встреча

ГЭНТХЭН вдруг, неожиданно, внезапно, **тэр** ~ уйлаад унав он вдруг заплакал

ГЭНЭ неожиданность, внезапность, случайность, оплошность, **би** ~ алдав я совершил оплошность, неожиданность застала меня враспloch

ГЭНЭГҮЙ неожиданный, внезапный, случайный, неожиданно, внезапно, случайно, ~ байх не подозревать, ~ байтал Нарангуа надруу ярсан неожиданно Нарангуа мне позвонила

ГЭНЭЙ 1) наивный, простодушный, легковерный, 2) доверчивый, 3) неосторожный, неопытный, **Ариунхишиг хүүхэд шиг** ~ Ариунхишиг наивна как ребёнок, ~ хүн наивный человек, ~ санаа, бодол наивные мысли

ГЭНЭХЭН довольно наивный, достаточно легковерный

ДЭЭРЭЭС 1) сверху, 2) из-за, вследствие, так как, потому что, ~ **тав дахь мөр** пятая строка сверху, ~ **доошоо хүртэл** сверху до низу, **ном** ~ **нь тавь** положите книгу сверху, **гэр түүнийг мэдээгүй** ~ **хийгээгүй** он не сделал этого, так как не знал, **ийм дээрээс** из-за этого

ДЭЭС (эн) 1) волосная верёвка, 2) верёвочный, 3) скакалка (детская игра), ~ **томох** вить верёвку, ~ **ни чөдөр** волосная тренога, ~ **ни дөрөөтэй гарах** с грехом пополам, выйти из тяжёлого положения, ~ **ни дөрөөн дээр дэнжигтэх** делать что-либо с риском для жизни, находится на краю пропасти

ДЭЭШ выше, вверх, наверх, свыше, ~ **харах** смотреть вверх, ~ **өргөх** поднять вверх, ~ **гарах** подниматься вверх, ~ **доошоо** вверх и вниз, **зуугаас** ~ свыше ста, больше ста

ДЭЭШЛҮҮЛЭХ *побуд.* от дээшлэх, поднимать, повышать, улучшать, **хөдөлмөрийн бүтээмжийг** ~ повышать производительность труда, **нэр хүндийг** ~ повышать престиж/авторитет, **хүн амын амьдралын түвшинг** ~ повышать жизненный уровень населения, **мэргэжлээ** ~ повышать свою квалификацию, **хариуцлагыг** ~ повышать ответственность, **чанарыг** ~ повышать качество

ДЭЭШЛЭЛТ улучшение, повышение, **ард түмний аж байдлын** ~ повышение благосостояния народа

ДЭЭШЛЭХ подниматься, повышаться, улучшаться, **тушаал** ~ повышаться по службе, **нэг** ~, **нэг доошлох** то повышаться, то понижаться

ДЭЭШЭЭ выше, вверх, наверх, свыше

ЕВРАЗИ Евразия

ЕВРЕЙ еврей, еврейский

ЕВРОП 1. Европа, 2. европейский, **баруун** ~ Западная Европа, ~ **тив** европейский континент/материк, **европ боловсрол** европейское образование, ~ **ын хамтын нийгэмдэг** Европейское сообщество, ~ **хүн европеец**, ~ **туулай заяц русак**, ~ **ын бух гөрөөс зубр**, ~ **ын уулын цэцгий** трясогузка горная европейская

ЕВРОПШУУ европеизированный, европейского типа

ЕГИПЕТ Египет, египетский

ЕГЗӨР 1. йогачария - буддийская философская школа, 2. искусственный, умудренный

ЕГӨГДӨХ *страд.* от егөх, испытывать на себе действие чего-либо, подвергаться чему-либо, ухудшаться

ЕГӨӨ ирония, ироническое отношение к кому-, чему-нибудь

ЕГӨӨДӨХ иронизировать, относиться с иронией, насмехаться, ~ **ж хэлэх** сказать что-нибудь с иронией, ~ **сон санаа/утга** иронический смысл

ЕГӨӨДҮҮЛЭХ *побуд.* от егөөдөх, подвергаться иронии, быть объектом насмешки, оказываться объектом иронии

ЕГӨӨЛӨХ выражать иронию, заключать в себе иронию, иронизировать, **тэр дандаа** ~ **ж байдаг** он ведь всегда подшучивает

ЕГӨӨТЭЙ иронический, ~ **харлулт** иронический ответ, ~ **инээмсэглэл** ироническая/насмешливая улыбка

ЕГӨХ ехидничать

ЕГҮҮТГЭХ истреблять, репрессировать, уничтожать

ЕМБУУ слиток серебра

ЕР 1. 1) совсем, абсолютно, никогда, 2) обычно, вообще, 3) обычный, обыкновенный, **тэр ~ нь тийм** он вообще такой, ~ **бусын** необыкновенный, необычный, **би түүнийг** ~ **хараагүй** я никогда не видел его

ЕР (эн) 2. девяносто, **бүгд** ~ **байна** все девяносто, ~ **н хонь** девяносто овец

ЕРГӨӨ тихая рысь

ЕРДИЙН обычный, обыкновенный, простой, ~ **хэрэг** обычное дело, обычный случай, ~ **олонхи** простое большинство, ~ **хөсөг гужевой** транспорт

ЕРДӨӨ 1. вообще, 2. только, всего, никогда, **би** ~ **хоёр зуун доллартай** у меня всего навсего двести долларов

ЕРДҮГЭЭР девяностый, ~ **зүйл** девяностая статья

ЕРДЭХ девяностый, ~ **хоног** девяностые сутки

ЕРӨНДӨГ 1. колпачок, *мед.* спираль, ~ **тавих** установить спираль (противозачаточную), 2. ~ **чанар** противоположность

ЕРӨНХИЙ общий, генеральный, главный, ~ **болоасрол** общее образование, ~ **тойм** общий обзор, общее представление, ~ **чиг шугам** общая линия, ~ **хамрал** общий кризис, ~ **дүн** общая сумма, общая сложность, ~ **мэдлэг** общие знания, кругозор, ~ **газар** главное управление, ~ **консул** генеральный консул, ~ **эмч/инженер** главный врач/инженер, ~ **нягтлан бодогч** главный бухгалтер, ~ **төлөвлөгөө** генеральный план, ~ **сайд** премьер-

министр, ~ **шүүгч** главный судья, верховный судья, **НҮБ-ын** ~ **нарийн бичгийн дарга** генеральный секретарь ООН, ~ **аргил муз.** генерал бас, ~ **зогсоц** генеральная пауза

ЕРӨНХИЙДӨӨ в общем и целом, вообще, ~ **зөв** в общем правильно, ~ **тэр зөвшөөрч байна** в принципе он согласен

ЕРӨНХИЙДӨХ станивиться/оказываться слишком общим

ЕРӨНХИЙЛӨГЧ президент, дэд ~ вице-президент, ~ **нийн зарлиг** указ президента, ~ **томилох албан тушаалтнууд** должностные лица, назначаемые президентом

ЕРӨНХИЙЛӨХ делать в общих чертах, обобщать

ЕРӨӨЛ 1. пожелание, желание блага, 2. судьба, участь, ~ **тавила** судьба, участь, ~ **өөр учрах** встретиться волею/по воле судьбы, ~ **айлтгах** совершать заупокойную молитву (службу)

ЕРӨӨЛТ совершаемый волею судьбы, имеющий определенную участь

ЕРӨӨЛЧ еролчи, человек, произносящий благопожелание

ЕРӨӨХ 1. желать блага, произносить пожелание, 2. проносить тост

ЕРТӨНЦ мир, свет, вселенная, **орчлон** ~ вселенная, **бүх** ~ **нийн таталцал** всемирное тяготение, **гадаад/дотоод** ~ **внешний/внутренний** мир, **шим** ~ органический мир, ~ **ийн үүсэл** происхождение мира, ~ **ийн гурав** монгольская стихотворная форма, ~ **вйг үзэх үзэл** мировоззрение, ~ **ийн мөнх бусыг үзүүлэх** отойти в вечность, умереть, ~ **ийн Эзэн Господь** (библ.)

ЕРҮҮЛ (ээ) все девяносто, **бид** ~ **гарын үсэг зурсан** мы, все девяносто человек, подписали

ЕРЭНТЭЭ девяносто раз

ЕРЭЭД 1. около девяноста, 2. по девяносто

ЕС (ен) девять, ~ ~ **өөр** по девять, ~ **н** ~ **наян** нэг девятью девять восемьдесят один, ~ **н зуу** девятьсот, ~ **н жорын юм** всякая всячина, ~ **ваах устар.** азыскивать с виновного штраф в размере 9 голов скота, ~ **барих (өргөх)** подносить высокопоставленным особам богатые дары по какому-либо случаю, ~ **эхлэх** время наступления настоящих зимних холодов *приблизительно*: крещенские морозы

ЕСДҮГЭЭР девятый, ~ **бүлэг/хуудас** девятая глава/страница, ~ **сарын нэгэн** девятое сентября

ЕСӨН 1. девять, 2. девятый день, девятое число, ~ **эрдэнэ** девять драгоценностей: (золото, серебро, кораллы, жемчуг, и т.д.) имеющих сокровенное значение. (Кладутся по обычаю в гроб покойника.) ~ **хөлт туг** знамя войск Чингис хана

ЕСҮҮЛ (ээ) все девять, вдевятьером, *муз.* нонет

ЕЭ *межд.* ах, ох, эх, ~ **чааваас!** ах как жаль!

ЕЭВЭН род печенья

ЕЭЖГЭР корявый, искривлённый

ЕЭЖИЙХ становиться корявым, оказываться нескладным, искривляться

ЕЭЗГЭР корявый, искривлённый

ЕЭТГЭР изогнутый, дугообразный, кривой, ~ **хамар** курносый

ЕЭТГЭРДЭХ быть слишком изогнутым

ЕЭТИЙХ быть изогнутым, кривиться, гнуться, изгибаться, ~ **сэн хамартай** с вздёрнутым носом

ЁВГОР вытанутый/суженный кверху, конусообразный
ЁВИРГОН резкий, грубоватый, властный
ЁВРОО толчок, удар (напр. кулаком)
ЁВРОЛДООН *разг.* потасовка, драка, толкотня, толчея
ЁВРОЛТ толчок, удар
ЁВРОЛДОХ *взвзм.* от ёврох, толкаться, драться, пихаться
ЁВРОН: дээд ~ иадмышелок
ЁВРОХ ткнуть, ударять, бить, толкать, пихать, подтолкнуть, тохойгоор ~ подтолкнуть/пихнуть локтём, үгээр ~ задевать словами
ЁВУУР палка, которой подталкивают, бильярдный кий
ЁВЧИХ *многочр.* от ёврох, подталкивать, тыкать, давать тумака, ударять
ЁВЧОО грубый, резкий, ~ хүн грубый человек
ЁВЧУУР грубиян
ЁГ: хэг ~ гэх/хийх а) ёкнуть, ёкать, б) упрямиться, в) запинка
ЁГТ иносказательный, аллегорический, эзоповский, скрытый, ~ үлгэр басня, ~ үг аллегория, иносказание, ~ хэлээр/үгээр ярих говорить эзоповским языком/иносказаниями
ЁГТЛӨЛ иносказание, аллегория, тэр ярихдаа/яриаидаа ~ хэрэглэх дуртай он любит употреблять в своей речи иносказание
ЁГТЛӨХ говорить иносказательно, иронизировать, насмеяться
ЁДОР шест на могиле
ЁЖ ехидство, насмешка, язвительность, сарказм, ~ үг ехидные/язвительные слова, сарказмы
ЁЖГҮЙ иесхидный, неязвительный
ЁЖИРХОХ говорить ехидно, зло иронизировать, ехидствовать
ЁЖИРХУУ любящий ехидствовать
ЁЖЛОМТГОЙ ехидный, язвительный
ЁЖЛОХ поступать саркастически, ехидничать, язвить, зло иронизировать, тэр ер нь юм болгоныг ~н тохуурхаж байдаг юм он вообще над всем ехидничает, издевается над всеми
ЁЖТОЙ 1) ехидный, язвительный, ядовитый, едкий, саркастический, 2) притворный, лицемерный, ~ егөөдөл едкая ирония, ~ нээд едкая усмешка, язвительная насмешка
ЁЗООР основание, корень, шүдний ~ корень зуба, тарнаны ~ жнивье
ЁЛ *зоол.* ягнятник, бородач (птица), тас ~ гриф
ЁЛБОГОР дряхлый, дряблый, вялый, мягкий
ЁЛБОЙХ дрябнуть, вянуть
ЁОГҮЙ обязательно, наверняка, надёжно, за гэвэл ~ хүн хозяин своего слова, надёжный, безотказный человек
ЁЛОЙХ быть вялым, оказываться дряблым, 2) тускло светиться, бүдэг гэрэл цөнхоор ~ж байв в окне мерцал слабый свет
ЁЛХГОР отвислый, ~ гэдэстэй пузатый, с отвислым животом
ЁЛХОГНОХ двигаться, шевелиться (об отвислых животе, грудях)
ЁЛХОЙХ отвисать, становиться отвислым, быть пузатым
ЁЛХОЛЗОХ двигаться, шевелиться (об отвислых животе, грудях)
ЁЛЦГОР дряблый, вялый
ЁЛЦОЙХ дрябнуть, вянуть, чувствовать себя вялым, становиться слабым
ЁМБОГОНОХ часто двигаться/шевелиться (о чём-либо выступающем)
ЁМБОГОР выпуклый, выступающий вперёд
ЁМБОЙХ быть выпуклым, сильно выдаваться, выступать тупым углом

ЁНДГОНОХ двигаться (об угловатых предметах)
ЁНДОЙХ выступать, торчать, выдаваться
ЁНЗОН титул наставника – учителя высших лам
ЁНХ вмятияи, выбоина
ЁНХИГОР худой, сухошавый, тощий, костлявый, ~ чавганц костлявая старуха
ЁНХИЙХ становится долговязым/худошавым, худеть, хилеть
ЁНХОГОНОХ 1. часто двигаться (о впалых глазах, худом человеке), 2. *перен. разг.* быть грубым, вести себя грубо
ЁНХОГОР впалый, глубоко сидящий
ЁНХОР 1. впалый, глубоко сидящий, ~ нүд глубоко сидящие глаза, 2. хлопкосырец, ~ өөдөн бархат
ЁНХОР 2. ~ утас шелковая иить
ЁНХОЙХ быть впалым, глубоко сидеть (о глазах), хацар нь ~ж орхижээ у него щęki впали
ЁНШГОЙТ *устар.* китайский доллар с изображением Юнь Шикая
ЁО *межд.* выражает боль ой-ой-ой, ~ гэх ойкать, стон
ЁОГ йога
ЁОЗ 1. манера, вид, форма, внешний вид, наружность, ~ маяг манера, внешний вид, байгаа ~ нь манера вести себя, манера держать себя
ЁОЗ 2. игральная косточка в два очка
ЁОЗГҮЙ непристойный, недостойный, скверный, плохой, неважный, негодный, ~ этгээд скверный человек, ~ хэрэг недостойный/скверный поступок, ~ эд/даавуу плохая материя, ~ морь негодный конь, ~ зан гаргах вести себя скверно, быть непристойным, ~ юм ярих/хэлэх сквернословить, говорить что-то неприличное
ЁОЗТОЙ ничего, неплохой, вполне возможный/приемлемый, приятенький, ~ санал приемлемое предложение
ЁОЛК ёлка, праздник
ЁОЛООН стон, стенания
ЁОЛОХ стонать, стенать, ~ дуу стон, ~н гинших охать, стонать
ЁОТОН сахар-рафинад, кусковой сахар, колотый сахар
ЁОТУУ мотыга, кайло
ЁОХОР бурятский хоровод
ЁОЧИН ёочин (монгольский национальный музыкальный инструмент)
ЁР предзнаменование, плохой признак, знак, рок, сайн ~ хорошее предзнаменование, хороший знак, муу ~ болох служить дурной приметой, ~ын тохиолдол роковая случайность
ЁРГИО 1. хвастливый, легкомысленный, 2. самодурство
ЁРГИХ хвастаться, кичиться, самодурствовать
ЁРДГОНОХ шевелиться, двигаться (о торчащем предмете)
ЁРДГОР торчащий, выступающий, высовывающийся, длинный, остроконечный, ~ мод длинная палка
ЁРДОЙХ торчать, высовываться, оттопыриваться
ЁРДОЛЗОХ часто двигаться, шевелиться (о торчащем, высовывающемся предмете)
ЁРЛОХ предвещать/предзнаменовать плохое, муу ~ предвещать плохое, предчувствовать плохое, предрекать
ЁРОГ холст, полотно, льняные ткани
ЁРООЛ 1. дно, днище, доице, 2. основа, подошва, ~д нь на дне, аяганы ~ дно чашки, уулын ~ подошва горы, ~д хүрэх достать до дна, ~ыг уудлах находить первопричину
ЁРООЛГҮЙ бездна, бездонный, глубокий, непостижимый, ~ нүх/сав бездонная пропасть/бочка

ЁРООЛДОХ 1. держать посуду снизу/с дониой стороны, 2. приближаться ко дну/к основанию, **аяга** ~ а) держать пиалу снизу, б) долго сидеть и пить много чая

ЁРООЛЛОХ 1. делать дно, 2. ехать/идти по нижнему склону горы

ЁРЧ вещун, предсказатель

ЁС общепринятое правило, обычай, традиция, ~ **заншил** нравы, обычай, традиция, ~ **журам** порядок, нравственность, ~ **суртахуум** нравственность, ~ **суртахууны хохирол** моральный ущерб, **шударга** ~ справедливость, **боловсон** ~ культурность, культура, **тахимдуу** ~ учтивость, **хууль** ~ закон, законность, **албан** ~ны **баримт бичиг** официальный документ, **албан** ~ны **айлчлал** официальный визит, ~ыг **баримтлах** придерживаться обычая, соблюдать общепринятое правило, ~ **гүйцэтгэх** выполнять обряд, выполнить церемонию, ~ **төдий** формально, **манай** ~оор/**заншил** ~оор по нашему обычаю, ~ **ёмбогор төр төмбөгөр** *приблизительно*: закон есть закон, ~ **эцгийн эрхт** патриархат, ~ **мэддэггүй** (~ үл мэдэх) хүнд ёр халддаггүй нарушающему обычаю по незнанию судьба простит (обычно об иностранцах), ~ **бусвар хурьцал үйлдэх** совершение полового акта в извращенной форме, садизм

ЁСГҮЙ 1. не должно быть, не следует, быть не может, 2. не знающий обычая, не соблюдающий правил приличия

ЁСЗҮЙ этика, этикет

ЁСЛОГЧ приветствующий, с приветом, с уважением, с почтением – слово в конце письма «за сим остаюсь...»

ЁСЛОЛ церемония, обряд, ритуал, **баяр** ~ праздник, торжество, ~ын **хувцас** парадная одежда, ~ын **буудлага** салют, ~ын

үдэшлэг торжественный вечер, ~ын **хэлтэс** протокольный отдел, ~ **төгөлдөр тэмдэглэх** торжественно отмечать, ~ын **уулзалт** аудиенция, протокольная встреча

ЁСЛОХ отдавать честь, приветствовать, козырнуть, оказывать почести, салютовать, **мэхийн** ~, ~н **хүндэтгэх** кланяться

ЁСООР согласно чему-либо, в соответствии с чем-либо, по, **хууль** ~ **шийтгэх** наказывать по закону, **тушаал** ~ согласно приказу, ~ **болгох** сделать как положено, удовлетворить (просьбу)

ЁСОРХОХ вести себя педантично, быть формалистом, педантом, церемониться

ЁСОРХУУ церемонный

ЁСТ знающий обычай/правила, придерживающийся обычая/традиции

ЁСТОЙ 1. должен, должно, надо, иадо, иадобно, необходимо, 2. настоящий, действительный, поистине, **тэр чамд бичих** ~ он тебе должен иапнсать, ~ **алт** настоящее золото, **тэр** ~ **сайн хүн** он действительно хороший человек, ~ **эр хүн** настоящий мужчина, **энэ** ~ **зөв** это действительно правильно

ЁСЧЛОХ придерживаться принятых правил, выполнять согласно общепринятым нормам, действовать согласно правилам, поступать по обычаям, следовать обычаям

ЁХ *межд.* ох, ~ **ядарч байна** ох устал, ~, **яасан гоё юм бэ?** ах, как приятно!

ЁХИР неласковый, исприветливый, недружелюбный, суровый, ~ **өвгөн** неласковый/суровый старик

ЁХЛОХ охать, стонать

ЖАА 1. *междометие выражает согласие в знак почёта*: хорошо, слушаюсь, ладно, ~ *хийе* хорошо, сделаю, *жаа мэдлээ* хорошо, понял, ~ *гүйцэтгэе* слушаюсь, есть!

ЖАА 2. вид игры в домино

ЖААЗ 1. 1) рама, рамка, 2) полка, этажерка, *зургийн* ~ рамка для картины/портрета

ЖААЗ 2. брак, дефект, ~ мал бракованный скот

ЖААЗЛАХ 1. вставлять в рамку, *зураг* ~ вставить фотографию в рамку

ЖААЗЛАХ 2. браковать, признавать дефекты, *бараа* ~ браковать товары

ЖААЛ 1. маленький, 2. немного, мало, *ие* очень много, 3. ребёнок, младенец, малютка, ~ *хүү* маленький мальчик, мальчуган, мальчишка, ~ *азная* подождем немного, *бид* ~ жуул юм идсэн мы немного перекусили

ЖААХАН 1. маленький, 2. немного, ~ *хүүхэд* маленький ребёнок, *та* ~ *удаан ярина уу?* говорите, пожалуйста, медленнее

ЖАВ *бот.* горичник

ЖАВАР 1. ветерверховник, 2. холод, стужа, *өглөөний* ~ утренний мороз, ~ *ны нь* гаргах подогреть, согреть, ~ *үргээх эр хүн дутах* нет милого, который бы согрел и приласкал, *гудамжны* ~ *тас няс янагийн халуун 40 градус (Д.Нацагдорж)* на улице стужа, а милая пышет жаром в 40 градусов

ЖАВАРЛАГ холодный, студёный

ЖАВАРЛАХ дуть (о ветре), *голын хөндийгөөс* ~ ветер с долины рек

ЖАВХАА величие, великолепие, блеск, пышность, *өнгөцөг* ~ блеск

ЖАВТИЙ *рел.* омовение, ~ *хүртэх* получать порицание тавлять список имен, *Ганбат Эвлэлийн Төв Хороог* ~ сан Ганбат «построил» ЦК ревсомола

ЖАВХААГҮЙ не блестящий, не имеющий величия

ЖАВХААТАЙ грациозный, великолепный, блестящий, величественный, ~ эр блестящий парень, великолепный мужчина

ЖАВХАЙХ выглядеть блестяще/великолепно, быть величественным, оказываться блестящим

ЖАВХАЛЗАХ двигаться грациозно и легко (о человеке со стройной фигурой), быть подтянутым

ЖАВХЛАН величие, великолепие, величавость, грандиозность, *сүрдөг* ~ мощь, величие, могущество, *цөг* ~ т... его величество...

ЖАВХЛАНГҮЙ не имеющий величия, не блестящий, невеличественный, неграндиозный

ЖАВХЛАНТАЙ величавый, величественный, великолепный

ЖАВШААН удача, успех, удобный случай, хороший повод, *ашиг* ~ выгода, польза

ЖАВШААНЧ человек, который ждёт случая чем-либо воспользоваться, пройдоха, проходимец

ЖАВШААНЧЛАХ искать случая воспользоваться чем-либо, ждать случая чем-либо воспользоваться

ЖАВШИХ 1. присваивать, 2. становиться выгодным, воспользоваться случаем, приносить пользу

ЖАГСААЛ шествие, строй, ряд, линейка, парад, манифестация, *сүрт* ~ демонстрация, *морьт* ~ конный строй, ~ *ын бэлтгэл* строевая подготовка, ~ *д оруулах* вводить в строй, ~ *аар явах* идти строем, идти в шеренгах, ~ *ын гүн* глубина строя

ЖАГСААЛГ список, *нэрсийн* ~ список имен, *экспортын барааны* ~ список экспортных товаров

ЖАГСААХ 1. построить в ряд, выстраивать в ряды, ставить в строй, 2. составлять список, *цэрэг* ~ выстраивать солдат в ряды

ЖАГСАХ выстраиваться, строиться в ряды, стоять в строю, образовывать строй/колонну, *жаг!* стройся!

ЖАД копьё, пика, штык, ~ *шидэлт* метание копья, ~ *лан угтах/эсрүүгүцэх* встретить в штыки (враждебно), *туялзуур* ~ шпага

ЖАЗ джаз, ~ *хөгжим* джазовая музыка

ЖАЙВГАР кривой, ~ *таваг* неровная тарелка

ЖАЙВИЙХ кривиться, искривляться

ЖАЙЖГАР кривой, искривлённый, косой

ЖАЙЖГАНАХ часто двигаться (о кривом предмете)

ЖАЙЖИГ кривой, неправильной формы

ЖАЙЖИЙХ кривиться, становиться кривым

ЖАЛГА овраг, лог, ложе, распадок, ~ *ын амсар дээр* на краю оврага, *хөндийн* ~ ложе долины, ~ *ын ёроолд* на дне оврага, ~ *ын үзэл* местнические взгляды

ЖАЛХ величие, пышность, великолепие, блеск, ~ *муутай харагдах* выглядеть нездоровым, выглядеть не совсем хорошо

ЖАМ закон, *байгалийн* ~ закои природы, ~ *ёсны эрх* неотъемлемое право

ЖАМЦ: ~ *давс* каменная соль, галитит

ЖАМЪЯ: ~ *мадаг бот.* купальница азиатская

ЖАН 1. соя (приправа)

ЖАН 2. мера длины в 10 локтей

ЖАНЖИН 1) главнокомандующий, полководец, 2) генеральный, главный, *бүх цэргийн* ~ главнокомандующий всеми видами вооружённых сил, ~ *штаб* генеральный штаб, ~ *шугам* генеральная линия

ЖАНЖЛАХ командовать, приказывать, иметь власть над кем-либо, господствовать, ~ *үзэл* гегемония, гегемонизм

ЖАНЖУУ лавр

ЖАНРАЙСЭГ: *Мэгээд Жапрайсэг* — статуя Будды в Улан-Баторе

ЖАНЧ балахон

ЖАНЧИХ бить, избивать, устраивать порку, *зодож* ~ избивать, ударять

ЖАНЧУУЛАХ *нобуд.от* *жанчих*, быть избитым

ЖАНЧУУР дубина, палица

ЖАР (аи) шестьдесят, ~ *тай хүн* шестидесятилетний человек, «-и ес» машина УАЗ 469

ЖАРААД 1. около шестидесяти, 2. по шестьдесят, ~ *оны үед* в шестидесятые годы

ЖАРААХАЙ рыбешка, *далайн* ~ хамса

ЖАРАВГАНАХ кокетничать, кривляться

ЖАРАН шестидесятилетие, цикл летоисчисления в шестьдесят лет

ЖАРАС минога

ЖАРВАЛЗАХ кокетничать, кривляться

ЖАРГААХ делать счастливым, осчастливить

ЖАРГАЛ счастье, блаженство, наслаждение, *аз/зол* ~ счастье, ~ *цэнгэл* наслаждение, *аз* ~ *ерөөх* пожелать счастья, ~ *даахгүйн* зовлон муки от невозможности переизнести счастье

ЖАРГАЛАН счастье, удача, блаженство, наслаждение

ЖАРГАЛАНТ счастливый, радостный, удачный, ~ *нрээдүй* счастливое будущее

ЖАРГАЛАНТАЙ счастливый, радостный

ЖАРГАЛГУЙ несчастливый, несчастный
ЖАРГАЛТАЙ счастливый, радостный, счастливо, радостно, ~ аж төрөх жит счастливо, быть счастливым
ЖАРГАХ 1. быть счастливым, наслаждаться, *амар сайхандаа* ~жээ *приблизительно*: жили долго и счастливо
ЖАРГАХ 2. гаснуть, заходить, закатываться, нар ~в солнце зашло
ЖАРГУУЛАХ *побуд. от жаргах*, осчастливить, делать счастливым
ЖАРДУУГААР шестидесятый
ЖАРТАЙЛГАХ *побуд. от жартайх*, выворачивать веко
ЖАРТАЙХ выворачиваться (о веке глаза)
ЖАРТАЛЗАХ 1. *перен.* кокетничать, кривляться, стронть глазки, 2. даггаты вывернутым веком, водить узкими глазами
ЖАРТГАЙ 1. вывернутый (о веке глаз), 2. *перен.* кривляющийся, 3. узкоглазый
ЖАРТГАНАХ 1. *перен.* кокетничать, кривляться, строить глазки, 2. двигать вывернутым веком, водить узкими глазами
ЖАРТГАР см. *жартгай*, ~ нүдтэй с вывернутым веком, с узкими глазами
ЖАС 1. хозяйство монастыря, 2. ризница
ЖАЯГ канон, устав
ЖЕНДЕР гендерный
ЖИБА разг. шлюха
ЖИВ: ов ~ *парн.* ловкость, хитрость, уловка, хов ~ *парн.* сплетня
ЖИВАА девять миллионов
ЖИВУУЛЭХ *побуд. от живэх*, топить, потопить, онгоц ~ потопить судно
ЖИВХ прокладка, подгузник, салфетка, памперс
ЖИВЭР грудные плавники
ЖИВЭХ тонуть, усанд ~ тонуть в воде
ЖИГ что-либо странное, что-то подозрительное, ~ жуг хийх/гэх сплетничать, перешёптываться
ЖИГД ровный, равномерный, одинаковый, ровно, одинаково, ~ алхаа ровный шаг, ~ хөдөлгөөн равномерное движение, ~ хөгжил равномерное развитие, ~ хуваарилалт равномерное распределение, ~ хуваах разделить на равные части
ЖИГД 2. *бот.* лох, джидда, ~ далавчтан термиты
ЖИГДЛЭХ делать ровным, выравнивать, зам ~н тэгшлэх выравнивать дорогу
ЖИГДРҮҮЛЭХ *побуд. от жигдрэх*, выравнивать, делать ровными
ЖИГДРҮҮЛЭГ муз. температура
ЖИГДРЭХ выравниваться, ~н цэгцрэх систематизироваться
ЖИГНҮҮР паровник, буузница
ЖИГНЭХ готовить, варить на пару, бууз ~ делать бузы
ЖИГТЭЙ странный, чудной
ЖИГУҮР 1) крылья, крыло, 2) *восп.* фланг, *атирааны* ~ *геол.* крыло складки, ~ хөлтөн крылоногие, *шнлжлийн* ~ *геол.* крыло сброса
ЖИГУҮРТ (зи) пернатые, птицы, ~ний судлал орнитология
ЖИГШИГДЭХ *страд. от жигших*, быть отвратительным, олонд ~ вызывать отвращение у других
ЖИГШИЛ отвращение, омерзение, презрение, ~ зэвүүцэл төрүүлэх вызывать отвращение, внушать презрение/отвращение
ЖИГШИХ 1. питать отвращение, не любить, презирать, гнушаться.
ЖИГШИХ 2. становиться робким, пугливым, ~сэн морь пугливая лошадь
ЖИГШИМЭЭР отвратительный, противный, вызывающий отвращение
ЖИГШҮҮЛЭХ *побуд. от жигших*, вызывать отвращение
ЖИГШҮҮР отвращение, неприязнь, омерзение
ЖИГШҮҮРГҮЙ непротивный, неотвратительный

ЖИГШҮҮРТ омерзительный, похабный, мерзопакостный
ЖИГШҮҮРТЭЙ отвратительный, омерзительный, похабный, гадкий, мерзкий, ~ явдал гадкий поступок, ~ хараал мерзкие слова, ругань
ЖИГШҮҮРТЭН мерзавец, негодяй, гад
ЖИГШЭЭХ *побуд. от жигших*, 1) пугать, запугать, 2) вызывать отарашение
ЖИДҮҮ 1. пнхта, 2. пропащий человек, 3. почесуха.
ЖИЖИГ маленький, мелкий, ~ *сажиг зардал* мелкие расходы, ~ хулгай мелкая кража, ~ аж ахуй/үйлдвэрлэл мелкое хозяйство/производство, ~ өмчтөн мелкий собственник, ~ *сажиг засвар* мелкий ремонт
ЖИЖИГДЭХ быть слишком мелким, быть маловатым, энэ гутал надад ~ж байна эта обувь мне маловата
ЖИЖИГЛЭХ размельчать, раздроблять, делить на мелкие части, ~н худалдах үнэ розничная цена, ~н болон бөөний худалдаа розничная и оптовая торговля
ЖИЖИГРҮҮЛЭХ *побуд. от жижигрэх*, делать мелким, размельчать, раздроблять на мелкие части/частицы
ЖИЖИГРЭХ размельчаться, раздробляться, становиться мелким, делаться маленьким
ЖИЖИГХЭН маленький, мелкий
ЖИЖҮҮР дежурный, ~ хийх дежурить, ~ийн эмч дежурный врач, ~ийн хуваарь расписание дежурства, шөнийн ~ ночное дежурство
ЖИЖҮҮРЛЭХ дежурить
ЖИЙНС джинсы
ЖИЙП джип (автомобиль)
ЖИЙРГЭВЧ прокладка, подстилка
ЖИЙРГЭВЧЛЭХ прокладывать, подстилать
ЖИЙРХЭХ 1) чувствовать холодок, 2) негодовать, брезговать, питать омерзение
ЖИЙРЭГ 1) прокладка, подстилка, 2) защита
ЖИЙРЭГЛЭЛТ прокладка, прокладывание, обёртывание
ЖИЙРЭГЛЭХ прокладывать, подстилать, обёртывать чем-либо
ЖИЙРЭХ 1) чувствовать холодок, 2) негодовать, брезговать, питать омерзение
ЖИЙТГАР узкоглазый, ~ нүдтэй с узкими глазами, с прищуренными глазами
ЖИЙХ вытягивать, протягивать, хөлөө ~ вытягивать ноги, дугуй ~ жать на педали
ЖИЛ год, *хичээлийн* ~ учебный год, энэ ~ текущий год, этот год, *ноднин/өнгөрсөн* ~ прошлый год, в прошлом году, *хойтон/ирэх/дараа* ~ будущий год, в будущем году, *өндөр* ~ високосный год, ~ийн өмнө год тому назад, год назад, ~ээс ~д из года в год, ~ийн тайлан годовой отчёт, ~ийн орлого годовой доход, годичный доход, ~ийн хугацаа годичный срок, *гэрлийн* ~ световой год, *хатуу/зоолон* ~ «твёрдые» и «мелкие» годы (по буддийскому календарю), ~ бүр каждый год, ежегодно, ~ийн чөлөө авах брать академический отпуск, ~ийн төлөв годовой бюджет, ~ бүр сунгадаг түрээсийн эрх эзэмшигч владелец на правах аренды с ежегодной пролонгацией, ~ жил благополучный год
ЖИЛБЭ молозиво.
ЖИМ 1. тропа, тропинка, просека, уулын горная тропа, ~ээр/дагаж явах идти/ехать тропой
ЖИМ 2. дёрн
ЖИМИЙХ сжимать/поджимать губы, уруулаа ~гээд суух сидеть с поджатыми губами
ЖИМС плоды, фрукты, ягоды, чихэр ~ сладости, ~ түүх собирать ягоды, ~ний мод фруктовое дерево, ~ний шүүс фруктовый сок, ~ний цэцэрлэг фруктовый сад, ~ний ус фруктовая вода

ЖИМСГЭНЭ ягода, ягоды, **жимс** ~ий плодоягодный, плодовая-годный

ЖИМСЛЭГ обильный фруктами/ягодами, плодonoсый

ЖИМСЛЭХ появляться (о фруктах и ягодах на дереве)

ЖИМСТ плодовой, фруктовый, ~ мод плодовые деревья

ЖИМСТЭЙ плодовой, фруктовый

ЖИМСЭРХЭГ обильный фруктами и ягодами

ЖИН 1. вес, **хувийн** ~ удельный вес, **хүндийн** ~ вес, тяжесть, **амьдын** ~ живой вес, **цэвэр** ~ вес нетто, **савтай/бохир** ~ брутто, **дунд** ~ средний вес, ~ **нэмэх/хасах** прибавить/убавить в весе, ~**гийн үнэмлэх** весовой сертификат

ЖИН 2.: **халуун** ~ согревающий компресс, грелка, **хүйтэн** ~ холодный/охлаждающий компресс, ~ **тавих** положить компресс

ЖИН 3. караван, ~ **тээх** перевозить/транспортировать грузы, заниматься извозом/транспортировкой грузов, **тэмээн** ~ караван верблюдов, ~**гийн цувсаа** караван

ЖИН 4.: ~ **тан хийх/болгох** готовить всё, обеспечивать полную подготовку, ~ **тан боллоо** всё готово, всё «тип-топ»

ЖИН 5. **звукoпoдpажание звону металла**: ~ ~ **хний/дуугарах** звенеть, издавать звои

ЖИН 6. **Жин улс** — династия Цзинь

ЖИНГҮЙДЭЛ невесомость, ~д **байх** находиться в невесомости

ЖИНГҮЙДЭХ быть невесомым

ЖИНГЭНҮҮЛЭХ *побуд. от жингэнэх*, звонить

ЖИНГЭНЭЭ звои, звук, производимый колебанием чего-либо

ЖИНГЭР 1. сука (собака)

ЖИНГЭР 2. **звукoпoдpажание звону металл**: ~ ~**Ихангир** ~ дуугарах звенеть, бряцать

ЖИНДҮҮ 1) холодный, прохладный, произывающий холод, ~ **өдөр** прохладный день, **гадаа** ~ **байна** на улице студёная погода

ЖИНДЭХ подвергаться действию холода, чувствовать холодок

ЖИНЛҮҮР весы

ЖИНС знаки отличия чиновников во время маньчжурского правления, ~т **малгай** шапка со знаками отличия, **гэрэлтэй хөх** ~ 3-ья степень отличия

ЖИНХЭНЭ настоящий, действительный, подлинный, полиоправный, ~ **шалтгаан** действительная причина, ~ **ноос** иастоящая/чистая шерсть, ~ **эх** оригинал, подлинник, ~ **найз** настоящий друг, ~ **гишүүн** действительный член, ~ **ардчилал** подлинная демократия, ~ **саинаа** действительные намерения

ЖИНЧИН караванщик, погонщик

ЖИРВИЙХ быть узкими и ровным, оказываться узеньким и ровненьким, ~**сэн сахал** тонкие, узкие усы, ~**сэн нарийн хөмсөг** тонкие длинные брови

ЖИРВЭГНЭХ мерцать, сиять, мелькать, рябить, одод ~нэ звёзды мерцают

ЖИРВЭГЭР узкий, тонкий, ровный, ~ **сахал** тонкие усы, ~ **хөмсөг** узкие длинные брови

ЖИРВЭЛЭЭХ 1) мерцать, мелькать, 2) двигаться (о чем-либо узком, ровном, изящном)

ЖИРГЭЛТ шebet, шebetание, чириканье, **болжморын** ~ чириканье воробьев, **хараацайн** ~ шebetание ласточек

ЖИРГЭХ 1. шebetать, чириквьт, **шувууд** ~нэ птицы шebetчут

ЖИРГЭХ 2. разделявать на куски, откальвать тонкими кусками, **мах** ~ разделить тушу на куски, **түлээ** ~ раскальвать дрова

ЖИРГЭЭН шebetание, чириканье, шebet

ЖИРИЙН обыкновенный, обычный, простой, рядовой, ~ **ажил** обычная работа, ~ **цэрэг** рядовой солдат, ~ **өдөр** обычный день, ~ **зээлдэгч** обычный кредитор

ЖИРИЙХ мчатся, истись, **чи хаашаа** ~ж явна? куда ты ис-сешься?

ЖИРСХИЙХ мелькнуть, промелькнуть, **ажуугаар** ~и **өнгөрөх** промелькнуть мимо

ЖИНТҮҮ подушка, валик, **өдөн** ~ пуховая подушка

ЖИНТЭЙ весомый, веский, тяжёлый, значительный, ~ **хувь нэмэр оруулах** внести весомый вклад, ~ **үг** веское слово, **хүнд** ~ имеющий тяжёлый вес

ЖИНХЛЭХ становиться настоящим, стать действительным, быть полиоправным

ЖИРХ *зоол.* бурундук, ~ **бялзуухай** амадин, ~н **хүдэр** бурундучная руда

ЖИРЭЛЗЭХ мелькать, мерцать, мчатся, быстро показываться и исчезать

ЖИРЭМ подпруга у седла

ЖИРЭМСЛЭЛТ беременность, ~эс **урьдчилан сэргийлэх** контрацепция, предупреждение беременности

ЖИРЭМСЛЭХ забеременеть

ЖИРЭМСЭН беременная, ~ **эмэгтэй** беременная женщина, ~ **болох** стать беременной, ~ **болгох** сделать беременной, ~ий **тэтгэмж** пособие по беременности

ЖИХАД джихад

ЖИХҮҮН прохладный, свежий, ~ **өдөр** прохладный день, **өнөөдөр** излээд ~ **байна** сегодня довольно прохладно, ~ **салхи** прохладный ветер

ЖИХҮҮРХЭХ чувствовать озноб, ощущать холод, зябнуть

ЖИХҮҮЦЭХ продрогнуть, озябиуть

ЖИЧ 1. особый, отдельный, особо, отдельно, специально, ~ **хэрэг** другое дело, отдельный случай, ~ **мэдэгдэх** сообщать отдельно, информировать специально, **энэ тухай** ~ **ярилцъя** об этом поговорим отдельно, потом

ЖИЧ 2. правнук, правнучка (сын, дочь внука)

ЖИЧИНЦЭР праправнук

ЖИШИГ 1) диаграмма, 2) образец, пример, порядок, обычай, 3) аналог, стандарт, **бусдын** ~гээр **байх/явах** подражать другим, следовать примеру других, **улсын** ~ государственныи стандарт

ЖИШИМ: ~ **гүй байх**, ~ **ч гүй байх** абсолютно не реагировать, не обращать внимания, проявлять иоль внимания

ЖИШИМГҮЙ несравнимый, несопоставимый, **юутай ч** ~ ни с чем не сравнимый

ЖИШИХ 1. предусматривать, заранее запланировать

ЖИШИХ 2. сравнивать, сопоставлять, **хоёр хэмжигдэхүүнийг хооронд нь** ~ сравнить две величины между собой, **нэгийг нөгөөтэй нь** ~ сопоставить одно с другим

ЖИШИХ 3. пойти в сторону от намеченного пути, сбиваться с прямого пути, отклоняться от правильного курса, **бид замаасаа** ~ээд **явчихжээ** мы, оказываемся, сблнсь с прямого пути

ЖИШИШГҮЙ несравнимый, несопоставимый

ЖИШҮҮ косой, иаклонный, диагональный, ~ **шугам** косые линии, ~ **харах** смотреть в сторону/искоса, избегать смотреть на кого-нибудь

ЖИШҮҮДЭХ делаться косым, становиться наклонным

ЖИШЭЭ пример, образец, **үлгэр** ~ **болох** стать образцом, ~ **болгон авах** приводить в качестве примера, **сайхан** ~ **үзүүлэх** показать хороший пример, ~ **авах** брать пример, ~ **нь** например, к примеру, ~гээр **шийтгэх хууль зүй** прецедентное право

ЖИШЭЭГЭЭР по примеру, по образцу, **бусдын** ~ по примеру других

ЖИШЭЭЛБЭЛ к примеру, например

ЖИШЭЭЛЭХ 1) приводить пример, брать в качестве образца/примера, 2) сравнивать, сопоставлять

ЖОВ: ~— ~! **межд.** пошла прочь! окрик, которым отгоняют собак

ЖОЛОО повод, вожжи, руль, баранка, штурвал, бразды правления, **морины** ~ повод, вожжи, **машинны** ~ руль, **онгоцны** ~

штурвал самолёта, ~ барих, ~ мушгих, ~ны ард суух сидеть за рулём, Мөнгөлд машины ~ мушгисан бүх эмэгтэйчүүд маш гоё бүсгүйчүүд шүү в Монголии все женщины за рулём удивительно красивы, ~ татах натянуть поводья, ~ сулруулах отпустить вожжи, ~ны курс водительские курсы

ЖОЛООГҮЙ 1) без поводов, без вожжей, без руля, 2) *перен.* необузданный, неукротимый, ухаан ~ безумный, безумно

ЖОЛООДЛОГО управление, вожделение, руководство, предводительство, мэргэн ~оор под мудрым руководством

ЖОЛООДОГДОХ *страд.* от жолоодох, быть руководимым, оказываться ведомым

ЖОЛООДОГЧ вождь, руководитель, предводитель, хувьсгалын их ~ великий вождь революции

ЖОЛООДОХ 1) править, управлять, руководить, направлять, предводительствовать, 2) водить, управлять, улс орныг ~ править страной, төр ~ управлять государством, машин ~ управлять автомобилем, галт тэрэг ~ водить поезд, ~ эрхийг хасуулах лишать водительских прав

ЖОЛООДУУЛАХ *побуд.* от жолоодох, быть руководимым, ведомым на поводу

ЖОЛООЧ водитель

ЖОМБОГОР 1) выпяченный, выдавшийся, вытянутый (напр. о губах), 2) продолговатый, овальный, ~ хушуутай хурга остроносый/остромордый ягиёнок

ЖОМБОЙХ быть выпяченным/вытянутым, выпячиваться, вытягиваться (о губах)

ЖОМБОЛОХ двигаться, шевелиться (о чем-либо выпячением, вытянутом)

ЖОН: ~ ~ хийх/гэх пншать, говорить пискливым голосом

ЖОНГЛЁРДОХ *разг.* жонглировать

ЖОНОН наследный принц, хан-регент.

ЖОНХУУ клейстер

ЖОНХУУДАХ замазывать клейстером, клеивать

ЖОНШ шпат, хайлуур ~ глиняный шпат, флюорит, хээрийн ~ полевой шпат, шохойн ~ известковый шпат

ЖОМ таракан, ~ны хор средство против тараканов

ЖОТГОНОХ кокетничать, строить глазки

ЖОТОЙХ быть узкоглазым, шуриться, прищурить

ЖОР рецепт, ~өөр эм авах получить лекарство по рецепту, ~ бичих выписать рецепт

ЖОРЛОН туалет, уборная, сортир, нийтийн ~ общественная уборная, ~гийн цаас туалетная бумага

ЖОРЛОХ приготавливать лекарство по рецепту

ЖОРОО 1. бегающий иноходью, ~ морь иноходец

ЖОРОО 2. круговая чаша, чаше всего последняя

ЖОРООЛОХ идти/бежать иноходью (о лошади)

ЖОРООЛУУЛАХ *побуд.* от жороолох, пускать иноходью

ЖӨТӨӨ зависть, агаа ~ төрүүлэх возбуждать зависть в ком-либо

ЖӨТӨӨРХӨГ завистливый, постоянно завидующий, ~ харц завистливые взгляды

ЖӨТӨӨРХӨХ завидовать, ревновать, ~н харах смотреть завистливо

ЖӨТӨӨРХҮҮ завистливый, ~ хүн завистливый человек

ЖӨТӨӨЧ завистник, завистница

ЖУДАГ совесть, облик, душевный склад, характер, ~ сайтай хүн совестливый человек

ЖУДАГТҮЙ бессовестный, безиравственный, эгоистичный, себялюбивый

ЖУДАГТАЙ совестливый, честный, благородный

ЖУДРАЙ маленький, малолетний, желторотый, неопытный

ЖУНГАА *разг.* китаец, китаёза

ЖУРАМ 1. порядок, распорядок, режим, правило, хартия, устав, дотоод ~ внутрений порядок, нийтийн хэв ~ сахиx соблюдать общественный порядок, ~ алдах/зөрчих иарушать порядок, ~д оруулах регламентировать, ~аар по линии, жуулчны ~аар по туристической линии, үл маргах ~ в бесспорном порядке

ЖУРАМ 2. дорожка, ковровая дорожка

ЖУРАМГҮЙ беспорядочный, неупорядоченный

ЖУРАМЛАГДАХ *страд.* от журамлах, быть упорядоченным, быть приведённым в порядок, упорядочиваться, журамлал юр. процедура

ЖУРАМЛАЛТ упорядочение, приведение в порядок

ЖУРАМЛАХ 1. приводить в порядок, упорядочивать, наладить порядок, ~н дагах соблюдать, руководствоваться

ЖУРАМЛАХ 2. регламентировать, ~ хашаа штрафная стоянка для авто транспорта

ЖУРАМТ пристойный, приличный, верный, лояльный, ~ нөхөр соратник, ардын ~ цэрэг иародные ополченцы, ~ эхнэр верная супруга, ~ үүрэг долг, ~ үүрэгт харшилсан протнворечающий моральному долгу

ЖУРАМТАЙ упорядоченный, организованный, с соблюдением порядка, ~ болгох упорядочить

ЖУРНАЛ журнал, ~ хөтлөх вести журнал

ЖУУЛЧИН путешественник, турист, ~ы газар туристическое учреждение, ~ы бааз туристическая база, кемпинг, Жуулчин — название монгольской туристической компании

ЖУУЛЧЛАЛ путешестве, туризм, поездка, дэлхий тойрох ~ кругосветное путешествие, олон улсын ~ международный туризм

ЖУУЛЧЛАХ путешествовать, совершать путешествие, тэр ~ дуртай он любит путешествовать

ЖУУМАЛЗАХ слегка улыбнуться, сдерживать смех, усмехаться

ЖУУХ грамота, итгэмжлэх ~ бичиг барих вручать верительные грамоты, засгийн газрын ~ правительственная грамота

ЖҮЖИГ спектакль, пьеса, яриан ~ драма, хошнн ~ комедия, эмгэнэлт ~ трагедия, бүжгэн ~ балет, ~ тоглох/тавих ставить пьесу, ~ийн хүрээлэн театр

ЖҮЖИГЛЭХ играть в роли, исполнять роль, создавать образ (в спектаклях, пьесах и др.), ставить пьесу/спектакль

ЖҮЖИГЧИН артист

ЖҮЛЧГЭР равнодушный

ЖҮНЗ рюмка, болор ~ хрустальная рюмка, ~ дүүргэх наполнить рюмку

ЖҮРЖ апельсин, апельсиновый, ~ийн шүүс апельсиновый сок, бэрсүүт ~ мандарин

ЖҮРҮР боярышник

ЖҮҮД еврей, еврейский

ЗАА ладно, хорошо, ~ болно а) ладно, хорошо, можно, пожалуй-ста, б) хватит, достаточно, ~ зуу болох договориться, условиться, ~ гэвэл ёогүй байх иазвалса груздем полезай в кузов

ЗААВАЛ непременно, обязательно, ~ дуусгах хэрэгтэй обязательно иадо закончить, ~ биелүүлэх хүчинтэй *юр.* обязательная сила

ЗААВАР инструкция, указание, руководство, предписание, хэрэглэх ~ инструкция по применению, ~ өгөх даватъ указание, ~ зөвлөгөө консультация, совет, инструкция

ЗААВАРЛАГЧ инструктор

ЗААВАРЛАХ инструктировать, даватъ указаниа, советовать, иа-ствалтъ

ЗААВАРЧЛАГА указание, инструкция, памятка

ЗААВАРЧЛАХ поучать, указывать, даватъ указаниа, советовать

ЗААГ рубеж, стьк, граница, межа, пределы, хилийн ~ пограничная линия, ~ ялгаа дифференциация, различие, ~ тогтоох про-водить границу, ажлын ~ дифференциация в работе, ~ шугам демаркационная линия

ЗААГГҮЙ неразграниченный, не имеющий границ

ЗААГГҮЙДЭХ не иметь границы, не зиаъ предела

ЗААГДАХ *страд.* от заах, 1) быть указаниым, указыватъся, 2) приговариватъся, быть приговоренным

ЗААГЛАЛ *геол.* контакт, маагмын ~ контакт магматический, давхаргазүйн ~ контакт стратиграфический

ЗААГЛАЛТ отделение, дифференциация, отмежевание, разделение

ЗААГЛАХ разграничение, разграничивать, дифференцировать, размежевывать, отделятъ

ЗААГТАЙ имеющий границу/дифференциацию, отграниченный, разграниченный, дифференцированный

ЗААГЧ 1) указатель, указательный, указывающий, 2) наставник, зам ~ указатель дороги, проводник, ~ зүү/сум указательная стрелка

ЗААДАЛ шов, паз, соединение, гагнаасын ~ сварной шов, ~аараа салах/ангайх расходиться по швам, ~гүй без шва, Тэнгэрийн ~ Млечный путь

ЗААДАС шов, паз, соединение, захын ~ шов краевой

ЗААЗЛАХ браковать, признавать дефекты

ЗААЗЛАГДАХ *страд.* от заазлах, быть забракованным, брако-ватьсяся

ЗААЗУУР поварской нож, тесак, затесь

ЗААЗУУРДАХ резать сечкой, рубить поварским иожом

ЗААЛ зал, гостиниа

ЗААЛГАХ обучатъся у кого-либо, учиться у кого-нибудь, Ян Хесуг Аюураар орос хэл ~ж байна Ян Хесуг учится у Аюура русскому языку

ЗААЛГУУЛАХ *побуд.* от заалгах, быть обучениым у кого-либо, обращаться за указаниями к кому-нибудь

ЗААЛДАГЧ истец

ЗААЛДАХ *взаимн.* от заах, судиться, иметь с кем-нибудь судебное дело, вести тяжбу, хөршгүйгээ ~ судиться с соседом, давж ~ апеллировать, подаватъ кассацию

ЗААЛТ указание, решение, резолюция, пункт, *жарг.* поручаемая в местах заключения работа, ~ биелүүлэх выполнять решение, ~ гаргах принять резолюцию/решение

ЗААМДАХ схватить за ворот

ЗААН 1. слои, слоювый, ~ы яс слоювая кость, ~ гөрөөс диноте-рийн, ~ы тугал слонёнок, ~ы соёо бивень слона, ~ы Ясан Эрэг Берэг Слоювой Кости

ЗААН 2. борцовский титул 3-ьей степени

ЗААР 1) мускус, 2) резкий запах, хударийн ~ мускус кабарги, ~ын үнэр мускусный запах, ухнын ~ запах козла

ЗААРИН шаман

ЗААРТ мускусный, ~ харх ондатра

ЗААРЦАГ множество кого-чего-либо, уйма, косяк, загасны ~ косяк рыб

ЗААРЬ кастрированный олень (северный)

ЗААХ 1) указывать, показывать, 2) учить, обучать, преподаватъ, зам ~ указать дорогу, хуруугаараа ~ показать пальцем, хичээл ~ даватъ уроки, преподаватъ, хөгжим ~ обучать музыке, гадаад хэл ~ арга методика преподавания иностранного языка, ~ тэмдэг указатель, ~ төлөөний үг указательное местоимение, ~ын тийн ялгал указательный/внимательный падеж, эрүү ~ разжимать челюсть

ЗАВ досуг, свободное время, ~ чөлөө, ~ зай, ~ тух *парн.* свободное время, би ~ муутай у меня мало свободного времени, ~ гаргах/олох выкритить/находить свободное время

ЗАВААН грязный, иеряшливый, безкусный, пресный, ~ гар грязные руки, ~ ажил грязная работа, яасан ~ юм бэ? какая грязь! как пошло!

ЗАВААРАХ 1) становиться грязным, развратичать 2) возитъся с кем-либо

ЗАВАГ щель между войлочной стеной и крышей юрты, залхүү хүн ~таа хүрэхгүй «лень с печки слезть»

ЗАВГУЙ иедосуг, занятый, не имеющий свободного времени, би ~ мие иедосуг, у меня нет времени

ЗАВДАЛ досуг, свободное время, ~ гаргах найти свободное время

ЗАВДАХ 1) успевать, улучать время, 2) собиратъся, готовитъся, намереватъся

ЗАВИЛАХ класть иоги крест-иакрест, скрестить иоги (при сидении), ~н суух сидеть скрестя иоги, поджав иоги

ЗАВОД завод, шаазангийн ~ фарфоровый завод

ЗАВСАР 1) щель, промежуток, интервал, 2) перерыв, пауза, момент, 3) между, зай ~ трещина, зазор, зай ~гүй плотно, без щели, без перерыва, ~ чөлөө свободное время, досуг, ~аяр нь хар хялгасан багтахгүй *приблизительно:* жить в большом согласии, ~ хөгжим иитермедиа

ЗАВСАРДАХ оказыватъся ни там ни сям, оказыватъся без дела, оставатъся без чего-либо, попадатъ куда-либо в перерыв/промежуток, сургууль ~ отсеиватъся, выбыватъ из учебного заведения

ЗАВСАРГҮЙ без промежутка, без щели, без интервала, непрерывный, битком, сплошь, ~ наах заклейт сплошь, без щели

ЗАВСАРДАЛТ перерыв, промежуток, разрыв

ЗАВСАРДМАЛ оказавшийся ни там ни сям, оставшийся в перерыве, промежутке чего-либо

ЗАВСАРЛАГА перерыв, пауза, антракт, перемена, каникулы, перекур, хичээлийн ~ перерыв, перемена между уроками, удийн ~ обеденный прерыв, түр ~ зарлах объявить перекур

ЗАВСАРЛАХ делать перерыв, отдыхать, делать паузу, устраивать перерыв

ЗАВСАРТ 1) в перерыв, мимоходом, между делом, 2) между, 3) между тем как..., в то время когда..., энэ ~ в перерыв этого, хичээлийн ~ между уроками

ЗАВСАРТАЙ имеющий промежуток, имеющий щели/интервалы, с перерывами, щелистый, ~ шал щелистый пол, ~ хийх/лүүлдэх

делать производить с перерывами, ~ үзэх различать, дифференцировать

ЗАВСАРТАХ расщеляться, образовываться (о щели, промежутке)

ЗАВСАРХАЙ шель, шёлка, сквозная трещина, хаалганы ~гаар харах смотреть в щелку двери

ЗАВТАЙ свободный, располагающий свободным временем, имеющий досуг, тэр ~ он свободен, ~ цагтаа в свободное время, в часы досуга

ЗАВТАЙДАА на досуге, в часы досуга, в свободное время

ЗАВТАЙХАН более свободный

ЗАВХАЙ распушенный, распутный, похотливый, развратный, ~ хүн развратный человек, развратник, ~ явдал распутство, распушенность, ~ явах вести распутную жизнь, развратничать, ~ эм шлюха, ~ дуу бластная песня

ЗАВХАЙДАХ становиться распушенным/развратным, становиться пошлым

ЗАВХАЙРАГЧ развратник, распутник

ЗАВХАЙРАЛ распушенность, развратность, развращенность

ЗАВХАЙРАХ развратничать, распутничать, вести разгульную распутную жизнь

ЗАВХАЙРУУЛАХ *побуд.* от *завхайрах*, развращать, делать распушенным, доводить до морального разложения, бусдыг ~ сделать кого-либо развратным, развратить кого-либо

ЗАВХАЙРУУЛАГЧ развратитель

ЗАВХРАЛ уклон, отклонение, искажение, баруунтны алдаа ~ правый уклон

ЗАВХРАХ 1) теряться, пропадать, 2) искажаться, 3) развращаться

ЗАВХРУУЛАГЧ вульгаризатор, уклонист

ЗАВХРУУЛАХ *побуд.* от *завхрах*, 1) терять, 2) сбивать с правильного пути, развращать, 3) искажать, вульгаризировать, онолыг/сургаалыг ~ искажать/вульгаризировать теорию/учение

ЗАВХУУЛ 1) потерявшийся, заблудившийся (о скоте), 2) бродяга, проходимец, ~ мал потерявшийся скот, ~ этгээд бродяга

ЗАВЧЛАХ выбирать подходящее время, улучать момент, находить время

ЗАВШААН возможность, шанс, удача

ЗАВШИХ присвоение, присванвать

ЗАВЬ лодка, шлюпка, аврах ~ спасательная шлюпка, усан доогуур яваг ~, шумбадаг ~ подводная лодка, моторг ~ моторная лодка, уралдааны ~ гоночная лодка, ~иар явах кататься на лодках, ~иар гатлах переправляться на лодке

ЗАВЬЖ углы/уголки рта

ЗАГ 1. *бот.* саксаул, ~н/-ийн шугуй саксауловый лес, саксауловая роща

ЗАГ 2. *мед.* гонорея, гнойные выделения при гонорее, ~ хүйтэн гонорея

ЗАГАЛМАЙ 1. крест, улаан ~ нийгэмлэг общество Красного Креста, ~тны ариун дайн крестовый поход

ЗАГАЛМАЙ 2. *зоол.* клёст, ~т могой уж гладкий

ЗАГАЛМАЙЛАХ креститься (у христиан), ~сан эцэг крестный отец, *перен.* мафиози

ЗАГАС рыба, рыбный, ~ барих ловить рыбу, ~нд явах поехать на рыбалку, ~ агнуур рыбный промысел, рыбная ловля, ~ны дэгээ рыболовный крючок, ~ны тор невод, ~ны түрс икра, ~ны үйлдвэр рыбная промышленность, ~ны орд созвездие Рыб, ~ наадуулах играть в любовные игры, заниматься любовью

ЗАГАСЧИН рыбак, рыболов

ЗАГАСЧЛАХ рыбачить, заниматься рыбной ловлей, ловить рыбу

ЗАГАСЧЛУУЛАХ *побуд.* от *загасчлах*, устраивать рыбалку, организовать рыбную ловлю

ЗАГАТНАА зуд, ~гий нь гаргах а) избавить кого-либо от зуда, б) *перен.* удовлетворять чье-либо сильное желание, ~гий нь

гаргах удовлетворить желание, Амраа амрагийнхаа ~г гаргаххаас хэзээ ч татгалзахгүй Амраа всегда готов удовлетворить желание любовницы

ЗАГАТНАХ зудеть, чесаться, ~сан газар маажсан юм шиг *приблизительно:* как бальзам на душу

ЗАГАТНУУЛАХ *побуд.* от *загатнах*, вызывать зуд

ЗАГАТНУУР чесотка, почесуха (болезнь)

ЗАГВАР модель, образец, форма, выкройка, ханцуйн ~ выкройка рукава, эзэлхүүнт ~ объёмная модель, ~ өмсөгч модель, манекен, ~ өмсөх демонстрация мод

ЗАГВАРЛАХ придавать форму, вид, делать выкройку

ЗАГВАРЧЛАЛ моделирование, математикийн ~ математическое моделирование

ЗАГЗАЙХ быть коренастым, ствновиться плотным

ЗАГЗГАР коренастый, низкорослый, приземистый

ЗАГИНАХ ругать, порицать, бранить, кричать, хүүхэд ~ порицать ребёнка

ЗАГНАХ 1. 1) ругать, кричать, бранить, порицать, 2) вести себя, поступать, проявлять свой характер, уурлаж ~ ругать, кричать, харааж зүхэж ~ бранить, проклинать, ругать

ЗАГНАХ 2. подбить, пришить подметку к обуви

ЗАГСААХ *побуд.* от *загсах*, давать остынуть, студить

ЗАГСАХ застывать, остывать, сүү ~ж байна молоко остывает

ЗАД 1. *частица усиления при глаголах со значением:* совершенно, вдребезги, часто соответствующая приставкам раз-, из-, ~ татах а) разломать, б) разорвать, ~ цохих а) разбить вдребезги, б) сильно избить, ~ гишгэх растаптывать, ~ загиннах/аашлах заругать, изругать, ~ угаах отмыть добела

ЗАД 2. иенастьё, непогода

ЗАДАРХАЙ открытый, раскрытый, распечатанный, обнажённый

ЗАДГАЙ 1) открытый, раскрытый, 2) заброшенный, бесконтрольный, салан ~ байдал расхлябанность, заброшенный, неаккуратность, ~ газар открытое место, ~ шаахай босоножки, ~ мөнгө мелочь, ам ~ несдержанный на язык, болтливый, говорливый, ~ хатир рысь-аллюр

ЗАДГАЙДАХ быть открытым, раскрытым

ЗАДГАЙЛАХ раскрывать, открывать, делать более открытым/раскрытым, делать более удобным

ЗАДГАЙРАЛ дезорганизованность, расхлябанность, бесхозяйственность

ЗАДГАЙРАХ 1) раскрываться, открываться, 2) *перен.* распускаться, разваливаться, дезорганизовываться, становиться недисциплинированным

ЗАДГАЙРУУЛАХ *побуд.* от *задгайрах*, 1) раскрывать, открывать, 2) *перен.* распускать, разваливать, дезорганизовывать

ЗАДЛАГ анализ, аналитический, ~ арга метод анализа, аналитический метод, ~нийлэг арга аналитико-синтетический метод

ЗАДЛАГДАХ *страд.* от *задлах*, быть распечатанным/раскрытым, раскрываться, распечатываться

ЗАДЛАЛ анализ, разбор, распечатка, вскрытие, өгүүлбэрийн ~ хийх делать разбор предложения

ЗАДЛАЛТ раскрытие, распечатание, вскрытие

ЗАДЛАХ раскрывать, распечатывать, вскрывать, развёртывать, боодол ~ развёртывать пакет, архи/шилтэй юм ~ раскупорить бутылку, нууц ~ выдавать/разболтать секрет, мөнгө ~ разменять деньги, ~н шинжлэх анализировать, хүүр ~ вскрытие тела

ЗАДЛУУЛАХ *побуд.* от *задлах*, давать вскрывать, позволять открыть, разрешать распечатать, мөнгө ~ дать деньги на размен

ЗАДРААГҮЙ нераскрытый, нераспечатанный

ЗАДРААХ *побуд.* от *задрах*, нууц ~ разглашать секрет/тайну, выдать тайну

ЗАДРАХ 1) раскрываться, развязываться, распечатываться, 2) разваливаться, распадаться, 3) *перен.* стать недисциплинированным, *ува* ~в узел развязался, *нууц* ~чээ тайна, секрет стали известными, ~*сан жаал* избалованный ребёнок

ЗАДРУУЛАХ *побуд.* от *задрах*, раскрывать, разглашать, развязывать, распечатывать, вскрывать

ЗАЖЛАХ жевать, разжёвывать, *бохь* ~жевать жевательную резинку, *мах* ~разжевывать мясо

ЗАЙ 1. 1) пространство, промежуток, интервал, 2) расстояние, дистанция, ~ *завсар/чөлөө* свободное время, *ойрын/холын* ~ближняя/дальняя дистанция, ~ *эзлэх* занимать место, ~ *тавих* расступаться, ~ *гаргах* дать место, выделять место, ~ *олох* найти место, ~ *үлдэх* оставлять место, ~ *н шатны тоо муз.* тоновая величина интервала, «~ *өгөөч/тавнач*» пропустите, дайте место, дороги

ЗАЙ 2. элемент, батарея, *хуурай* ~сухой элемент, *нарны* ~солнечная батарея, *машины* ~*хураагуур* аккумулятор автомобиля

ЗАЙ 3. хитрость, уловка, ~ *нхтэй хүн* очень хитрый человек

ЗАЙГУУЛ бродячий, странствующий, ~ *хүн* бродяга

ЗАЙГҮЙ 1. 1) неместительный, 2) занятый, не свободный, 3) не имеющий промежутков/щели, *зав* ~ *байх* не иметь свободных мест, *хөл тавих* ~яблоку упасть негде

ЗАЙГҮЙ 2. очень близкий, интимный, открытый, тесный, ~ *найзууд* неразлучные/очень близкие друзья

ЗАЙГҮЙДЭХ не иметь свободных мест, не вмещаться

ЗАЙДАН без седла, неосёдланный, ~ *морь унах* ехать на неосёдланном коне

ЗАЙДАС кровяная колбаса, сардельки, сосиски

ЗАЙДЛАХ 1) ехать верхом без седла, 2) *перен.* садиться на чём-либо у кого-либо, *тэмээ* ~садиться на верблюда без седла, *хүзүүн дээр* ~садиться на шею кому-нибудь

ЗАЙДУУ на некотором расстоянии, на определённой дистанции, в отдалении, ~ *буух* остановиться подальше от кого-чего-либо

ЗАЙДУУХАН чуть подальше, далекоавато

ЗАЙЛАХ 1. полоскать, *усанд* ~полоскать в воде, *ам* ~полоскать рот

ЗАЙЛАХ 2. освобождать место, сторониться, отходить, отстраняться, *цавшаа зайл!* уберите прочь! уходите! *замаас* ~уступать дорогу, *оргож* ~убежать

ЗАЙЛСХИЙГЧ *юр.* лицо, уклоняющееся от чего-либо

ЗАЙЛСХИЙХ уклоняться, удаляться, избегать, *уулзахаас* ~уклоняться от встречи, *хариулахаас/хариуцлагаас* ~уклоняться от ответа/от ответственности, *ажлаас* ~уклоняться от работы, *нийтгэлээс* ~избегать наказания, *татвар төлөхөөс* ~уклоняться от уплаты налогов

ЗАЙЛУУЛ бедный, несчастный, *хөөрхий* ~*хөөрхий* бедный, бедняжка

ЗАЙЛУУЛАХ 1. *побуд.* от *зайлах*, заставляя полоскать

ЗАЙЛУУЛАХ 2. *побуд.* от *зайлах*, устранять, отстранять, удалять, *тушаалаас* ~устранять от должности, *ажлаас* ~увольнять с работы

ЗАЙЛУУГҮЙ 1) непременный, неизбежный, 2) непременно, неизбежно, ~ *нөхцөл* непременно условие, ~ *худалдаа* вынужденная продажа

ЗАЙМРАХ 1) податься в сторону, уклоняться, отклоняться, 2) покачиваться, колебаться

ЗАЙМРУУЛАХ *побуд.* от *займрах*, 1) уклонять, отклонять, 2) покачивать, колебать

ЗАЙР шуга, ~ *гүйх* покрываться шугой

ЗАЙРАН шаман

ЗАЙРМАГ 1) мороженое, 2) тоненький лёд, *шоколадтай* ~шоколадное мороженое, ~ *тогтох* покрываться тоненьким льдом

ЗАЙРМАГТАХ покрываться тонким льдом, *шөндөө голын* ус ~*ж байв* ночью вода в реке покрывалась тонким слоем льда

ЗАЙСАН титул западно-монгольских ханов

ЗАЙТАЙ 1. 1) шёлковый, промежуточный, 2) имеющий свободное место, обширный, просторный, ~ *өрөө* просторная комната

ЗАЙТАЙ 2. хитрый, ловкий, ~ *хүн хитрый* человек

ЗАЙЧЛАХ находить свободное место, выделять свободное место для кого-чего-нибудь

ЗАЛАА 1. кисточка на головном уборе, гребень у птиц, ~ *нь гозойх* возгордиться, ходить петухом (гоголем)

ЗАЛАА 2.: ~ *баг цэцэг бот.* метёлка

ЗАЛАА 3. колос, *тарнаны* ~колос

ЗАЛАА 4. толстая шёлковая нить

ХАЛЦЛАХ обдирать, сдирать, снимать, **модны холтос** ~ обдирать кору с дерева
ХАЛЦРАХ становиться редким (о волосах, шерсти), облезать, вылезать, выпадать, **будаг** ~ **в** краска облезла
ХАЛШРАХ не решаться приступить к чему-либо, не осмеливаться, робеть, тяготиться, уклоняться, **хүйтнээс** ~ бояться мороза, **уулзахаас** ~ уклоняться от встречи, не решаться встретиться с кем-либо
ХАЛЬС 1. оболочка, кожница, кожура, корка, плева, шелуха, скорлупа, **онгон** ~ девственная плева, **жүржний** ~ апельсиновая корка, **үрийн** ~ оболочка семян, **өндөгний** ~ скорлупа яйца, **ясны** ~ надкостница
ХАЛЬС 2. плёнка, фото, **соронзон** ~ магнитная плёнка
ХАЛЬТ *частица, выражающая неполное мимолётное движение:* мнмоходом, мнмолётно, мельком, слегка, бегло, поверхностно, еле-еле, небрежно
ХАЛЬТИРГАА скльжение, скользкое место
ХАЛЬТРАХ поскользнуться, скользить, ~ **ч** унах поскользнуться и упасть, **хэл** ~ оговариваться, говорить неправильно
ХАМ 1.: ~ **гарал** парагенезис, ~ **үүсэл** парагенерация, **зохицолын** ~ **шинж** адапционный синдром, **сульдлын** ~ **шинж** синдром неврастениц (астения), **эртгэлийн хөдлөлийн** ~ **шинж** психомоторное возбуждение, **хий үзэгдэл дэмийрлийн** ~ **шинж** синдром галлюцинации — параноя (бредовая идея), **догширол хөшилтийн** ~ **шинж** синдром агрессивности и ступора, **хүүдэрхэн тэнгэлэх** ~ **шинж** слабоумие, шизофрения, **ухамсарт ухаан өөрчлөгдөх** ~ **шинж** расстройство сознания, **өвчирхөг** ~ **шинж** синдром болезненного состояния
ХАМ 2. аккорд, ~ **ын эгшгүүд** аккордовые тона, ~ **эгшгийн зүй** аккордка
ХАМ 3.: гал ~ корш
ХАМАА отношение, касательство, принадлежность, ~ **тай болох** иметь **ХАМХУУЛ 1)** *бот.* «перекати-поле», 2) ветренный, легкомысленный, непостоянный, **чи яасаи** ~ **шинг хүн бэ!** какой ты непостоянный человек!
ХАМААГҮЙ не имеющий значения, безразличный, **энэ чамд** ~ это тебя не касается, ~ **хүн а)** посторонний человек, б) фамилярный человек
ХАМААНДАЛАХ командовать
ХАМААРАГДАХ *страд. от хамаарах*, относиться к кому-, чему-либо, иметь касательство/принадлежность к чему-либо, принадлежать, **уул хэрэгт энэ** ~ **гүй** это к данному делу не относится
ХАМААРАГЧ: хэргийг түр ~ временный поверенный в делах
ХАМААРАЛ отношение, принадлежность, касательство, зависимость
ХАМААРАХ 1) касаться, относиться, принадлежать, иметь отношение/связь с кем-, чем-нибудь, 2) замещать кого-либо, выполнять обязанность, **энэ танд** ~ **гүй** это не относится к вам
ХАМААРУУЛАХ *побуд. от хамаарах*, привлекать к участию, вовлекать, охватывать других
ХАМААТАН родственник, **эцгийн талын** ~ родственник по отцу, **хольны/ойрын** ~ дальний/близкий родственник
ХАМААТУУЛАХ: ~ **төлөөний нэр** местоименне принадлежностн, ~ **нөхцөл** аффикс принадлежности
ХАМАГ 1) все, всё, 2) самый, ~ **юм** все вещи, ~ **ийн сайн/муу** самый хороший/плохой, наилучший/наихудший, ~ **ийн нх/бага** самый большой/маленький, ~ **ийн түрүүнд** прежде всего, ~ **ийн**

сүүлд, эцэст в самом конце, **~ийн чухал** самый важный, **~ийн сонин** самый интересный, **~ийн хэцүү** самый трудный, **~ийн хялбар**, **амархан** самый лёгкий, **~ийн хямд/үнэтэй** самый дешёвый/дорогой

ХАМАР 1. 1) нос, 2) носок, **моихор** ~ горбатый нос, **~ын нүх** ноздря, **~ын үзүүр** кончик носа, **~ын тамхи** нюхательный табак, **гутлын** ~ носок сапога, **~аа сөхөх** задира́ть нос

ХАМАР 2. холм, возвышение

ХАМАР 3.: ~ **өвчин вет. сап**

ХАМАР 4.: ~ **хашаа** смежный двор

ХАМАР 5. (хамар цаас) лист, **дэвтрин** ~ хуудас лист из тетради

ХАМАХ загреба́ть, сгребать, подбирать, собирать что-либо на большой площади, в больших объёмах, **өвс** ~ сгребать сено, **хог** ~ подбирать сор

ХАМБА 1.: ~ лам высший сан в монгольской ламаистской церкви, патриарх, епископ, настоятель

ХАМБА 2. первосортный шёлк

ХАМГААЛАГЧ защитник, охранитель, охранник, **бие** ~ телохранитель, **хөл бөмбөгийн** ~ защитник (в футболе), **зих тайвныг** ~ защитник мира, **гал** ~ предохранитель (электрический)

ХАМГААЛАЛ охрана, защита, оборона, **хөдөлмөр** ~ охрана труда, **байгаль** ~ охрана природы

ХАМГААЛАЛТ защита, охранение, оборона, **иргэний** ~ гражданская оборона, **~аас давшилтад орох а)** перейти от обороны к наступлению, б) переход от обороны к наступлению, **~ын бүс** охранный зона

ХАМГААЛАХ защищать, оборонять, охранять, **эх орноо** ~ защищать родину, ~ **барилга байгууламж** оборонительные сооружения, **батлан** ~ **арга хэмжээ** оборонные мероприятия, **эрх ашгаа** ~ защищать свои интересы, **эрдмийн зэрэг** ~ защищать учёную степень, **байгаль орчныг** ~ охрана окружающей среды, **эх нялхсыг** ~ охрана материнства и младенчества, **жирэмсэлтгээс** ~ предохраняться от беременности

ХАМЖИХ делать что-либо совместно, действовать общими усилиями, **пособлять**, **делая сообща**, **выполнять общими силами**, **помогать**, **приходить на подмогу**

ХАМРАГДАХ *страд. от хамрах*, охватываться, вовлекаться, привлекаться, включаться, распространяться

ХАМРАХ охватывать, привлекать, вовлекать, включать

ХАМСАА: **хань** ~ соучастник, сообщник, сателлит

ХАМСААТАН сообщник, соучастник, **хэрэгтнийг** ~ **ы нь хамт баривчлах** задержать преступника с его соучастником

ХАМСАХ совместно действовать, делать что-либо сообща, присоединяться, объединяться, прилагать свои усилия к усилиям других

ХАМТ вместе, ~ **олон коллектив**, **~ын ажиглагаа** сотрудничество, **~ын чармайлт** совместное усилие, **~ын баталгаа** коллективная гарантия, **~ын гэрээ** коллективный договор, **~ын нэхэмжлэл** групповой иск, **нөхдийн** ~ вместе со своим товарищами, **Тусгаар Тогтисон Улсуудын** ~ын **Нө-хөрлөл** Содружество независимых государств (СНГ)

ХАМТАРСАН совместный, соединённый, объединяться, соединяться, сотрудничать, ~ **хуралдаан** совместное заседание

ХАМТАТГАХ объединять, соединять, присоединять

ХАМТДАХ: ~ын **орд** созвездие Ближнецов

ХАМТЛАГ коллектив, ансамбль, труппа

ХАМТРАЛ колхоз, колхозный

ХАМТРАЛЖУУЛАЛТ коллективизация

ХАМТРАЛЖУУЛАХ *побуд. от хамтралжих*, коллективизировать

ХАМТРАХ объединяться, соединяться, сотрудничать, ~и **зүтгэгч** соратник, ~и **зохиох** соавторство, ~и **өв залгамжлагч** сонаследник, ~и **эээмшигч** совладелец

ХАМУУ честка, ~ны **хачиг** зуд чесоточный

ХАМХИХ прикрывать, закрывать, **уруулаа** ~ поджать губы, **гараа** ~ сложить руки, не работать

ХАМХУУЛ 1) *бот.* «перекати-поле», 2) ветреный, легкомысленный, непостоянный, **чи яасан** ~ **шиг хүн бэ!** какой ты непостоянный человек!

ХАН: ~ **боргоой** ананас, ~ **гарьд** мифическая птица, «гаруда»

ХАНА стена, решётчатая стенка юрты, **чулууи** ~ каменная стена, ~ны **сонин** стенная газета, ~ны **цаг** стенные часы, ~ын **шүүгээ** стенной шкаф

ХАНАГАР 1) исполинский, огромный, очень большой, крупный, широкий, 2) зажиточный, состоятельный, удовлетворённый, ~ **уудам тал** обширная степь, ~ **гэр** большая юрта, ~ **эрийг хангахад амар юм болов уу?** легко ли удовлетворить мужчине гигантского телосложения (богатыря), ~ **айл** зажиточная семья

ХАНАМЖ удовлетворение, удовлетворённость, удовольствие

ХАНАМЖГҮЙ неудовлетворённый, недовольный

ХАНАМЖТАЙ удовлетворённый, довольный, **сэтгэл** ~ **байх** быть довольным, оказаться удовлетворённым

ХАНАНЦАР стенка, холоодны ~ стенка желудка

ХАНАХ 1. быть довольным, быть удовлетворённым, получать удовлетворение, удовлетворяются, **сэтгэл** ~ **довольствоваться**, **получать удовольствие**, **нойр** ~ **выспаться**, **чи ~сан уу?** ты получила удовольствие?

ХАНАХ 2. пускать кровь, делать кровопускание

ХАНГАДАХ *страд. от хангах*, снабжаться, обеспечиваться, удовлетворяются

ХАНГАЙ 1. 1) хангай (гористая и лесистая местность, обильная водой и плодородием), 2) хангайский, ~и **ууле** хангайские горы

ХАНГАЙ 2. «~и нохой» табунированное имя волка

ХАНГАЛ необъезженный, необученный (о лошади), буйный, неистовый, ~ **адуу** необъезженная лошадь, ~ **хүн** неистовый человек

ХАНГАЛГА: **гар** ~ мастурбация

ХАНГАЛТ удовлетворение, обеспечение, снабжение, ~ **муутай** плохо обеспеченный, с плохим снабжением

ХАНГАЛТГҮЙ неудовлетворительный, недостаточный, необеспеченный, неудовлетворительно, недостаточно, плохо, необеспеченно, **шалгалтад** ~ **бэлтгэх** недостаточно подготовиться к экзаменам

ХАНГАЛТТАЙ удовлетворительный, достаточный, довольный, удовлетворительно, достаточно, довольно, ~ **гэж үзэх** считать достаточным/удовлетворительным, ~ **харнулт** удовлетворительный ответ, ~ **үндэслэл** достаточное основание

ХАНГАЛУУН довольный, удовлетворительный, **сэтгэл** ~ **байх** быть довольным/удовлетворённым, ~ **сайхан амьдрах** жить счастливо и зажиточно

ХАНГАМЖ обеспеченность, снабжение, **нийгмийн** ~ социальное благосостояние, **цусан** ~ кровоснабжение, **усан** ~ водоснабжение, **матерналлаг** ~ матерьяльная обеспеченность, матерьяльное благосостояние, **хүнсний** ~ продовольственное снабжение

ХАНГАХ удовлетворять, исполнять, обеспечивать, снабжать, **болзлыг** ~ удовлетворять условия, **хүсэлтийг** ~ удовлетворять просьбу, **шаардлага** ~ удовлетворять/отвечать требованиям, **аюулгүй байдлыг** ~ обеспечивать безопасность

ХАНГИНАХ 1. звенеть, звучать, раздаваться, **хөгжим** ~на звучит музыка

ХАНГИНАХ 2. порнчать, журить, **аав намайг** ~лаа отец меня журил

ХАНГИНАХ 3. пахиуть, бить в нос
ХАНГИНУУР 1) звенящий, звонкий, 2) проворный, ловкий, ~ сүх плотничий топор, ~ залуу проворный парень
ХАНГИР *эукоподр.* ~ чингэр хийх издавать лязг, бряцать
ХАНД настойка, экстракт, жимсний ~ ягодный экстракт
ХАНДАХ обращаться, относиться, подходить, направляться, сайхан ~ хорошо обращаться, эсрэг ~ бить против кого-, чего-либо
ХАНДГАЙ лось, сохатый, лосиний, ~н арьс лосина, ~н эвэр лосиные рога, хашир ~ тертый калач
ХАНДЛАГА обращение, отношение, тенденция, направление, гол ~ главная тенденция, буруу ~ неправильный подход
ХАНДИВ вклад, пожертвование, лепта, придача, өчүүхэн нэмэр ~ оруулах внести свой скромный вклад/свою лепту, нэмэр ~ вклад, ~лагч донор, инвестор, финансирующая организация, ~лагч орнууд страны-доноры
ХАНДЛАХ делать иастой, готовить настойку/экстракт, настаивать
ХАНДУУЛАХ обращать, направлять, анхаарал ~ обращать внимание
ХАНЗ 1. иероглиф, Фатима ~ бичиг маш сайн мэднэ Фатима очень хорошо знает иероглифическую письменность
ХАНЗ 2. лежанка, нары
ХАНЗЛАХ 1) пороть, распарывать, 2) вскрывать, распечатывать, оёдлоор нь ~ разрезать по швам
ХАНЗРАХ пороться, распариваться, оёдлоороо ~ рваться по швам
ХАНИАД грипп, кашель, хамрын ~ насморк, ~ хүрэх заболеть гриппом, бөгшүүлдэг ~ коклюш
ХАНИАЛГАХ кашлять, цусаар ~ кашлять кровью
ХАНИАЛГА кашель, хуурай ханиалга сухой кашель
ХАНИАХ кашлять, хуурай ~ кашлять сухим кашлем
ХАНИЛАХ 1) сходиться, сожительствовать, подружиться, 2) дружить, быть другом, оказываться спутником, идти/ехать вместе, ~ж явах идти вместе, ~н суух соединить судьбу, жениться
ХАНТААЗ жилет, безрукавка
ХАНХАЙ 1. пустой, свободный, ~ гэр пустая юрта, небогатая мекбэлю юрта
ХАНХАЙ 2. ~ эмээл вьючное седло
ХАНХАЙ 3. шахм. ладья
ХАНХАЙХ 1. быть широкоплечим
ХАНХАЙХ 2. оказываться пустым и неудобным
ХАНХАЛЗАХ двигать/шевельить широкими плечами
ХАНХАР могучий, огромный, громадный, широкий, богатырско-го телосложения
ХАНХЛАХ пахнуть, благоухать, сарнай цэцгийн сайхан үнэр ~на розами приятно пахнет, архи ~ нести водкой, спиртным
ХАНХУУ принц
ХАНЦУЙ рукав, ~ шамлах засучить рукава
ХАНЦ 1. курс, цена, валюта, албан ёсныхоо ~аар нэг доллар 1000 төгрөг орчимтой тэнцэнэ по официальному курсу один доллар равняется приблизительно 1000 тугрикам, ~ буурах девальвация, понижение курса, мөнгөний ~ уналт инфляция
ХАНШ 2. дружелюбие, отзывчивость
ХАНЬ друг, подруга, муж, жена, ~ бүл супруги, супружеская чета, ~ нөхөр а) муж, б) друг, друзья, ~ хамсаатан соучастник, сообщник
ХАР 1. 1) чёрный, тёмный, 2) злой, коварный, тас ~, хав ~ чёрный-пречёрный, ~ нүд чёрные глаза, ~ талх чёрный хлеб, ржаной хлеб, ~ тамхи опиум, наркотик, ~ мах постное мясо, мясо без жира, ~ цай чай без молока, ~ шөл мясной суп, ~ шороо

чернозём, ~ чавга чернослив, ~ мод лиственница, ~ хэрээ ворон, ~ санаа злой умысел, коварство, ~ ухаанаар бодоход еслн судить по-простому, ~ зах чёрный рынок, ~ санах, ~ буруу санах злумышлять, иметь злос намерение, ~ дарах видеть кошмары во сне, ~ тэнгис Чёрное море, ~ мөрөн река Амура
ХАР 2. простой, обычный, физический, грубый, ~ ажил чёрная работа, ~ ажилчин чернорабочий, ~ усаа балгачих напиться, налзаться, ~ ярианы хэл просторечие, разговорный язык, ~ хүн муж, ~ тодол скворец обыкновенный, ~ хүчээр при помощи грубой силы, ~ амиа бодох проявлять эгоизм, ~ болох а) ствновиться чёрным, б) делаться грязным, пачкаться, в) ствь мирянином, ~ галуу казарка, ~ өрөв тас анст чёрный, ~ байван железный купорос, ~ тугалга свинец, ~ болор геол. морион, ~ халтмар, геол. шерл, ~ занар геол. чёрные сланцы, ~ төмөрлөг чёрные металлы, ~ гэртэй хаан, бор гэртэй богд *приблизительно*: дома н стены помогают
ХАР 3. ревность, подозрение, ~ ихтэй эхнэр ревнивая жена, ~тай нөхөр ревнивый муж, ~ авах подозревать кого-либо
ХАРАА 1) зрение, поле зрения, 2) *перен.* наблюдение, подозрение, хүүхэн ~ зрачок, нүдний ~ сайтай/сайн байх иметь хорошее зрение, ~ны ш'л очки, бусдын ~нд байх находиться под наблюдением посторонних, быть под подозрением
ХАРААГҮЙ 1) не зрячий, слепой, 2) не видели, не заметилн, ~чүүдийн сургууль училище для слепых, ~ болох слепнуть, терять зрение, стать незрячим, би түүнийг ~ я его не видел, чи Сэлэнгээг ~ биз? ты не видел Сэлэнгэ? Америкт яасан шүү дээ! Да она же в Америку уехала!
ХАРААЛ проклятие, ругательство, брань, ~ тавих ругать, бранить, ~ын үг ругательные слова, бранные слова, бөөгийн ~ шаманское проклятие
ХАРААЛГАХ быть обруганным
ХАРААЛЧ сквернослов, проклинатель (лама, шаман)
ХАРААТ зависимый, зависший от кого, чего-либо, вассал, подчинённый, ~ байдал зависимость, зависное положение, ~ улс вассальное государство
ХАРААХ бранить, ругать, ругаться, поносить, сквернословить, проклинать, бүдүүлэг үгээр ~ поносить кого-либо грубыми словами
ХАРААХАН 1) ещё не ..., пока ещё, 2) как только, только что, тэд нар ~ ирээгүй л байна онн пока ещё не приехали
ХАРААЦАЙ ласточка, алтан ~ ласточка деревенская, үхэр ~ касатка, ~ загас рыба летучая, ~ багадаа в молодые годы
ХАРАВТАР черноватый, темноватый, ~ өнгө темноватый цвет
ХАРАГДАХ *страд. от* харах, виднеться, показываться, быть видным, оказываться доступным для взора, ~аа болих, ~гүй болох исчезать из виду, залуу ~ выглядеть молодым, тооноор ~ тэнгэр небо, виднеющееся сквозь дымник юрты, итгэж ~аач *разг.* думашь, поверю
ХАРАГЧ чёрная (о масти самок домашних животных), ~ үнээ чёрная корова
ХАРАЙЛТ прыжок, өндрийн/уртын ~ прыжок в высоту/в длину, тулгууртай ~ прыжок с шестом, гурвын ~ тройной прыжок
ХАРАЙХ прыгать, босон ~ вскочить с места, буун ~ соскочить, спрыгнуть, шуудуун дээгүүр ~ прыгнуть через траншею
ХАРАЛГАН 1) подслеповатый, близорукий, 2) недалёковидный, ~ бодлого иедалёковидная политика
ХАРАЛДАА 1) приблизительноый, приблизительноно, одинаковый, 2) приблизительноно, параллельно, симметрично, пвраллельный, симметричный, нас ~ приблизительноно одинакового возраста, ~ хаалга параллельная дверь, ~ зохиомж муз. контрапункт
ХАРАМ скупой, жадный, ~ сэтгэл скупость, зависть

ХАРАМГҮЙ не скупясь, не жалея, **сэтгэл** ~ тусламж бескорыстная помощь

ХАРАМЖ вознаграждение, ответная услуга, **шан** ~ *парн.* вознаграждение за что-либо, ответный подарок

ХАРАМЛАХ 1) скупиться, жадничать, скрадничать, 2) беречь, жалеть

ХАРАМСАЛ сожаление, досада, ~ **төрөх** испытывать сожаление, ~ **төрүүлэх** вызвать досаду/сожаление

ХАРАМСАЛТАЙ жалкий, жалобный, досадный, жалко, жаль, досадно, ~ **явдал** досадный случай, неприятный поступок, ~ **нь** к сожалению

ХАРАМСАХ сожалеть, вызвать досаду, жалеть, досадовать, **би тэр эр хүнтэй учирсан явдалд** ~ юм байхгүй я ннчуть не сожалею, что судьба свела меня с этим мужчиной, залуудаа хайр дурлалын ид шидийг амсаагүй явсандаа ~ жалеть о том, что в молодости не вкусил(а) всех тайнств любви, хувь заяандаа ~ **н** гомдох досадовать на свою судьбу

ХАРАМЧ скряга, скупой, жадный, **мөнгөнд** ~ скупой/скуп на деньги, ~ **хүнд нөхөр хол ногоо.** от скряги друзья далеки, ~ **хүн хоёр удаа мөнгө төлдөг** скупой платит дважды

ХАРАНГА 1. гонг, ~ **цохих/дэлдэх** ударить в гонг, **түгшүүрийн** ~ дэлдэх бить тревогу

ХАРАНГА 2. название ламанского ритуала

ХАРАНГАДАХ изнемогать, ослабевать от голода и жажды

ХАРАНДАА карандаш, **балын/хорын** ~ простой/химический карандаш, **будгийн, өнгийн** ~ цветной карандаш, ~ **үзүүлэх** чинить карандаш

ХАРАНХҮЙ 1) темнота, тьма, мрак, потёмки, 2) тёмный, невежественный, 3) скрытый, иеясный, подозрительный, ~ **шөнө** тёмная ночь, **шөнийн** ~ **д/гаар** во мраке ночи, в ночной темноте, ~ **будүүлэг хүмүүс** невежественные люди, ~ **хэрэг** тёмное, подозрительное дело, ~ **будлиан** неясный, подозрительный инцидент, ~ **өрөө** тёмная комната

ХАРАНХҮЙДАХ стаивиться чересчур тёмным, темнеть, делаться слишком мрачным

ХАРАНХҮЙЛАХ загораживать свет, затемнять, стать тёмным, становиться мрачным, **тэнгэр** ~ **н** небо потемнело

ХАРАХ 1) видеть, смотреть, глядеть, 2) смотреть, присматривать, ухаживать, ~ **эрхтэн** органы зрения, **дэвшээ доошоо** ~ смотреть вверх и вниз, **буруу** ~ отворачиваться, **цонхоор** ~ смотреть в окно, **дагуулан** ~ смотреть вслед, **урагшаа** ~ смотреть вперёд, **хулгай нүдээр** ~ поглядывать искоса, **хүүхэд** ~ смотреть за ребёнком, **өвтгөн** ~ ухаживать за больным, **морь** ~ сходить в туалет, сходить «до ветру», ~ **ж хандах хүн** проявляющий заботу

ХАРВАА (н) стрельба из лука, **сур** ~ **н** состязание (соревнование) в стрельбе из лука

ХАРВААЧ стрелок из лука, лучник

ХАРВАЛТ стрелять, пускать

ХАРВАХ стрелять из лука, **сур** ~ стрелять из лука, **нуужин** ~ запускать ракету, **од** ~ падение звезды, **цус** ~ кровонзлияние, **чавхаар** ~ стрелять из катапульты, ~ **сан сум шиг** (быстрый) как выпущенная стрела

ХАРВИН подбрюшный жир

ХАРГАА 1) причина, последствие, следствие чего-либо, 2) из-за, из-за того что, вследствие, по причине, **өвчнийн** ~ **гаар** из-за болезни

ХАРГАЛДАХ конфликтовать, сталкиваться, вступать в противоречие, соперничать, **Эрдэнэтэд бидний ашиг сонирхол** ~ **в** наши интересы столкнулись в Эрдэнэте

ХАРГАЛЗАГЧ надзиратель, надсмотрщик

ХАРГАЛЗАХ учитывать, принимать во внимание, присматривать, надзирать, **хүсэлтийг** ~ **н** учитывая желание/просьбу, ~ **н** дэмжигч попечитель, ~ **н** дэмжилт попечительство

ХАРЖИГ 1) жестокий, свирепый, лютой, зверский, 2) реакционный, ~ **хэргийг** жестокий, деспотический, ~ **хүчин** реакционные силы, ~ **дэглэм** реакционный режим, ~ **хэргийг** явдал жестокость

ХАРГИСЛАЛ реакция, зверство, жестокость

ХАРГИСЛАХ подвергать реакции/жестокости, проявлять жестокость, деспотизм

ХАРГУЙ путь, дорога

ХАРГУЙ 1) неровный, 2) добродушный

ХАРДАХ ревновать, подозревать, **эхнэрээ, нөхрөө өөр хүнтэй** ~ ревновать жену к другому, мужа к другой, **хулгайд** ~ подозревать в краже

ХАРДЛАГА ревность, подозрение, ~ **сэрдлэгэ** *парн.* подозрение, преследование, ~ **төрүүлэх** вызвать подозрение

ХАРИЛЦАА отношение, связь, взаимоотношение, контакт, сношение, **олон улсын** ~ международные отношения, **гадаад** ~ внешне связи/сношения, **дипломат** ~ дипломатические отношения, **худалдаа эдийн засгийн** ~ торговые и экономические связи/отношения, **соёлын** ~ культурные связи, **сайн хөршийн** ~ добрососедские отношения, **агаарын** ~ воздушная связь, **зам** ~ средства коммуникации, ~ **тогтоох** устнавливает связь/отношения, ~ **гаа таслах** порвать связь, разорвать отношения, ~ **тасалдах** прекращение отношений

ХАРИЛЦАХ иметь контакты, быть в связи, сноситься, относиться, ~ **н** адил взаимность, ~ **н** адилгүй отличающенся, ~ **н** ойлголцох понимать друг друга, взаимопонимание, ~ **н** ойлголцлын санамж бичиг протокол (меморандум) о взаимопонимании, ~ **н** туслалцах помогать друг другу, взаимопомощь, ~ **н** туслалцах гэрээ договор о взаимопомощи, ~ **н** бие биеэ хүндэтгэх уважать друг друга, взаимное уважение друг друга, ~ **н** зөвшөөрөлдөх прийти к взаимному/обоюдному соглашению, ~ **н** ашигтай хамтын ажиллагаа взаимовыгодное сотрудничество, ~ **н** буулт хийх прийти к компромиссу, ~ **н** тохиролцох обоюдное согласие, ~ **данс** текущий счёт, **захидлаар** ~ переписываться с кем-либо

ХАРИЛЦУУР трубка телефонного аппарата, ~ **авах** взять трубку

ХАРИМАЛ стареющий, немолодой, ~ **бөх** стареющий борец

ХАРИМХАЙ: **уян** ~ **биетүүд** упругие, эластичные тела, ~ **чаанар** упругость, гибкость, эластичность

ХАРИН однако, только, но, а, ~ **ээ!** однако ж..., **дайга** подумать, ~ **ч** **гайгүй болсон** однако не плохо получилось

ХАРИУ ответ, ответный, **захидлын** ~, ~ **захидал** ответное письмо, ~ **айлчлал** ответный визит, ~ **арга хэмжээ** ответные меры, ~ **цохилт** ответный удар, ~ **авах** а) получить ответ, б) мстить, ~ **өгөх** давать ответ, ~ **хэлэх** отвечать, ~ **илгээх/явуулах** отправлять/посылать ответ, **бодлогын** ~ ответ на задачу, ~ **гаа** **авах** взять реванш

ХАРИУГҮЙ 1) безответный, 2) плохой, некудышный, неважный, плохо, неважно, **бие** ~ **байх** чувствовать себя плохо, неважно, ~ **туранхай** очень тощий/худой

ХАРИУЛАХ 1. отвечать, **асуулгад** ~ отвечать на вопросы, **ачийг** ~ отблагодарить, оплатить за услугу, **мөнгө** ~ давать сдачу

ХАРИУЛАХ 2. возвращать, давать обратно

ХАРИУЛАХ 3. пасти, **мал** ~ пасти скот

ХАРИУЛАХ 4. ослаблять, распускать

ХАРИУЛГА выпас, выгон скота на подножный корм, **малын** ~ **маллагаа** *парн.* уход за скотом, выпас скота на отгонном пастбище

ХАРИУЛТ 1. ответ, **асуулт** ~ вопрос и ответ

ХАРИУЛТ 2. сдача, ~аа авах получить сдачу, ~гүй өгөх дать без сдачи

ХАРИУЦАГЧ ответчик, ~ мэдүүлэг өгөхөөс татгалзах отказ ответчика от дачи показаний, ~аар татах привлекать в качестве ответчика

ХАРИУЦАХ 1. нести ответственность, отвечать, толгойгоороо ~ отвечать головой, өөрийн үйлдлийг ~ ответить за свои дела

ХАРИУЦАХ 2. противодействовать, препятствовать

ХАРИУЦЛАГА ответственность, ответ, ~ хүлээх нести ответственность, взять на себя ответственность, ~д татах призвать кого-либо к ответу, првлекать к ответственности, ~ыг дээшлүүлэх повысить ответственность, ~ ихтэй очень ответственный, ~ хүлээхээс цааргалах отказываться от ответственности, ~аас тэнсэн хэвн харгалзаж чөлөөлөх условное освобождение от ответственности

ХАРИУЦЛАГАГҮЙ безответственный, неответственный, безответственно, ~ цалгар назгай байдал халатность

ХАРИУЦЛАГАТАЙ ответственный, ~ эрхлэгч/ажилтан ответственный редактор/работник, ~ даалгаар ответственное задание, ~ цаг үе критический момент

ХАРИУЦЛАГАТАН ответственные, ответственные работники/лица

ХАРИУЦУУЛАХ сделать кого-либо ответственным за что-то, поручить какое-либо дело

ХАРИХ 1. возвращаться, вернуться, гэртээ ~ идти домой обратно, возвращаться домой, нас ~ стареть

ХАРИХ 2. обратный, возвращающийся, ~ урвал обратимая реакция

ХАРЛАХ чернеть, становиться чёрным, дотор ~ чувствовать тяжесть под ложечкой

ХАРМААЛАХ класть в карман

ХАРТАЙ 1) подозрительный, недоверчивый, осторожный, 2) ревнивый

ХАРУЙ: ~ бүрий сумерки

ХАРУУЛ 1. рубанок, ~аар банз харууддах строгать доску рубанком, ~ын хэл язычок рубанка

ХАРУУЛ 2. 1) караул, стража, дозор, охрана, 2) караульный, хүндэт ~ почётный караул, ~д зогсох стоять в карауле, нести караул, ~ солих сменять караул, ~ын алба караульная служба, ~ын байр караульная будка, караульное помещенне, зэвсэгт ~ вооруженная охрана, ~ маная дозор, караул, ~ манаянаас оргосон гэмт хэрэгтэн преступник, бежавший из под стражи

ХАРУУЛАХ 1) показывать, заставлять смотреть, 2) направлять, помещать в каком-нибудь направлении, уруу нь ~ перевертывать, поворачивать

ХАРУУЛДАС стружка, царсны ~ дубовые стружки

ХАРУУЛДАХ 1. ожидать, сторожить, поджидать, өдөржингөө ~ ждать кого-либо целый день

ХАРУУЛДАХ 2. падать вниз лицом, упасть на живот

ХАРУУЛДАХ 3. строгать рубанком, банз ~ строгать доску, ~ суурь машини строгальный станок

ХАРУУЛДАХ 4. наблюдать, следить за чьими-либо действиями, выслеживать кого-либо

ХАРХ: заарт ~ зоол. оидатра, заарт ~н/~ын арьсан малгай шапка из оидатры, оидатровая шапка

ХАРХАН чёрный, ~ нүд чёрные глазки, очи чёрные

ХАРХҮҮ разг. молодой мужчина, молодой человек, малый, багш ~ молоденький учитель

ХАРЦ 1. взгляд, взор, зөөлөн/ширүүн ~ нежный/суровый взгляд, хорсолтой муухай ~ свирепый, враждебный взгляд, ~ тусгах бросить взгляд, ~аа чиглүүлэх направить взгляд, взор, ~аа тогтоох приковать взгляд

ХАРЦ 2. простололин, смерд

ХАРЦАГА поясница, ~ны бүлэг яс отдел поясничный, ~ны нерв нерв крестовый

ХАРЧУУД (харчуул) простые граждане, простолодины

ХАРШ 1. дворец, особняк, 30-р харш особняк N30

ХАРШ 2. 1) чуждый, враждебный, 2) несовместимый, противоположный, анти-, ~ үзэл суртал враждебная идеология, хуулинд ~ противозаконный, незаконный, шинжлэх ухаанд ~ антинаучный

ХАРШИЛ мед. аллергия, аллергический, ~ өвчин аллергическое заболевание, ~ үүсэл аллерген, ~ эмзэглэл аллергия

ХАРШИХ 1. не соответствовать, хуульд ~ противоречить закону

ХАРШИХ 2, истощаться, искудаты

ХАРШИХ 3. стукаться, ударяться друг о друга

ХАРШЛАХ быть чуждым, оказываться враждебным, быть несо-вместимым, быть противоположным, быть протнвопоказанным, вызывать аллергию

ХАРЬ 1. чужой, чуждый, иноземный, ~ газар чужая земля/страна, чужбина, ~ гаригийнхан инопланетяне, ~ийн булаан эзлэгчид иностранные захватчики

ХАРЬ 2. сачок (для ловли рыбы)

ХАРЬЦАНГУЙ 1) относительный, сравнительный, 2) относительно, сравнительно, ~ үнэн относительная правда/истина, ~н онол теория относительности, ~ бага сравнительно мало/меньше, ~ олонхи относительное большинство

ХАРЬЦАХ относиться, обращаться, эелдэг ~ вежливо относиться

ХАРЬЦУУЛАЛ сравнение

ХАРЬЦУУЛАЛТ сравнение, сопоставление, ~ хийх провести сопоставление

ХАРЬЦУУЛАХ сравнивать, сопоставлять, ~сан арга сравнительный метод

ХАРЬЯА подчинённый, подведомственный, находящийся в ведении

ХАРЬЯАЛАГДАХ страд. от харьяалах, быть подведомственным, подчинённым, подчиняться, находиться в подчинении

ХАРЬЯАЛАЛ гражданство, принадлежности

ХАРЬЯАЛАЛГҮЙ без гражданства, ~ этгээд лицо без гражданства

ХАРЬЯАЛАХ иметь отношение, ведать, ~ын тийн ялгал грам. родительный падеж

ХАРЬЯАТ 1) подданный, подданство, 2) подчинённый, гадаадын ~ иностранный подданный, ~ болох приобрести гражданство, ~аа сонгох выбор гражданства, гадаадын иргэнд ~ын эрх олгох давать права гражданства иностранцу

ХАС 1. яшма

ХАС 2. внутренняя сторона бедра

ХАС 3.: ~ хатуур цэцэг бот. тубероза

ХАС 4.: ~ тэмдэг свастика

ХАСАГ 1. казах, казахский

ХАСАГ 2.: ~ тэрэг повозка-одноколка

ХАСАГДАХ страд. от хасах, быть лишённым чего-либо

ХАСАХ 1. 1) убавлять, уменьшать, сокращать, 2) вычитать, отнимать, урезывать, 3) исключать, отчислять, 4) лишать, хурд ~ сбавлять скорость, эрхийг ~ лишать кого-либо прав, урлдаанаас ~ снимать (дисквалифицировать) с соревнований

ХАСАХ 2. 1) отрицательный, 2) минус, вычитание, ~ тоо отрицательное число, ~ тэмдэг знак вычитания, ~ үйлдэл хийх произ-вести вычитание

ХАТААГУУР сушилка, фен

ХАТААГЧ сушилка, сушильня, сушильный, ~ багаж сушильный аппарат

ХАТААЛГА сушилка, сушение

ХАТААЛГ 1) сушение, сушка, 2) *тех.* закалка
ХАТААМАЛ сушёный, высушенный, просушенный, ~ *цэцэг* засушенные цветы
ХАТААХ 1. сушить, высушивать, *өвс* ~ сушить сено, ~ *сай талх* сахар
ХАТААХ 2. закаливать, *болд* ~ закалить сталь
ХАТАВЧ решётчатый стык стены и двери у юрты
ХАТАГТАЙ дама, госпожа, мадам, *ноёд* ~ *нар аа!* Дамы и господа!
ХАТАН 1. ханша, царица, княгиня, *ноёны* ~ супруга ноёна, ~ *хаан* королева, *цог жанхлант* ~ *хаан* её величество королева, ~ *зөгий* пчеломатка, ~ *тоть* самка попугая, ~ *сүйх* орнамент «дамские серьги»
ХАТАН 2. крепкий, твёрдый, закалённый, ~ *төмөр* закалённое железо, ~ *зориг* неустрашимая воля
ХАТАН 3.: *уян* ~ упругий, гибкий, эластичный
ХАТАНГИ подсохший, сухой, высохший, исхудавший, ~ *мал* истощённый скот
ХАТАНГИР истощённый, чахлый, сухой, исхудалый, засохший, ~ *эрхтэн* атрофированный орган
ХАТИНГАРТАХ исхудать, истощаться, высохнуть
ХАТАНХАЙ художавый, исхудалый, тощий, чахлый
ХАТАХ сохнуть, засыхать, высыхать, пересыхать, увядать, исхудать, чахнуть, атрофироваться, *өвчинд* ~ сохнуть от болезни
ХАТГАА *мед.* воспаление, пневмония, колющая боль, ~ *авах* заболеть пневмонией
ХАТГААС подстрекательство, провокация, побуждение
ХАТГАГЧ 1. колющий
ХАТГАГЧ 2.: *өдөөн* ~ подстрекатель
ХАТГАЛГАА воспаление, пневмония, колющая боль, *уушгины* ~ воспаление лёгких, пневмония
ХАТГАЛГА подстрекательство, *өдөөн* ~ провокация
ХАТГАМАЛ 1) вышивание, вышивка, 2) вышитый, ~ *оёх* заниматься вышивкой, ~ *цэцэг* вышитые цветы
ХАТГАМАЛЧ вышивальщица
ХАТГАХ 1. 1) колоть, уколоть, 2) кусать, жалить, 3) втыкать, вонзать, водружать, *зүүгээр гарaa* ~ уколоть руку иглой, *туг* ~ водрузить знамя
ХАТГАХ 2. вышивать, *угалз* ~ вышивать узор
ХАТГАХ 3. подстрекать, инспирировать, *өдөөн* ~ подстрекать
ХАТГАХ 4.: *хаяа* ~ *ж суух* жить бок о бок
ХАТГИ фурункул, чирей
ХАТГИН (хатагин) одно из монгольских племён
ХАТГИТАХ страдать фурункулезом, появляться (о множестве фурункулов)
ХАТГУУР 1. подсвечник, *лааны* ~ подсвечник
ХАТГУУР 2.: *үсний* ~ шпилька
ХАТИГ фурункул, чирей
ХАТИР рысь, ~ *тай морь* рысак
ХАТИРАХ 1) бежать рысью, рысить, 2) танцевать
ХАТИРЧ рысистый, ~ *морь* рысистая лошадь, рысак
ХАТМАЛ сухой, затвердевший
ХАРЬЦАА 1) отношение, связь, 2) соотношение, пропорция, *үйлдэр* сухая трава, сухое сено
ХАТУУ 1) твёрдый, крепкий, прочный, жёсткий, твёрдо, крепко, прочно, жёстко, 2) суровый, строгий, жестокий, сурово, строго, жестоко, ~ *боллого* твёрдая, жесткая политнка, ~ *хөрс/газар* твёрдая земля, твёрдый грунт, ~ *хавтас* твёрдый переплёт, ~ *сэтгэл* жестокое, суровое сердце, ~ *итгэл* твёрдая уверенность, ~ *сануулга* серьёзное предупреждение, ~ *шийдвэр* твёрдое решение, ~ *үгэмшил* твёрдое убеждение, ~ *үг* суровое слово, ~ *шалгалт* суровое испытание, ~ *хууль* суровый закон, ~

шийтгэл/арга хэмжээ суровые наказания/меры, ~ *үнэ* твёрдая цена, ~ *архи*, ~ *ус* крепкая водка, водка, ~ *вагон* жёсткий вагон, *амьдралын* ~ *сургууль* туулах пройти суровую жизненную школу, ~ *чихтэй* тугой на ухо, ~ *хэтүү юм* золото и другие драгоценности, ~ *биеийн физик* физика твёрдых тел
ХАТУУДАХ 1) быть слишком твёрдым, оказываться чересчур крепким, 2) *перен.* быть очень суровым, строгим, жестоким, *шийтгэл нь арай* ~ *жээ* наказание оказалось чересчур суровым
ХАТУУЖИЛ закалка, стойкость, выносливость, закалённость, *үзэл суртлын* ~ идейная закалка, *тэсвэр* ~ *гаргах* проявить стойкость
ХАТУУЖИЛГҮЙ невыносливый, нестойкий, нетерпеливый
ХАТУУЖИЛГАЙ выносливый, стойкий, терпеливый
ХАТУУЖИХ закаляться, делаться закалённым, стать выносливым, *тэмцэлд* ~ закаляться в борьбе
ХАТУУЛГА крепление, подпора
ХАТУУЛАХ 1) крепить, крепчать, укреплять, делать прочным, 2) относиться к кому-либо строго, проявлять требовательность, усаливать нажим, притеснять кого-либо
ХАТУУРАЛ затвердение, отвердение, окостнение, *судасны* ~ *мед.* склероз сосудов, а.еросклеротические изменения сосудов
ХАТУУРАЛТ затвердение, отвердение, окостнение, уплотнение
ХАТУУРАХ 1) твердеть, становиться твёрдым, отвердевать, 2) делаться строгим, стать суровым
ХАТУУРХАГ довольно строгий, слишком суровый
ХАТУУРХАХ быть суровым, оказываться строгим, быть довольно требовательным, ожесточаться
ХАХАХ 1) подавиться, поперхнуться, 2) *перен.* тесниться, напираться, давить друг друга в тесноте, *утаанд* ~ *ж цацах* задыхаться от дыма, ~ *сай дээр нь нудрах* доканать кого-либо, подтолкнуть падающего
ХАХИНАХ скрипеть, издавать скрип, *үүд* ~ *в* дверь заскрипела
ХАХИР 1) суровый, резкий, тяжёлый, скудный, 2) скрипучий, ~ *муухай дуугарах* говорить резким скрипучим голосом, ~ *газар* каменистый, твёрдый грунт, каменистая твёрдая земля, ~ *хүйтэн* чертовский холод
ХАХИРДАХ 1) быть резким, скрипучим, 2) быть скудным, твёрдым (о земле)
ХАХУУЛЬ взятка, подкуп, коррупция, ~ *өгөх* дать взятку, ~ *авах* брать взятку, ~ *авагч* взяточник, ~ *д идэгдэх* продажность
ХАХУУЛЬДАХ подкупать, корруптировать, давать взятку
ХАЦАР щека, *хоёр* ~ *ыг үнсэх* поцеловать в обе щеки, ~ *руу нь алгадах* дать пощёчину, *улаан* ~ *тай өхн* краснощёкая девочка, девочка с румяными щеками
ХАЦАРЛАХ замерзать по краям (о реке)
ХАЧИГ клец, ~ *шиг наадах* впитаться как клец
ХАЧИН интересный, необыкновенный, странный, ~ *хүн* странный человек, ~ *явдал* интересный случай, ~ *сонин* очень интересный, ~ *санагдах* казаться странным, ~ *марзан хүн* «ну и фрукт!»
ХАЧИР гарнир, *байцаан* ~ *тай шарсан мах* жареное мясо с гарниром из капусты, ~ *тай талх* сэндвич
ХАЧИРЛАХ 1) снабжать гарниром, приправлять блюдо гарнирами, 2) *перен.* дополнять, приукрашивать, приправлять
ХАЧИРХАЛ изумление, удивление, странность, ~ *төрүүлэх* вызывать изумление
ХАЧИРХАХ дивиться, удивляться, изумляться
ХАШ 1) яшма, яшмовый, 2) нефрит, ~ *хөөрөг* твабакерка из яшмы, ~ *хайрцаг* яшмовая шкатулка
ХАШАА забор, загон, ограда, изгородь, двор, *малын* ~ загон для скота, *мал* ~ *нд хаших* загонять скот в загон, ~ *нд тоглох* играть во дворе

ХАШААЛАХ огораживать, обносить забором
ХАШГИРАЛДААН крик, крики, вопли
ХАШГИРАЛДАХ кричать (о большом количестве людей)
ХАШГИРАХ кричать, вопить, орать, байдгаараа ~ орать во всё горло, өвдсөндөө ~ кричать от боли
ХАШГИЧАА крикливый, сварливый, ~ хүн крикун
ХАШИЛТ кавычки, ~ нээх открыты кавычки, үг ~д авах взять слово в кавычки
ХАШИР бывалый, опытный, ~ хүн опытный человек, ~ малчин опытный скотовод, ~ суух набираться опыта, становиться опытным
ХАШИРЛАХ осторожничать, проявлять осторожность, хэт ~ / ~сны хэрэгтэй не надо чрезмерно осторожничать
ХАШИХ 1) загораживать, преграждать, огораживать, окружать, загонять, 2) держать, ннкуда не пускать, мал хашаанд ~ загнать скот во двор, алба ~ нести службу, служить
ХАШЛАГА 1. сруб, худгийн ~ колодезный сруб
ХАШЛАГА 2. преграда, ~ далан запруда, плотина
ХАШРААХ *побуд.* от хашрах, проучивать, отучать, надоедать, зүтгүй хүүхдийг ~ проучить озорника, шалуна
ХАШРАХ получать отвращение к чему-либо, прнскучивать, знать что-либо по собственному опыту, быть наученным горьким опытом
ХАЯА край, нижний край, нижняя часть, окраина, гэрийн ~ место стыка стены и пола в юрте, нижние края стены, тэнгэрийн ~ горизонт, небосклон, ~ хот пригород, город-спутник, ~ хатгаж буух/суух жить стена в стену, жить бок о бок, жить совсем рядом, ~ уулс предгорье, ~ гаа манах быть начеку, ~ гаа хадрах разорить своих соседей
ХАЯГ адрес, вывеска, гэрийн ~ домашний адрес, түр/байнгын ~ временный/постоянный адрес, буцах ~ обратный адрес
ХАЯГДАЛ отбросы, утиль, очистки, үйлдвэрийн ~ производственные отбросы, ~ төмөр металлолом, ~ цаас макулатура, ~ түүхий эд утиль сырьё, ~ цуглуулах собирать утиль/утиль-сырьё, ~ын агуулах хвостохранилище
ХАЯГДАХ теряться, быть потерянным, быть покинутым, быть брошенным
ХАЯГЛАХ адресовать, посылать по адресу, захиа ~ адресовать письмо
ХАЯЛГААР горизонталь, гадаргын ~ горизонталь рельефа
ХАЯЛТ бросание, ажил ~ забастовка, стачка, суугаа ажил ~ сидячая забастовка, итальянская забастовка, ажил ~ зарлах объявить забастовку
ХАЯЛЦАА: үнэ ~ аукцион, торги
ХАЯЛЦАХ *совм.* от хаях, перебрасываться, бросаться, үнэ ~ худалдаа продажа с аукциона/с торгов
ХАЯХ 1) бросать, кидать, выбрасывать, 2) покидать, 3) терять, 4) переставать, бросать, чулуу ~ бросать камни, тамхиа ~ бросить курить, сургуулиа ~ бросить учёбу, цонхоор гаргаж ~ выбросить через окно, шүлс ~ сплунуть, Цэвлээ нөхрөө ~д явчихсан Цэвлээ бросила своего мужа
ХИАМ колбаса, колбаска, колбасный, чанасан/утсан ~ варёная/копчёная колбаса
ХИАРАХ гибнуть, погибать (массами), массовая гибель, ~гал хядах поголовно истреблять/уничтожать/убивать
ХИВС ковёр, ковровый, ~ний үйлдвэр ковровая фабрика, ~ цэвэрлэх чистить ковёр
ХИВЭГ мякина, высевка, отруби, ~ тэжээл мякинный/отрубный корм
ХИЖИГ тиф, эпидемия, гэдэсний ~ тусах/халдах заболеть/заразиться брюшным тифом
ХИЖИГТЭХ болеть тифом, болеть эпидемией

ХИЖЭЭЛ пожилой, немолодой, ~ эмэгтэй пожилая женщина
ХИЙ 1) воздух, газ, 2) зря, напрасно, впустую, бессодержательный, пустой, агаарын ~ атмосфера, ~ дамжуулах хоолой газопровод, ~н хуримтлал запасы газа, ~н зуух газовая плита, ~ дэмий зря, напрасно, ~ чалчаа пуста болтовня, ~морь доройтох терпеть неудачи, ~морно сэргээх подиать себе иа-строенне, развяться, ~ мөрөөдөл пустые мечты, ~ ханналга сухой кашель, ~ буудах а) стрелять вхолостую, б) стрелять в воздух, ~ мөргөх получать добавочное очко (о борцах)
ХИЙГҮЙ 1) безвоздушный, вакуумный, 2) безошибочный, безукоризненный, безупречный, безошибочно, безукоризненно, безупречно, 3) тесный, близкий, тесно, близко, ~ хүн ненне, клевета, ~ээр шүүх незаконно судить кого-либо, ложно обвинить кого-нибудь
ХИЙД монастырь, монастырский, ~ний амьдрал монастырская жизнь
ХИЙДҮҮЛЭХ *побуд.* от хийдэх, 1) пропускать, не являться, прогуливать, 2) пользоваться случаем, ажил ~ не явиться/не выйти на работу, прогулять работу
ХИЙДЭЛ *юр.* пробел
ХИЙДЭХ 1) остываться незаметным/неиспользованным, оказываться нн там, нн сям, 2) оставаться без прнмотра, вне поля зрения
ХИЙЖИХ наполняться воздухом, газироваться
ХИЙЖҮҮЛЭЛТ газирование, газировка, наполнение воздухом
ХИЙЖҮҮЛЭХ газировать, насыщать газом, наполнять воздухом, ~сэн ус газированная вода
ХИЙЛ скрипка, ~ хөглөх настроить скрипку, ахмад ~ контрабас, морни ~ виолончель
ХИЙЛГЭХ *побуд.* от хийх, заставлять делать, давать делать, побудить делать, ажил ~ заставлять работать, дать работу, араасаа ~ заниматься сексом в познции «раком»
ХИЙЛДЭХ играть на скрипке
ХИЙЛЧ скрипач, нэртэй ~ известный скрипач
ХИЙЛЭХ накачивать воздух, надувать воздухом, наполнять воздухом, дугуй ~ накачивать шнну, велосипедную камеру
ХИЙМОРЬ удача, успех, благополучие, счастье
ХИЙМОРЬГҮЙ неудачливый, несчастный, невезучий
ХИЙМОРЬТОЙ удачливый, счастливый, везучий
ХИЙМЭЛ искусственный, ~ бодис синтетические материалы, ~ торго искусственный шёлк, ~ цэцэг искусственные цветы, ~ шүд зубные протезы, искусственные зубы, ~ үе суулгах эндопротез, дэлхийн ~ дагуул искусственный спутник Земли
ХИЙРХҮҮ нервый, нервозный, истеричный, истерический, ~ хүн нервный человек, истерик
ХИЙРХЭЛ нервозность, истерия, психоз, дайны ~ военный психоз
ХИЙСВЭР 1) абстрактный, отвлечённый, 2) легкомысленный, ветренный, ~ ойлголт, ~ ухагдахуун абстрактное понятие, ~ сэтгэхүй абстрактное мышление, ~ ярих рассуждать отвлечённо, ~ зай араншин фривольное поведение
ХИЙСВЭРДЭХ 1) быть абстрактным, быть довольно отвлечённым, 2) быть слишком легкомысленным
ХИЙСВЭРЛЭЛ абстрагирование, абстракция, отвлечение
ХИЙСВЭРЛЭХ 1) абстрагировать, отвлекать, 2) быть ветренным/легкомысленным, ~н сэтгэх мыслить абстрактно
ХИЙСГЭХ развеивать, рассеивать, сдувать, пускать по ветру
ХИЙСЭХ развеиваться, реять, нестись, носиться (по воздуху), салхинд ~ развеиваться по ветру, нестись по ветру
ХИЙТЭЙ 1) наполненный воздухом, 2) нанвный, неосторожный, 3) истеричный, безумный, помешанный

ХИЙХ 1) делать, производить, 2) класть, наливать, 3) носить, та юу ~ж байна? что вы делаете? **ажил** ~ работать, **дасгал** ~ делать упражнение, **дадлага** ~ проходить практику, практиковаться, **илтгэл** ~ делать доклад, **алдаа** ~ делать/допускать ошибку, **яриа** ~ проводить беседу, **гэрээ хэлэлцээр** ~ заключать договор/соглашение, **айлчлал** ~ нанести визит, посетить с визитом, делать визит, **хүлээн авалт** ~ устраивать приём, **тооцоо** ~ производить расчёт, делать расчёт, **засвар** ~ делать ремонт, ремонтировать, **хоол** ~ готовить обед, **ан** ~ охотиться, **аялал** ~ организовать/совершить экскурсию, **тус** ~ помогать, **саад** ~ препятствовать, **анганд цай** ~ наливать в чашку чай, **давс** ~ солить, положить соль, ~вэл бүү ай, **айвал бүү хий** сделал — не бойся, боишься — не делай

ХИЙЦ 1. 1) конструкция, устройство, 2) оформление, внешний вид, фасон, мода, **хувцасны** ~ мода одежды, ~ эдлэхүүн компонент, часть конструкции

ХИЙЦ 2. продукты питания, съестные припасы, **аяганы** ~ авах взять с собой продукты на дорогу

ХИЙЦ 3. специальные приправы в чай, ~тэй цай чай заправленный мукой или рисом/просом, слегка поджаренным в масле или на сале

ХИЛ граница, рубеж, **улсын** ~ государственная граница, ~ийн шон пограничный столб, ~ийн овоо пограничный знак, ~ийн харуул пограничный караул, пограничная охрана, ~ийн боомт пограничная застава, пограничный пост, ~ийн шугам пограничная линия, ~ийн будлиан пограничный инцидент, ~ийн цаана суух жийтэ за границей, ~гүй эмч нар (~ хязгаарыг үл хайхрагч эмч нарын нийгэмлэг) «врачи без границ», ~ийн чанадаас илгээх послать из-за границы, ~ нийлэх/залгах граничить, ~ нэвтрэх/давах перейти границу, ~ зөрчих нарушить границу, ~ орчмын нутаг приграничный район, местность, ~ийн дэглэм пограничный режим, ~ийн шалган өнгөрүүлэх газар пограничный контрольно-пропускной пункт (КПП), ~ зааг геол. граница, ~ таталт околтуривание

ХИЛЛЭХ граничить, проводить границу, **Монгол улс урдуураа Хятадтай** ~дэг Монголия на юге граничит с Китаем

ХИЛС ложный, несправедливый, клеветнический, ложно, несправедливо, клеветнически

ХИЛСДҮҮЛЭХ *побуд.* от хилсдэх, обвинять, осуждать несправедливо, подвергать ложному обвинению, клеветать

ХИЛСДЭХ быть оклеветанным, подвергаться ложному обвинению

ХИЛСДЭХГҮЙ не будет преувеличение (сказать), **бараг л юу ч хийгээгүй гэж үзэхэд** ~ не погрешим против истины, если скажем, что ничего не сделано

ХИЛЧИН пограничник

ХИЛЭГНЭЛ вспышка гнева, возмущение, негодование

ХИЛЭГНЭХ гневаться, сердиться, возмущаться

ХИЛЭМ осётр, **шивэр** ~ сибирский осётр.

ХИЛЭН 1. гнев, ярость, **уур** ~ *нарн.* гнев, **уур** ~ **бадрах** прийти в ярость

ХИЛЭН 2. бархат, вельвет, бархатный, вельветовый

ХИЛЭН 3. носорог

ХИЛЭНЦ грех, **нүгэл** ~ *нарн.* грех, грехи

ХИЛЭНЦЭТ грешный, греховный, ~ **аалз**, ~ **хорхой** скорпион, ~ийн орд созвездие Скорпиона

ХИМИ химия, химический

ХИМИЖИХ химизировать

ХИМИЖҮҮЛЭЛТ химизация

ХИМИЖҮҮЛЭХ химизировать

ХИМИЧ химик

ХИМЛЭХ обгладывать, обгрызать, **яс** ~ обгрызть кости

ХИНШҮҮ гарь, горелое, ~ **үнэртэнэ** пахнет гарью

ХИР 1. 1) мера, предел, способность, возможность, 2) около, приблизительно, 3) как, каким образом, в какой степени, ~ **хэмжээ** мера, предел, возможность, **чадлын** ~ээр хийх делать в меру своих возможностей, по мере своих сил, ~ээ мэдэх знать свою меру/свои силы, ~ээ мэдэхгүй умеющий оценить свои возможности, переоценивающий свои силы, **үдийн** ~д к полудню, **нэг жил** ~ около одного года, приблизительно один год, **аль** ~, ~ **зэрэг** как, в какой мере, в какой степени, **таны бие** ~ **зэрэг байна?** как вы себя чувствуете? **чадлынхаа** ~ээр по мере сил, **мнний** ~тэй ростом с меня, ~ийн хүн заурядный человек, ~ **баргийн** обыкновенный, заурядный

ХИР 2. грязь, ~тэй хувцас грязное бельё, ~ **болох** становится грязным, загрязняется

ХИРГҮЙ 1) чистый, незагрязнённый, свободный от грязи, 2) *перен.* чистый, беспорочный, непорочный, ~ **дотуур хувцас** чистое бельё, ~ **сэтгэл** чистая душа, честность, непорочность

ХИРДХИЙХ вздрагивать, ужасаться, прийти в ужас, страшиться
ХИРТЭЙ 1) грязный, загрязнённый, испачканный, 2) приблизительный, соразмерный, приблизительно, около, **онгоцоор цаг** ~ **ни** эх лētu один час, **нуруугаар чиний** ~ ростом с тебя, ~ **бай!** веди себя в меру свою! знай свою меру! веди себя порядочно!

ХИРТҮҮЛЭХ *побуд.* от хиртэх, делать грязным, запачкать, испачкать

ХИРТЭЛТ 1) затмение, 2) загрязнение, **нарны/сарны** ~ солнечное/лунное затмение, **бүтэн/хагас** ~ полное/частичное затмение

ХИРТЭХ 1) загрязняться, пачкаться, делаться грязным, стать грязным, 2) затмение, **нар** ~эн жил год затмения солнца

ХИЧНЭЭН сколько, какой, как, ~ **удаан?** сколь долго? ~ **сонин** гээч! ух, как интересно!

ХИЧЭЭЛ 1. старание, усердие, прилежание, активность

ХИЧЭЭЛ 2. занятие, урок, **монгол хэлний** ~ уроки монгольского языка, ~ **хийх** проводить/давать урок, ~ **давтах** повторить урок, ~ **таслах** пропускать уроки, ~ийн жил учебный год, ~ийн хуваарь расписание уроков, ~ийн төлөвлөгөө учебный план

ХИЧЭЭЛЛЭХ заниматься, учиться, **спортоор** ~ заниматься спортом

ХИЧЭЭНГҮЙ старательный, аккуратный, ~ **үсэг** каллиграфическое письмо

ХИЧЭЭНГҮЙЛЭХ усердствовать, быть старательным, оказываться прилежным

ХИЧЭЭХ стараться, пытаться, **байдгаараа** ~ стараться изо всех сил, **хувийн ашиг** ~ преследовать личную выгоду, ~и мэрийх проявлять усердие

ХИШИГ 1. дары, милости, щедроты, счастье, благополучие, благо, ~ **буян**, **буян** ~ *нарн.* милости, милостыня, ~ **хүртэх** удаваться милости, **байгалийн** ~ дары природы

ХИШИГ 2. 1) воскресенье, 2) смена, очередь, **өнөөдөр манай хонины** ~ сегодня наша очередь пасти овец, сегодня день нашего выпаса овец

ХЛОР хлор, ~т **кальци** хлористый кальций

ХОВ 1. *частича усиления к словам с начальным:* хо-, ~ **хоосон** совершенно пустой, ~ **хол** совсем далеко, очень далеко

ХОВ 2. клеюза, сплетня, ~ **жив нарн.** ябеда, сплетни, ~ **зөөх** ябедничать, клеюзначать, распространять сплетни

ХОВДОГ жадный, алчный, ненасытный

ХОВДОГЛОХ жадничать, быть алчным, ненасытным

ХОВИЛ желобок, паз, канавка, борозда, ~ **гаргах** сделать желобок

ХОВЛОХ 1) сплетничать, ябедничать, клеюзначать, 2) доносить, жаловаться, **хамт олны дотор** ~дог ганц хоёр хүн дандаа **байдаг** в коллективе всегда есть один-два клеючника

ХОВОР 1) редкий, уникальный, дефицитный, редкостный, 2) скудный, редкий, бедный, ~ **ном** редкая книга, ~ **амьтан** редкое животное, ~ **наидин** эд уникальная вещь, **өдрийн од шнг** ~ очень редкий, весьма уникальный, **маш** ~ очень редко, **тэр ч ёстой** ~ **бүсгүй шүү** это действительно редкая девушка

ХОВОРХОН довольно редкий, дефицитный, ~ **сайхан бөгж** кольцо редкой красоты

ХОВОРДОЛ(т) сильное сокращение/уменьшение кого-, чего-либо, нехватка, дефицит

ХОВОРДОХ стать редкостью, делаться редким, сильно сокращаться/уменьшаться, становиться дефицитным, быть в дефиците, скудеть, **Дашбалбарын ном их** ~ **жээ** книги Дашбалбара стали библиографической редкостью, **зарим ан амьтад нэлээд** ~ **ж байна** количество некоторых видов диких животных сильно сокращается

ХОВХЛОХ сбивать, сдирать, отдирать, отделять, вырывать, отрывать

ХОВХРОХ отдираться, отделяться, отлетать, срываться, гутлын **зан** ~ **чээ** подмётки отодрались

ХОВЧ сплетник, ябедник, клеветник

ХОГ сор, отбросы, мусор, труха, ~ **тарих/хаях** сорить, мусорить, ~ **ийн сав** мусорный ящик, ~ **хаях нүх** мусорная яма, ~ **ургамал сорняк**, **нийгмийн** ~ **шаар** отребье, отбросы общества

ХОГГУЙ 1) без мусора, 2) без остатка, всё, совсем, совершенно, полностью, ~ **эдгэрэх** полностью вылечиться, стать совершенно здоровым

ХОГТОЙ 1) имеющий мусор, сорный, 2) с остатком, неполностью, с последствиями

ХОГЧ мусорщик, чистильщик мусора

ХОГШИЛ имущество, пожитки, скарб, мебель, инвентарь, **гэрийн** ~ мебель, пожитки

ХОДООД желудок, желудочный, ~ **ны шүүс** желудочный сок, ~ **ны өвчин** желудочные болезни, ~ **ны үрэвсэл** гастрит

